



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨВ

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө 2014 – 2020 он



Улаанбаатар, 2014

АГУУЛГА

0. ХУРААНГУЙ	6
1. ҮНДЭСЛЭЛ	11
1.1. Ажлын зорилго ба үндэслэл	11
1.2. Тогтвортой аялал жуулчлалын зарчим.....	11
1.3. Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн сонирхогч талууд	13
2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	14
2.1. Аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа.....	14
2.2. Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар.....	20
2.3. SWOT шинжилгээ.....	24
3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ	25
3.1. Эрхэм зорилго	25
3.2. Язгуур үнэт зүйлс	25
3.3. Алсын хараа	26
3.4. Хөгжлийн стратеги.....	26
3.5. Ирээдүйн хөгжлийн таамаглал.....	27
4. ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД	30
4.1. Зорих газрын оновчтой засаглалыг хөгжүүлэх, институцын тогтолцоог сайжруулах.....	30
4.2. Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх.....	34
4.3. Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох.....	43
4.4. Зорих газрын дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.....	48
4.5. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих.....	54
4.6. Хүний нөөцийн хөгжил, сургалт, судалгааг хөгжүүлэх.....	62
5. ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ	67
6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	70
7. АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД	84
8. ХАВСРАЛТ	85

ХҮСНЭГТ

- Хүснэгт 1 Тогтвортой хөгжлийн зарчмын шалгуур үзүүлэлтүүд
- Хүснэгт 2 Монголд ирж буй жуулчдын тоо /аяллын зорилгоор/
- Хүснэгт 3 Жуулчид Монголыг сонгож аялсан үндсэн шалтгаан
- Хүснэгт 4 Зах зээлд эзлэх хувь /аймгаар/
- Хүснэгт 5 Хөдөө орон нутаг дахь аялал жуулчлалын байршуулах хэрэгслийн хүчин чадал
- Хүснэгт 6 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй зочид буудлуудын судалгаа
- Хүснэгт 7 Улаанбаатар хотын дэн буудлуудын судалгаа
- Хүснэгт 8 Орон нутгийн нөхөрлөлүүдээс жуулчдын авах үйлчилгээ
- Хүснэгт 9 Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар
- Хүснэгт 10 Монголын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар ба харьцуулалт
- Хүснэгт 11 Монголын аялал жуулчлалын нөхцөл байдлын шинжилгээ
- Хүснэгт 12 Өсөлтийн А хувилбар /бага өсөлт/
- Хүснэгт 13 Өсөлтийн В хувилбар /дунд өсөлт/
- Хүснэгт 14 Өсөлтийн С хувилбар /өндөр өсөлт/
- Хүснэгт 15 Засгийн Газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд
- Хүснэгт 16 Жуулчны баазын өөрсдийн авах арга хэмжээ
- Хүснэгт 17 Зорин очих газрын даацийн үнэлгээ
- Хүснэгт 18 Замын нөхцлийн мэдээлэл
- Хүснэгт 19 Аялал жуулчлалын төрлүүд ба өсөлтийн таамаглал
- Хүснэгт 20 Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой бүтээгдэхүүнүүд
- Хүснэгт 21 Бүтээгдэхүүний хөгжлийн төлөвлөлтийн хуваарь
- Хүснэгт 22 Аялал жуулчлалын салбар дахь хүний нөөцийн эрэлт

ЗУРАГ

- Зураг 1 Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зарчим
- Зураг 2 Монголын аялал жуулчлалын сонирхогч талууд
- Зураг 3 Монголд аялсан жуулчдын тоо 2002 - 2012
- Зураг 4 Монголд аялсан жуулчид /бүс нутгаар/
- Зураг 5 Аяллын гол газруудыг сонгосон байдал
- Зураг 6 Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн стратеги
- Зураг 7 Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээнүүд
- Зураг 8 Монгол улсын ТХГН-ын сүлжээ
- Зураг 9 Аялал жуулчлалын идэвхижүүлэлтэд сошиал медиа ашиглах боломж
- Зураг 10 Монгол улсын замын нөхцлийн үзүүлэлт /өнөөгийн байдал, ирээдүйн төлөв/
- Зураг 11 Монгол улсын замын нөхцлийн мэдээлэл
- Зураг 12 Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн сургалт

ХАВСРАЛТ

- Хавсралт 1 Олон улсын жуулчны ёс зүйн журам
- Хавсралт 2 Аялал жуулчлалын ногоон гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрүүд
- Хавсралт 3 Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд
- Хавсралт 4 Аялал жуулчлалын кластерт суурилсан бүсчилсэн хөгжлийн концепци

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЖ	Аялал жуулчлал
АЖТХТ	Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төв
АЖҮТ	Аялал Жуулчлалын Үндэсний Төв
АЖХЧ	Аялал жуулчлалын хүчин чадал
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХЯ	Байгаль орчин, Ногоон Хөгжлийн Яам
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГХЯ	Гадаад Харилцааны Яам
ДАЖБ	Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДЦГ	Дархан Цаазат Газар
ЗТЯ	Зам Тээврийн Яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАЖХ	Монголын Аялал Жуулчлалын Холбоо
МЗБХ	Монголын Зочид Буудлуудын Холбоо
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
НАЖГ	Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ССАЖЯ	Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яам
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТСАЖ	Тусгай сонирхлын аялал жуулчлал
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
ТХГНУГ	Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Удирдлагын Газар
УБ	Улаанбаатар
УТХГ	Улсын Тусгай Хамгаалалттай Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХЗЯ	Хууль Зүйн Яам
ХЯ	Хөдөлмөрийн Яам
ШУА	Шинжлэх Ухааны Академи
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭЗХЯ	Эдийн Засгийн Хөгжлийн Яам

ХУРААНГУЙ

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний гол зорилго нь Монгол улсад аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх үндсэн зарчмуудыг тодорхойлж, тогтвортой хөгжлийн бодлогын концепцийг үйл ажиллагааны хамт төлөвлөх явдал юм.

- Монголын хувьд аялал жуулчлал нь хөдөө аж ахуй (ДНБ-ний 25 орчим хувь), уул уурхай (ДНБ-ний 20 орчим хувь)-н дараа орох эдийн засгийн гуравдахь чухал салбар болж байна. 2012 оны байдлаар Монгол улсын ДНБ-д аялал жуулчлалын салбарын эзлэх хувь 4%, нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь 13 болсон.
- Монголд ирж байгаа жуулчдыг аяллын зорилгоор ангилж үзэхэд 20 гаруй хувь нь амралт жуулчлалын зорилгоор ирсэн бөгөөд жуулчдын дийлэнх нь Монголын унаган байгаль, нүүдэлчин соёл, Чингис хааны тухай илүү сонирхдог.
- Монгол улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс сүүлийн жилүүдэд сайжирч, Дэлхийн Эдийн засгийн Форумас тодорхойлдог эрэмбэлэлээр дэлхийн 105 улсаас 99-р байранд орсон байна.
- Монголын аялал жуулчлалын нөхцөл байдлын шинжилгээнээс үзэхэд, соёлын болон байгалийн нөөц, нүүдлийн ахуй, зан заншил, өвөрмөц олонд танигдсан түүх зэрэг аялал жуулчлалын үзмэрийн давуу тал олон боловч, дэд бүтцийн хөгжил тааруу, маркетингийн үйл ажиллагааны түвшин сул, улирлын шинж чанартай зэрэг сул талууд аялал жуулчлалын салбарын хөгжилд саад болж байна.
- Монгол улсын тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн эрхэм зорилго нь “байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах замаар нүүдлийн соёл, зан заншлын өлгий нутаг- нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүс нутаг” байхад оршино.
- Монголын аялал жуулчлалын язгуур үнэт зүйлсүүд нь байгаль орчин ба түүх соёлын өвүүд бөгөөд өнөөгийн нийгмийн амьдрал юм.
- Аялал жуулчлалын хөгжлийн алсын харааг дараахь хүснэгтээр тодорхойлов.

Тогтвортой ногоон хөгжил	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд ээлтэй • Газар ашиглалтын цогц шийдэлтэй • Орчны төлөвлөлт бүхий • Байгаль, түүхийн болон орон нутгийн өвийг хадгалж хамгаалсан
Соёл, спортын бүтээгдэхүүнийг байгалийн өвийн нөөцтэй багтаасан багц	<ul style="list-style-type: none"> • Спортын аялал жуулчлал • Нүүдэлчдийн соёл
Тусгай сонирхлын адал явдалт аялал жуулчлалын газар нутаг	<ul style="list-style-type: none"> • Тусгай сонирхолтой зах зээлд чиглэсэн • Эрсдэлгүй, жинхэнэ адал явдал • Байр, сууцны өргөн сонголтууд • Олон улсын стандартын үйлчилгээ
Чанартай дэд бүтэц ба үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Жуулчны мэдээллийн өргөн сүлжээтэй • Хот хооронд зорчих сайн замууд, замын тодорхой тэмдэглэгээ

	<ul style="list-style-type: none"> • Агаарын болон төмөр замын зангилаа бөгөөд дамжин өнгөрөх өргөн бололцоо
Нутгийн иргэдэд түшиглэсэн хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Аяллын бүс нутгийн хамтын ажиллагаа • Нутгийн иргэдийн шууд оролцоо • Орон нутгийн эдийн засгийн хөгжилд бодит дэмжлэг • Нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээний ерөнхий мэдлэг • Зочломтгой малчин ард түмэн

- Тогтвортой аялал жуулчлалын гол зорилгод хүрэх аялал жуулчлалын хөгжлийн үндсэн стратегийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэг. Зорих газрын оновчтой засаглал ба институцийн тогтолцоог сайжруулах


Хоёр. Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх

Гурав. Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох

Дөрөв. Зорих газрын менежмент, дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Тав. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих тус тус болно.

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн стратеги



- Монголыг зорин ирэх жуулчдын хэтийн төлвийг 2021 он хүртэл 3 хувилбараар тооцож үзвэл, дараах байдалтай байна.

ӨСӨЛТИЙН А ХУВИЛБАР

Өсөлтийн А хувилбар /бага өсөлт/

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.6900	35,045	10,864	10,614	10,370	10,131	9,898	9,671	9,448	9,231
Хувийн	299,306	62.9	0.0000	299,306	326,842	356,912	389,748	425,604	464,760	507,518	554,209	605,197
Албан	151,398	31.8	0.0000	151,398	163,510	176,591	190,718	205,975	222,453	240,250	259,470	280,227
Дамжин	2,850	0.6	-0.7500	713	556	433	338	264	206	160	125	98
Бусад	5,597	1.2	-0.7700	1,287	1,017	803	635	501	396	313	247	195
Нийт	475,917			487,748	502,789	545,353	591,808	642,476	697,713	757,911	823,500	894,948

Өнөөдрийг хүртэлх өсөлтийн хурдцийг өмнөх жилүүдийн хэлбэлзлийн дунджаар тооцоход 2020 онд Монгол улс 823500 жуулчин хүлээн авах боломжтой гэсэн тооцоо гарч байна.

Харин өмнөх жилүүдийн өсөлтийн дундаж хурдцийг хэвээр хадгална гэж үзсэн нөхцөлд 2021 онд аялагчдын тоо 1056183 – д хүрэхээр байна.

ӨСӨЛТИЙН В ХУВИЛБАР

Өсөлтийн В хувилбар /дунд өсөлт/

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.02	110,447	107,907	105,425	103,000	100,631	98,317	96,055	93,846	91,687
Хувийн	299,306	62.9	0.09	326,842	356,912	389,747	425,604	464,760	507,518	554,209	605,197	660,875
Албан	151,398	31.8	0.08	163,510	176,591	190,718	205,975	222,453	240,250	259,470	280,227	302,645
Дамжин	2,850	0.6	-0.22	2,223	1,734	1,352	1,055	823	642	501	390	305
Бусад	5,597	1.2	-0.21	4,422	3,493	2,760	2,180	1,722	1,361	1,075	849	671
Нийт	475,917			607,444	646,636	690,002	737,815	790,389	848,086	911,310	980,509	1,056,183


ӨСӨЛТИЙН С ХУВИЛБАР

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, Монгол улсад тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө, Аймаг орон нутгуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг уялдаа холбоотойгоор хэрэгжүүлж чадвал 2021 он гэхэд 1763284 жуулчин хүлээн авах боломжтой.

Өсөлтийн С хувилбар /өндөр өсөлт/

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.0023	112,787	112,528	109,939	107,411	104,940	102,527	100,169	97,865	95,614
Хувийн	299,306	62.9	0.9200	574,668	627,537	685,270	748,315	817,160	892,339	974,434	1,064,082	1,161,978
Албан	151,398	31.8	0.8000	272,516	294,318	317,863	343,292	370,756	400,416	432,449	467,045	504,409
Дамжин	2,850	0.6	-0.0220	2,787	2,174	1,696	1,323	1,032	805	628	490	382
Бусад	5,597	1.2	-0.0210	5,479	4,329	3,420	2,702	2,134	1,686	1,332	1,052	831
Нийт	475,917			968,238	1,040,885	1,118,188	1,203,043	1,296,022	1,397,773	1,509,012	1,630,534	1,763,214

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн концепцийг доорхи зургаар дүрслэн үзүүлэв.



ОРШИЛ

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төв (ТББ)-с профессор, доктор Д.Гансүх, профессор, доктор С.Эрдэнэтуул, доктор Д.Гантөмөр нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон орчин үеийн аялал жуулчлалын судалгаа, төлөвлөгөө боловсруулах арга зүйд үндэслэн Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн Газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэсэн болно.

Энэхүү төлөвлөгөөг олон улсын болон Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн хамгийн сүүлийн үеийн чиг хандлага, статистик тоо баримтанд тулгуурлан тогтвортой хөгжлийн стратеги, бодлогод тулгуурлан Улаанбаатар хотод байрладаг тур операторууд, төр, хувийн хэвшлийн оролцогч талуудын санал, бодлуудыг тусгаж, холбогдох байгууллагуудаас сүүлийн жилүүдэд явуулсан судалгааны дүнг ашигласан юм.

Энэхүү мастер төлөвлөгөөг боловсруулахад бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Соёл, Спорт Аялал Жуулчлалын Яам, судалгааны явцад мэдээлэл, саналаа хуваалцсан холбогдох байгууллагууд, судлаач нар болон нийт хүмүүст гүн талархлаа илэрхийлье.

1. ҮНДЭСЛЭЛ

1.1. Ажлын зорилго ба үндэслэл

Аялал жуулчлалын салбар нь дэлхийн улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, улмаар үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг, үр ашиг нь тодорхой нэгэн хэсэгт бус нийгэм-эдийн засгийн бүхий л салбарт, иргэдэд хүрдэг онцлогтой. Дэлхийн улс орнууд экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар эдийн засгийн өсөлтийг бий болгоход стратегийн чухал салбар нь аялал жуулчлал хэмээн анхаарах болсон өнөө үед Монгол улс ч мөн аялал жуулчлалын салбарын хөгжлийг чухалчлан үзэж байна. Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн **төлөвлөгөөний гол зорилго нь Монгол улсад аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх үндсэн зарчмуудыг үйл ажиллагааны хамтаар тодорхойлоход оршино.**


Үндэслэлүүд:

- 1992 онд болсон НҮБ-ын Байгаль орчин, Хөгжлийн Бага Хурал буюу Рио Де Жанейрогийн Дэлхийн Чуулга Уулзалтаас сайн дурын болон төр засгийн, олон улсын бүхий л хууль тогтоомжоор “ногоон” үйлдвэрлэлийн санаачилгыг дэмжих тухай тунхагласан байна. Дэлхийн Чуулга Уулзалтаас тогтвортой хөгжлийн зарчим, үйл ажиллагааг бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хэрэгжүүлэх тухай Хэлэлцэх Асуудал 21 (**Agenda 21**) тунхаглалыг дэлхийн 182 орны төрийн тэргүүнүүд баталгаажуулсан.
- Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтууд
- Шинэчлэлийн Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, 2012-2016
- Тур оператор, зочлох үйлчилгээний байгууллагуудын олон улсын ногоон санаачилга, хөтөлбөрүүд зэрэг болно.

1.2. Тогтвортой аялал жуулчлалын зарчим

Тогтвортой аялал жуулчлал нь улс орны нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангахыг чухалчилдаг бөгөөд тогтвортой хөгжлийн үндсэн зарчмыг зураг 1 – т үзүүлэв.

Зураг 1. Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн зарчим



Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн үндсэн зарчмууд:

- Эдийн засгийн амьдрах чадвартай байх
- Хөдөлмөр эрхлэлтийн чанар
- Гийчин, жуулчдын сэтгэл ханамж
- Орон нутгийн амьжиргааны түвшин
- Физик бүрэн бүтэн байдал
- Нөөцийн өгөөж
- Нутгийнхний цэцэглэн хөгжил
- Биологийн олон төрөл зүйлүүд
- Онгон байгаль
- Баялаг соёл
- Нийгмийн тэгш байдал
- Орон нутгийнхны хяналт

Тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлж чадаж байгаа эсэхийг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны нөлөөллийн арван шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлдог (хүснэгт 1).

Хүснэгт 1. Тогтвортой хөгжлийн зарчмын шалгуур үзүүлэлтүүд

Эдийн засгийн зорилтууд ба шалгуур үзүүлэлтүүд

- Эдийн засгийн нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болон тодорхойлогдох
- Хамтын ажиллагааг сайжруулж, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн ач холбогдлыг өндөрт тавих
- Орон нутгийнхан аялал жуулчлалын үйл ажиллагаанд өргөнөөр оролцож, ашиг тусыг хүртэх зарчмыг хангах
- Бүтээгдэхүүний хөгжил ба маркетингийн асуудлыг орон нутгийн эдийн засагтай уялдаатай тодорхойлох

Нийгмийн зорилтууд ба шалгуур үзүүлэлтүүд

- Орон нутгийнхны оролцоог төлөвлөлт ба шийдвэр гаргахад хангах
- Нийгмийн нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болон тодорхойлогдох
- Нийгэм-соёлын олон талтбөгөөд төрөлжилтийг хадгалж, хөгжүүлэх

- Орон нутгийн соёлд хүндэтгэлтэй хандах

Хүрээлэн буй орчны буюу байгаль орчны зорилтууд ба шалгуурууд

- Байгаль орчны нөлөөлөл нь аялал жуулчлалын хөгжлийн угтвар нөхцөл болон тодорхойлогдох
- Байгалийн нөөцийг тогтвортой хөгжлийн зарчмаар ашиглаж, хог хаягдлыг багасгах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж таслан зогсоох

Дэлхийн Байгаль орчин, Хөгжлийн Комиссоос /The World Commission on Environment and Development/ **“тогтвортой хөгжил гэж ирээдүй үеийнхний эрэлт хэрэгцээгээ хангах чадвартай уялдуулан одоогийн эрэлт хэрэгцээний дагуу дэвшин хөгжих хэлбэр”** хэмээн томъёолжээ. Тогтвортой хөгжлийн зарчим нь зөвхөн байгаль орчны төдийгүй нийгэм, эдийн засгийн нөлөөллийг харгалзан үзэхэд оршино. НҮБ-ын ДАЖБ-аас “тогтвортой аялал жуулчлал нь зочин гийчин, аялал жуулчлалын салбарынхан, орон нутгийн болон газар орны эрэлт хэрэгцээнд тулгуурлан байгаль орчин, нийгэм, эдийн засагт эерэг таатай нөлөөлөл авчрах аялал жуулчлал” хэмээн тодорхойлсон байна.

Монгол улсад аялах гадаад, дотоодын жуулчны тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, улмаар шинэ эрэлт хэрэгцээ бий болж байгаатай уялдуулан аялал жуулчлалд оролцогч талуудын харилцааг байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэйгээр зохицуулан хөгжүүлэхэд төрийн бодлого, тогтвортой аялал жуулчлалын төлөвлөлт чухал шаардлагатай байна.

1.3. Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн сонирхогч талууд

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах зорилгоор одоогийн нөхцөл байдлын талаар авч үзэхэд үндсэн сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг тодорхойлох нь чухал билээ. Ингэснээр холбогдох үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлэхэд талуудын сонирхол, эрэлт хэрэгцээнд тохирохуйц үр дүнтэй байх болно.

Үндсэн сонирхогч талууд бол тур оператор, агентууд, хөтгүүд, жолооч нар, байр, хоол ундаа, амралт, чөлөөт цагийн үйлчилгээгээр хангагчид, тээврийн компаниуд, төрийн ба төрийн бус байгууллагууд болон доорхи зурагт үзүүлсэнчлэн зочлогчидтой харьцах нутгийн хүмүүс юм.



Гол сонирхогч талуудын оролцоо, хүлээх хариуцлага болон хамтын ажиллагааны чиглэлүүдийг Тогтвортой аялал жуулчлалын энэхүү төлөвлөгөөг боловсруулахад тусган авч үзсэн болно.

2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


2.1. Аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа

Өнөөдөр аялал жуулчлалын салбар нь дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 10 хувь, худалдаа үйлчилгээний 30 хувь, хөрөнгө оруулалтын 7 хувь, хэрэглээний зардлын 11 хувь, татварын орлогын 5 хувь, экспортын 10 хувийг эзэлж байна [14]. Эдийн засгийн утгаар нь авч үзвэл дэлхийн эдийн засаг, мөнгөний эргэлтийг хөдөлгөгч нийгмийн хөдөлгүүр нь аялал жуулчлал болж байна. Нөгөөтэйгүүр аялал жуулчлал нь “ард түмнүүдийн найрамдал, хамтын ажиллагааг идэвхижүүлэгч”, “утаагүй үйлдвэрлэл”, “үл үзэгдэгч экспорт” гэдэг сонгодог утгаараа дэлхий дахинд эрчимтэй хөгжиж байгаа билээ. 2013 онд аялал жуулчлалаас даян дэлхийн эдийн засагт эзлэх хувь 9%-иар өсч, ойролцоогоор 9 их наяд ам.доллар болжээ [16]. Аялал жуулчлал нь өсөлтийн хурдаараа санхүү, бизнесийн үйлчилгээ, бөөний худалдаа, тээвэр зэрэг олон салбаруудаас хол түрүүлсэн байна. Олон улсын аялал жуулчлалд өнгөрсөн онд 4,7 сая шинэ ажлын байр бий болж, нийтдээ 266 сая хүн ажиллаж байгаа нь дэлхийн 11 ажлын байрны нэг юм. Мөн аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт дэлхийн хэмжээнд өмнөх 2012 оноос 2,9 хувиар өссөн байна [17].

Монголын хувьд аялал жуулчлал нь хөдөөажахуй (ДНБ-ний 25 орчим хувь), уулуурхай (ДНБ-ний 20 орчим хувь)-н дараа орох эдийн засгийн гуравдахь чухал салбар болж байна. 2012 оны байдлаар Монгол улсын ДНБ-д аялал жуулчлалын салбарын эзлэх хувь 4%, нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь 13 болсон [17]. 2002 - 2007 оны хооронд Монголд ирсэн аялагчдын тоо жилд дунджаар 15 хувь өссөн бол, 2007 – 2009 оны хооронд дэлхийн эдийн засгийн хямралаас

шалтгаалан буурч, харин 2009 оноос буцаад өссөн бөгөөд 2009 – 2012 оны хооронд жилд дунджаар 10 хувийн өсөлттэй байна (зураг 3) [8].

Зураг 3. Монголд аялсан жуулчдын тоо 2002 - 2012




Аяллын зорилгоор нь авч үзвэл, хувийн ба албан зорилгоор айлчлан ирж байгаа бүлгүүд өсч, харин амралтын аялал жуулчлалаар ирж байгаа бүлэг буураагүй байна (Хүснэгт 2) [8].

Хүснэгт 2. Монголд ирж буй жуулчдын тоо /аяллын зорилгоор/

Монголд ирж буй гадаадын жуулчдын аялалын зорилго (2007-2013)								
Аяллын зорилго	2007	2008	2009	2010	2011	2012	дундаж өсөлт	2012 (%)
Жуулчлал	127,055	103,762	100,039	97,023	111,210	113,047	0.02	19.8
Хувийн	192,553	228,001	181,429	204,501	191,691	299,306	0.11	52.3
Албан	103,992	85,418	89,343	121,978	137,373	151,398	0.16	26.5
Дамжин	9,590	6,103	9,185	5,973	4,287	2,850	-0.12	0.5
Бусад	18,462	23,023	31,644	26,828	12,953	5,597	-0.21	1.0
Нийт	451,652	446,307	411,640	456,303	457,514	572,198	0.07	100.0
Өсөлтийн хувь	-	-1.2	-7.8	10.9	0.3	25.1		

Бүс нутгаар нь авч үзвэл, сүүлийн жилүүдэд Ази Номхон далайн жуулчид дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд цаашид ч энэхүү бүлэг зорилтот зах зээлийн нэг байх бол Европын зах зээл дараах хувийг эзэлж байгааг зураг 4 – өөс харж болно.

Зураг 4. Монголд аялсан жуулчид /бүс нутгаар/



■ Африк ■ Америк ■ Ази Номхон Далай ■ Европ ■ Ойрхи Дорнод ■ Өмнөд Ази ■ Бусад


Монголд ирж байгаа жуулчдыг аяллын зорилгоор ангилж үзэхэд 20 гаруй хувь нь амралт жуулчлалын зорилгоор ирсэн байна [3]. Ирж буй жуулчдын дийлэнх нь Монголын унаган байгаль, нүүдэлчин соёл, Чингис хааны тухай илүү сонирхдог (хүснэгт 3).

Хүснэгт 3. Жуулчид Монголыг сонгож аялсан үндсэн шалтгаан

Монголд зочлох шалтгаан	1998	2004	2005	2012
Үзэсгэлэнт байгаль	66	69	78	61
Зэрлэг ан амьтан	31	25	23	9
Монголын уламжлалт соёл	51	46	60	43
Монголын болон Чингис хааны түүх	27	21	21	11
Адал явдалт аялал	24	26	32	12
Загасчлах			3	2
Ан агнуур	2	1	1	
Тусгай сонирхол	10	9	1	6
Бусад	12	12	1	12

Аялах газар, орон нутгаа сонгох нь багц аяллын хөтөлбөр болон жуулчны зах зээлээс хамааран харилцан адилгүй байгаа ба Европын жуулчид Монголын тур операторуудын сонгодог аяллаар, харин Японы жуулчид Хангайн аяллаар илүү аялжээ (Зураг 5).

Зураг 5. Аяллын гол газруудыг сонгосон байдал



Сүүлийн жилүүдэд Монгол улсад дотоодын аялал жуулчлал хурдацтай хөгжиж байгаа бөгөөд БОНХЯ-ны мэдээгээр 2011 оны байдлаар нийт 200 мянга гаруй дотоодын аялагчид ТХГН-уудад аялсны 71% нь Хан Хэнтийн УТХГ, Богд Хан уулын ДЦГ, Хөвсгөлийн УТХГ-т тус тус аялжээ.

Зах зээлд эзлэх хувь хэмжээг аймгуудаар авч үзвэл, Монголыг зорин ирсэн жуулчид 2 – 3 аймгаар аялдаг болох нь тодорхой байна. Судалгаанаас авч үзвэл, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Төв, Өвөрхангай, Хөвсгөл, Архангай зэрэг аймгууд жуулчны тоогоор тэргүүлж буй (Хүснэгт 4) бөгөөд энэ хандлага ойрын жилүүдэд хэвээр хадгалагдана хэмээн таамаглаж байна [8].

Хүснэгт 4. Зах зээлд эзлэх хувь /аймгаар/

№	Аймаг	Давхацсан дүнгээр /%/	Давхцаагүй дүн /%/
1	Архангай	20	6.8
2	Баян-Өлгий	7	2.4
3	Баянхонгор	12	4.1
4	Булган	7	2.4
5	Говь – Алтай	5	1.7
6	Говьсүмбэр	2	0.7
7	Дархан	2	0.7
8	Дорноговь	30	10.2
9	Дорнод	7	2.4
10	Дундговь	42	14.3

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

11	Завхан	2	0.7
12	Орхон – Уул	2	0.7
13	Өвөрхангай	23	7.8
14	Өмнөговь	60	20.4
15	Сүхбаатар	3	1.0
16	Сэлэнгэ	5	1.7
17	Төв	27	9.2
18	Увс	3	1.0
19	Ховд	4	1.4
20	Хөвсгөл	22	7.5
21	Хэнтий	9	3.1

Одоогийн байдлаар хөдөө орон нутагт аялал жуулчлалын дэд бүтэц буюу байршуулах хэрэгслийн хүчин чадал, үйлчилгээний чанар хангалттай бус байна (Хүснэгт 5).

Аймгуудын аялал жуулчлалын дэд бүтэц										
Аймаг	Зочид буудал	Жуулчны бааз	Дэн буудал	Малчны гэр	Анчны отог	Motel	Рашаан сувилал	hunter's зуслан	Сувилал	Хүчин чадал /Орны тоо/
Архангай	6	23	30	24			2	-	2	1,804
Баян - Өлгий	7	8	-	3	2		3	2	3	800-1,000
Баянхонгор	6	2	1				2		2	300
Булган	30	19	11		4	1	24	4	24	2,000<
Говь - Алтай	3	4	31		1		1	1	1	629
Говьсүмбэр	11	-	-					-	-	149
Дорноговь	32	5	-				3	-	3	500-550
Дорнод	9	4	1					-	-	300-350
Дундговь	4	12	1				1	-	1	670
Завхан	14							-	-	1,050
Орхон	45	-	-				11	-	11	676
Өвөрхангай	16	28	35	18	2		5	2	5	1,500
Өмнөговь	13	22	2	18	2		5	2	5	1,978
Ховд	11	5	2	11	3	2	2	3	2	300
Увс	4	4	2	6	2		2	2	2	100-150
Хөвсгөл	23	50	25		4	3	2	4	2	1,508
Сэлэнгэ	18	16	36		2		2	2	2	2,000
Сүхбаатар	8	5	-				2	-	2	235
Хэнтий	31	12	-					-	-	

Хүснэгт 5. Хөдөө орон нутаг дахь аялал жуулчлалын байршуулах хэрэгслийн хүчин чадал

Нийслэл Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд зэрэг олон улсын сүлжээний зочид буудлууд бий болж, тооны хувьд өсч (Хүснэгт 6) байгаа ч үйлчилгээний чанараар олон улсын стандартын шаардлага хангах буудлууд цөөн байгаа юм.

Хүснэгт 6. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлуудын судалгаа

дүүрэг	зочид буудал												
	2009	2010	өөрчлөлтийн үзүүлэлт		2011	өөрчлөлтийн үзүүлэлт		2012	өөрчлөлтийн үзүүлэлт		2013	өөрчлөлтийн тоо	
			тоо	хувь		тоо	хувь		тоо	хувь		тоо	хувь
Баянгол	98	92	6	-7.1	71	-21	-29	57	-14	-19	119	62	52
Баянзүрх	32	32	0	0	53	21	39	26	-27	-50	66	40	60
Сонгинохайрхан	22	16	6	-27.2	13	-3	-18	11	-2	-15			
Сүхбаатар	38	31	7	-18.5	34	3	0.8	34	0	0	35	1	2.8
Чингэлтэй	17	16	1	-5.9	15	-1	-0.6	17	2	13			
Хан-Уул	9	5	4	-45	12	7	140	9	-3	-25	14	5	35
Налайх	6	4	2	-33.9	4	0	0				23		
Багануур	7	4	3	-42.9	5	1	125	8	3	60	3		
Нийт	229	200			207			162	-41	-20			

Сүүлийн жилүүдэд Монгол улсад аялан ирэх үүргэвчтэй аялагчид жил бүр нэмэгдэж байгаатай уялдан Улаанбаатар хотын дэн буудлууд тодорхой хэмжээнд өсч байгааг 7-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 7. Дэн буудлуудын судалгаа

дүүрэг	дэн буудал									
	2009	2010	Өөрчлөлтийн үзүүлэлт		2011	Өөрчлөлтийн үзүүлэлт		2012	Өөрчлөлтийн үзүүлэлт	
			тоо	хувь		тоо	хувь		тоо	хувь
Баянгол	71	76	5	6.6	73	-3	-3.9	61	-12	-16
Баянзүрх	71	71	0	0	44	-27	61.9	103	59	134
Сонгинохайрхан	20	20	0	0	30	10	33	58	28	93
Сүхбаатар	48	33	15	-31.2	34	1	2.9	34	0	0
Чингэлтэй	33	29	4	-13.2	27	-2	-6.8	33	6	22
Хан-Уул	16	16	0	0	8	-8	-50	11	3	37
Налайх	2	2	0	0	2	0	0			
Багануур	2	2	0	0	2	0	0	0	-2	-100
Нийт	263	249			220			300	82	37

Аялал жуулчлалын салбар нь ойролцоогоор 24.500 ажлын байрыг шууд (хөдөлмөрийн зах зээлийн 3 хувь), 81000 ажлын байрыг шууд бусаар (нийт ажиллагсадын бараг 7.1 орчим хувь) бий болгож байна [17].

Олон улсын жуулчдын дунд явуулсан санал асуулгын судалгааны дүнгээс үзэхэд, Монголд аялан саатаж байгаа нэг жуулчны хувийн нэг өдрийн дундаж мөнгөн зарцуулалт:

- Багц аяллын жуулчин- **190 ам.доллар**
- Бие даан аялагчид- **120 ам.доллар**
- Үүргэвчтэй аялагчид- **77 ам.доллар** тус тус байна [3].

Дотоодын аялагчдын хувьд НҮБ – ын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр “ТХГН – ийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн санаачилгаар 2013 онд 600 хэрэглэгчийг хамруулан хийсэн судалгаанаас үзэхэд, аялагчдын дийлэнх нь ТХГН – ийг зорин аялдагаас гадна дунджаар 3 – 5 хоногийн хугацаатайгаар аялдаг байна [6]. Аялах явцдаа жуулчны бааз, хувийн майхан, нөхөрлөлийн гэрүүд, дэн буудлуудаар хоноглодог бөгөөд давхардсан дүнгээр дийлэнх хувийг жуулчны бааз болон орон нутгийн нөхөрлөлийн гэрүүдийг ашигладаг байна. Орон нутгийн иргэдээс буюу нөхөрлөлүүдээс морь унуулах, сүү, цагаан идээ худалдаж авах үйлчилгээг түлхүү авдаг болох нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 8. Орон нутгийн нөхөрлөлүүдээс жуулчдын авах үйлчилгээ

Асуулт	Хувилбар	Харнулт	
		Тоогоор	Хувиар
Та орон нутгийн хүмүүсээс ямар үйлчилгээ авсан бэ?	Морь унах	406	38,2%
	Сарлаг унах	25	2,4%
	Хоол хийлгэх	241	22,7%
	Сүү, цагаан идээ худалдаж авах	288	27,1%
	Мал худалдаж авах	76	7,1%
	Бусад	27	2,5%
Нийт		1063	100,0%

2.2. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын түвшин

Улс орнуудын өрсөлдөх чадвар судлал нь эдийн засгийн шинжлэх ухааны салбар бөгөөд аливаа орны компаниуд нь илүү өндөр ашиг орлоготой, ард түмэн нь илүү чинээлэг, хангалуун амьдралтай байх орчныг бүрдүүлж, хөгжүүлэх талаар бодит байдал, бодлого хоёрыг харьцуулан судалдаг. Дэлхийн Эдийн Засгийн Форумаас “Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар”-ын судалгааг явуулж, энэхүү судалгааны тайланг дэлхийн улс, орнуудын төр засгийн болон бизнесийн байгууллагууд өрсөлдөх чадвараа сайжруулах гол баримт бичгээ болгон ашиглаж байна. Энэ нь 1) Аялал жуулчлалын зохицуулалт, эрх зүй 2) Аялал жуулчлалын бизнесийн орчин ба дэд бүтэц 3) Хүн ба байгаль, соёлын нөөц гэсэн гурван үндсэн бүлгүүдэд хуваагдах 14 чиглэл бүхий нийт 71 үзүүлэлтүүдээр дэлхийн улс орнуудыг эрэмбэлэн жагсаадаг индекс юм.

Энэхүү тайлангаас үзэхэд Монгол улсын өрсөлдөх чадварын индекс сүүлийн жилүүдэд сайжирч 105-аас 99-р байранд (хүснэгт 9)шилжсэн байна [15].

Хүснэгт 9. Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар

Онууд	Дэлхийн хэмжээнд эзлэх байр	Бүс нутгийн хэмжээнд эзлэх байр	Дэд индексүүд					
			Хууль эрх зүйн хүрээний АЖ өрсөлдөх чадвар		Бизнесийн орчин ба дэд бүтцийн АЖ өрсөлдөх чадвар		Хүний, соёлын, байгалийн нөөцийн АЖ өрсөлдөх чадвар	
			байр	оноо	байр	оноо	байр	оноо
2013	99 (140)	19 (26)	91	4,3	107	3,0	90	3,7
2011	101 (139)	19 (26)	97	4,2	112	2,8	86	3,7
2009	105 (133)	19 (25)	90	4,2	107	2,7	106	3,5

Монголын аялал жуулчлалын салбарт хүчтэй өрсөлдөх давуу талуудаас гадна шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлууд бий. Өрсөлдөх чадварын давуу тал нь дэлхийн бусад улс оронд олж үзэхэд хэцүү болоод байгаа өргөн уудам, хөндөгдөөгүй ландшафт, өнөөг хүртэл хадгалагдан ирсэн нүүдэлчин амьдралын хэв маяг билээ. Монголын говь, Хөвсгөл нуур, уугуул, нэн ховор, ховордсон амьтан ургамал болон өдийг хүртэл хадгалагдан үлдсэн палеонтологийн олдвор зэрэг Монголын нүүр царайг илтгэх онцлогууд нь олон улсын жуулчдыг татах хүч болж байна.

Монголын аялал жуулчлалын нийтлэг хөтлбөр, бүтээгдэхүүн нь зэрлэг онгон байгаль, эвдрээгүй соёлтой танилцахтай зэрэгцэн явагдах бөгөөд цаашид аялал жуулчлалыг хөгжүүлэхэд өндөр өртөг, дэд бүтэц, туслах тогтолцоо ихээр шаардагдахгүй.

Аялагчид Монгол улс руухүрэх замын зардал нь очсон газар нутагтаа аялал жуулчлалын туслах үйлчилгээнд зарцуулахаас хэт илүү байдагт дурамжхан байдаг нь судалгаагаар нотлогдсон байдаг. Иймд олон улсын нислэгийн үнийг өрсөлдөх чадвар бүхий хэмжээтэй болгож өсгөвөл орон нутгийн нислэгийн үнийг бууруулан, жуулчдаас орон нутгийн нислэгт зарцуулах сонирхлыг нэмэгдүүлэх боломжтой.

Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжилд нөлөөлж буй дараах таагүй нөхцлүүд байна. Үүнд:

- Өвлийн улирал нь хатуу ширүүн, удаан үргэлжлэх тул аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх идэвхитэй үе нь зөвхөн зургаа, долоо, наймдугаарсарууд байдаг. Хэдийгээр богино хугацаатай шилжилтийн үе (тавдугаар сарын эхэн, дундаас зургаан сар хүртэл, есдүгээр сараас аравдугаар сарын дунд хүртэл) байдаг ч аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид жуулчлалын үндсэн үеэс бусад үед үйл ажиллагаа эрхлэхийг бараг хичээдэггүй. Хүйтний улиралд үйл ажиллагааны зардал их гардаг нь үнээ бууруулах замаар жуулчдыг татан үйл ажиллагаа явуулах боломжийг нь хязгаарладаг.
- Монголд ирж очих олон улсын агаарын нислэг хязгаарлагдмал байдаг нь аялал жуулчлалын салбарын хөгжилд таагүй нөлөө үзүүлж байна. Монголд аялал жуулчлал эрхлэгчдийн гол гомдол нь нислэгийн тоо хязгаарлагдмал (өрсөлдөх чадваргүй тээвэрлэлтийн бодлогын уршгаар Монголруу нислэг хийдэг, үндэсний агаарын тээврийн ажиллагаанд нэмэрлэдэг найман компани байдаг: МИАТ, Аэро Монголиа, Кориан Эйр, Аэрофлот, Эйр Чайна, Изнис, Хүннү Эйр болон Туркиш Эйрланз), түүний үнэ өндөр байдаг явдал юм. Цаг агаарын байдлаас болж нислэгийг цуцлах (ялангуяа хавар, намрын улиралд) болон агаарын нислэгийн улирлын графикийг цагийг нь тулган байж гаргадаг практик дээрх бэрхшээл дээр нэмэгддэг.
- Дэд бүтэц сул дорой хөгжсөн нь энэ салбарт тулгардаг бас нэг бэрхшээл юм. Хэдийгээр чанартай авто замын сүлжээ байхгүй, түүнийг дагалдах дэд бүтэц дутагдан аялал жуулчлалын хурдацтай хөгжлийг боомилж байгаа боловч дэд бүтцийн хязгаарлагдмал байдлыг доорх үндсэн гурван шалтгааны улмаас зөвхөн сул тал гэж авч үзэх шаардлагагүй:
 - i. Дэд бүтцийн хангалтгүй байдал нь өдийг хүртэл Монголын гол нүүр царай болсон цөөнгүй тооны үнэ цэнэ бүхий экосистем, зэрлэг онгон байгальтай газар нутгийг хадгалж үлдээхэд хэд хэдэн тус нэмэр болсон байр талтай. Харин ч дэд бүтэц байхгүй байгааг ашиглан байгаль орчинд сөрөг үр дагавар багатай, эдийн засгийн өндөр ашигтай, цөөхөн хүнийг хамарсан тусгай сонирхлын аяллуудыг (загасчлал, ан хийх, явганаар аялах, зэрлэг байгальтай танилцах, фото сафари буюу өндөр үнэтэй дээд зэрэглэлийн аялал) бий болгож хөгжүүлэх сайхан боломжуудыг нээж өгч байна.
 - ii. Монголыг зорин ирэх жуулчдын хүсэх зүйл нь сайхан зассан зам, өндөр хөгжилтэй дэд бүтэц байхгүй ч их зүйл үзэж нийтдээ өндөр сэтгэгдэлтэй буцахаас гадна хамгийн гол нь тэдний аюулгүй байдал билээ. Жуулчдыг татаж байгаа гол үйл явдал болох зэрлэг байгальд байх, хээр хонох, загасчилах, ан хийх болон бусад байгальтай харьцах аялал жуулчлалын үйл ажиллагаанууд нь засаагүй замаар явах, дэд бүтэцгүй байхыг тэсвэрлэх хангалттай шалтгаан болдог.

Хэдий тийм боловч аюулгүй байдлыг ямар нэг байдлаар хангах нь юунаас ч илүү чухал учир хээрийн замын арчилгаа тордолгоо, тэмдэгжүүлэлт хийх, эрэл хайгуул, аврах үйлчилгээ зэргийн бэлэн байдлыг хангахад анхаарах нь зүйтэй.

- iii. Нийтийн хэрэгцээний дэд бүтэц байхгүй байгаа нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчидэд нөхцөлдөө тохирсон жижиг цар хүрээтэй, байгаль орчинд ээлтэй тогтолцоонд шилжихэд нь дэмжлэг өгөх, үүнд нь хөшүүрэг болж чадахуйц бодлого, санхүүгийн тохирсон арга механизмыг авч хэрэгжүүлэх боломж олгох юм. Хэдийгээр зам тээврийн одоогийн байдлыг цаашид сайжруулах шаардлагатай ч Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд нь голчлон адал явдалт аялалд тулгуурласан учир огт тохиромжгүй гэж хэлж болохооргүй байна. Хучилтгүй замуудад мэдээж цаг агаарын хатуу ширүүн нөхцлөөс үүдэх сөрөг үр дагаврыг сааруулах, аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд засвар үйлчилгээ хийх шаардлагатай. Замын тэмдэгжүүлэлт, заалт дутагдалтай байгааг шийдвэрлэснээр одоо байгаа замуудыг оновчтой ашиглах бас нэг боломж бүрдүүлж, аюулгүй байдлыг дээшлүүлэх нэг арга болж болох юм. Орон нутгийн зам тээврийн аюулгүй байдлыг хангахын тулд GPS-ийн буюу газар зүйн мэдээллийн системийн багаж хэрэглэх, гар утасны холбоог хөгжүүлэх, I search барьдаг болгох, аврах үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай.

Монголын өрсөлдөх чадвар ба харьцуулалтын давуу талуудыг нэгтгэн шинжилсэн үнэлгээний дүнг 10-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 10. Монголын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар ба харьцуулалт

	Үнэлгээ (+ + +, + +, + хүртэл -, -, - -)	Тайлбарууд
Зорих газрын өрсөлдөх чадварыг илэрхийлсэн нөөцүүд		
Байгалийн нөөцүүд		
Байршил	- -	Уудамбайгальньөрсөлдөөниймашчухалдавуутал; Цаг агаарын нөхцөл байдлыг маркетингд бэхжүүлэх шаардлагатай
Байгалийн үзэсгэлэнт байдал	+ + +	
Цаг агаар	- -	
Соёлын нөөцүүд		
Түүх	+ +	Нүүдлийн соёл нь маш чухал нөөц бөгөөд түүнийг байгальтай хослуулснаар Монгол улсыг байршуулах чухал элемент болно. Соёлын бусад нөөцүүдийг аялал жуулчлалд сайжруулсан байх хэрэгтэй
Хэл	- -	
Хоол	- -	
Хөгжим	-	
Урлаг ба гар урлал	+	

Уламжлал, зан заншил	+ + +	
Хүний нөөц		
Ур чадвар	- -	Бусад газруудтай харьцуулбал үйлчилгээний салбарууд нь дөнгөж хөгжиж байна.
Бүс нутгийн хэмжээнд ажиллах хүчний байдал	- -	
Хөгжүүлэх нөөцүүд		
Хүрч очих бололцоо	- - -	Нийтэд нь сайжруулахад ихээхэн хөрөнгө шаардана; Ойрын хугацаанд огцом өөрчлөгдөхгүй.
Дэд бүтэц	- -	
Хүний гараар бүтээсэн үзмэрүүд	- -	
Зорих газруудтай харьцуулалтын байдлыг илэрхийлсэн нөөцүүд		
Санхүүгийн нөөцүүд		
Төсвийн хэмжээ ба агуулга	- -	Маркетингд шаардлагатай санхүүжилт багахан бөгөөд олон улсад сурталчлахын тулд нэмэгдүүлэх шаардлагатай.
Хувийн хэвшлийн маркетингийн нөөцүүд	+ +	
Засгийн Газрын бодлогын нөлөөлөл	-	
Хөрөнгө оруулалтын байдал	-	
Хууль эрх зүйн нөөцүүд		
Брэнд, худалдааны тэмдэгүүд	- -	Хувийн салбарын эрх ашигт нийцүүлэн хууль эрх зүйн нөөцүүдийн үр ашгийг сайжруулах хэрэгтэй.
Лиценз ба визийн бодлого	-	
Зохион байгуулалтын нөөцүүд	- -	
Засаг захиргааны бодлого ба бүтэц		
Албан хаагчдын төвшин	-	Засаг захиргааны бодлого ба бүтэц нь зөв боловч мэргэшсэн байдал хангалтгүй.
Сургалт	-	
Дадлага туршлага	-	
Технологи ба уян хатан чанар	-	
Мэдээллийн нөөцүүд		
Маркетингийн мэдээллийн системүүд	- -	Шаардлагатай боловч одоогоор хангалтгүй байгаа.
Хамтын ажиллагааны нөөцүүд		
Салбарын гадаад дотоод интеграци	+	Хамтын ажиллагаатай байгаа нь амжилтанд хүрэх чухал хүчин зүйл болно.
Гол оролцогчидын хамтын ажиллагаа	+	
Хэрэгжүүлэлтийн нөөцүүд		
Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөлт	+	Төлөвлөлтийн үйл ажиллагаа заавал хэрэгжих ёстой.
Байршуулалт ба сурталчилгаа	- -	

2.3. SWOT шинжилгээ

Монголын аялал жуулчлалын нөхцөл байдлын шинжилгээнээс үзэхэд, соёлын болон байгалийн нөөц, нүүдлийн ахуй, зан заншил, өвөрмөц олонд танигдсан түүх зэрэг аялал жуулчлалын үзмэрийн давуу тал олон боловч, дэд бүтцийн хөгжил тааруу, маркетингийн үйл ажиллагааны түвшин сул, улирлын шинж чанартай зэрэг сул талууд аялал жуулчлалын салбарын хөгжилд саад болж байна. Цаашид аялал жуулчлалын салбарт байж болох боломж болон эрсдэлийн талаар хүснэгт 11 – ээс үзнэ үү.

Хүснэгт 11. Монголын аялал жуулчлалын нөхцөл байдлын шинжилгээ

<p>ДАВУУ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> • Соёлын болон байгалийн нөөцтэй газар нутаг • Нүүдлийн ахуй, зан заншил • Нөхөрсөг, найрсаг хүмүүс • Аюулгүй байдал • Өвөрмөц, олонд танигдсан түүх • Экологийн харьцангуй цэвэр нутаг 	<p>СУЛ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын урсгал улирлын чанартай • Дэд бүтэц хөгжөөгүй • Хязгаарлагдмал аялал жуулчлалын үйл ажиллагаа болон чанаргүй бүтээгдэхүүн үйлчилгээ • Маркетинг болон идэвхжүүлэлтийн дутмаг байдал • Эрх зүйн зохицуулалтын хомс байдал
<p>БОЛОМЖ</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын аялал жуулчлалын зах зээл дээр нүүдлийн амьдралын хэв маяг болон уудам газар нутгийг хослуулсан өвөрмөц газар • Томоохон болон шинээр гарч ирж буй Азийн зах зээлд ойрхон • Зах зээлээ тэлэн хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ бага • Уул уурхайн салбарын хөгжил дээр тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг бий болгох 	<p>АЮУЛ ЗАНАЛ</p> <ul style="list-style-type: none"> • БНХАУ-ын Өвөр Монгол зэрэг өрсөлдөгч зорих газрын амжилт • Байгаль орчны менежментийн доройтол

3. ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

3.1. Эрхэм зорилго

Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах замаар нүүдлийн соёл, зан заншлын өлгий нутаг- нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүс нутаг болно.

3.2. Язгуур үнэт зүйлс

Монголын аялал жуулчлалын язгуур үнэт зүйлсүүд нь байгаль орчин ба түүх соёлын өвүүд бөгөөд өнөөгийн нийгмийн амьдрал юм.

3.3. Алсын хараа

Тогтвортой ногоон хөгжил	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд ээлтэй • Газар ашиглалтын цогц шийдэлтэй • Орчны төлөвлөлт бүхий • Байгаль, түүхийн болон орон нутгийн өвийг хадгалж хамгаалсан
Соёл, спортын бүтээгдэхүүнийг байгалийн өвийн нөөцтэй багтаасан багц	<ul style="list-style-type: none"> • Спортын аялал жуулчлал • Нүүдэлчдийн соёл
Тусгай сонирхлын адал явдалт аялал жуулчлалын газар нутаг	<ul style="list-style-type: none"> • Тусгай сонирхолтой зах зээлд чиглэсэн • Эрсдэлгүй, жинхэнэ адал явдал • Байр, сууцны өргөн сонголтууд • Олон улсын стандартын үйлчилгээ
Чанартай дэд бүтэц ба үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Жуулчны мэдээллийн өргөн сүлжээтэй • Хот хооронд зорчих сайн замууд, замын тодорхой тэмдэглэгээ • Агаарын болон төмөр замын зангилаа бөгөөд дамжин өнгөрөх өргөн бололцоо
Нутгийн иргэдэд түшиглэсэн хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Аяллын бүс нутгийн хамтын ажиллагаа

	<ul style="list-style-type: none"> • Нутгийн иргэдийн шууд оролцоо • Орон нутгийн эдийн засгийн хөгжилд бодит дэмжлэг • Нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээний ерөнхий мэдлэг • Зочломтгой малчин ард түмэн
--	---

3.4. Хөгжлийн стратеги

Олон улсын зах зээлд өөрийн улс орны имижийг бүрдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүний ялгарлыг бий болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь тогтвортой аялал жуулчлалын гол зорилго байх болно.

Тогтвортой аялал жуулчлалын гол зорилгод хүрэх аялал жуулчлалын хөгжлийн үндсэн стратегийг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэг. Зорих газрын оновчтой засаглал ба институцийн тогтолцоог сайжруулах


Хоёр. Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх

Гурав. Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох

Дөрөв. Зорих газрын менежмент, дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Тав. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих тус тус болно.

Зураг 6. Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн стратеги



3.5. Ирээдүйн хөгжлийн таамаглал

Олон улсын аялал жуулчлал

2020 онд жуулчдын тоо 1995 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 1,6 тэрбумд хүрэх бөгөөд Ази, Номхон далайн бүс нутагт аялах жуулчдын тоо дэлхийн бусад бүсүүдээс илүү хурдацтай нэмэгдэнэ хэмээн судлаачид үзжээ [14]. Энэ нь тус бүс нутагт эдийн засгийн өсөлт нэмэгдэж, худалдаа арилжаа ихээхэн либералчлагдаж буйтай холбоотой. Түүнчлэн олон улсын жуулчид нэг удаагийн аяллаар хоёр ба түүнээс дээш орноор аялж танилцах сонирхолтой байгаа нь урд хөрштэй хамтран аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж байгааг тодотгож байгаа хэрэг юм. ДАЖБ-ын мэдээгээр өнгөрсөн 2013 онд аялал жуулчлалын салбараас дэлхийн эдийн засагт 1,2 их наяд ам.доллар оруулсан бөгөөд үүнээс 196 тэрбум нь зорчигч тээврийн үйлчилгээнээс олсон орлого байна [12]. Олон улсын аялал жуулчлал, зорчигч тээврийн салбар нь дэлхийн экспортын үйлчилгээний 30 хувийг эзэлж байна. Жуулчдыг бүс нутгаар нь авч үзвэл, Европын орнууд 45%, Ази Номхон далайн бүс 28%, Америкийн бүс нутаг 19% - ийг тус тус эзэлж байна [12].


Олон улсын аялал жуулчлалын цаашдын хөгжлийн голлох хандлагууд:

- 1) Жуулчид эрүүл, ухаалаг хэрэглээний чиглэлийг илүү сонгож байна. Энэ нь жуулчид экологийн цэвэр, соёл, урлагийн арга хэмжээ бүхий аяллуудыг чухалчилж, улмаар байгаль, соёл, түүхийн өвд илүү татагдах болсон нь Монголын аялал жуулчлалд таатай нөлөөлөх боломжтой.
- 2) Аялал жуулчлал нь бүс нутгийн дотор хөгжиж, богино зайн аяллууд илүү зонхилох хандлагатай байгаа.
- 3) Аялалд түрээсийн болон үйлчилгээтэй байрны төрлүүд болон адал явдалт төрлүүд, хувь хүний захиалгат тансаг зах зээлийн хэрэгцээ нэмэгдэж байна.
- 4) Хариуцлагатай аялал жуулчлал, нийгмийн хариуцлагыг цаашид өргөнөөр дэмжих чиглэлтэй. Үүний дотор байгаль цаг уурын өөрчлөлтийн асуудал, ногоон бизнесийг дэмжих нь улам хурцаар тавигдаж байна.
- 5) Бага, дунд оврын агаарын хөлгүүдийг ашигласан, хямд үнэтэй агаарын тээврийн нислэгүүд аялал жуулчлалд улам өргөн хэрэглээтэй болж байна.
- 6) Аяллын болон ханган нийлүүлэгч компаниуд илүү ухаалаг технологи, онлайн маркетингийн арга хэлбэрүүд болон интернет захиалгын системийг сонирхож байна.
- 7) Холын аяллуудаас илүү ойрын бүс нутгийн аяллууд илүү давамгайлан хөгжиж эхэлсэнтэй холбогдуулан зорих газрын менежмент ба аялал жуулчлалын байгууллагынхан энэ чиглэлд маркетингийг шилжүүлэн эрчимжүүлж байна.

- 8) Жуулчны аюулгүй байдалд нөлөөлөх үлс төрийн тогтворгүй байдал, үймээн бослого, цаг агаарын таагүй байдал, гахайн ханиадны тархалт зэрэг нь аялал жуулчлалын хөгжлийг саатуулах голлох хүчин зүйлүүд хэвээр байна.
- 9) Эрүүл мэнд, чийрэгжүүлэлт, биеэ гамнаж сувилж тордох зорилгоор хийх аяллууд улам нэмэгдэх болно. Эрүүл мэндийн аяллууд 2004 оноос эхлэн хөгжиж байгаа бөгөөд судалгаанаас үзэхэд, энэ төрлийн жуулчид очсон газартаа ердийн жуулчдаас дөрөв дахин илүү хугацаагаар байрладаг байна.
- 10) Хятадын жуулчдын урсгал нэмэгдэхийг бүс нутагт төдийгүй дэлхийн аялал жуулчлалд мэдэгдэхүйц нөлөөлнө гэж үзэж байна. Үүний дотор янз бүрийн орнуудад суралцаж байгаа хятад оюутнуудын тооны өсөлт ч хамаарна.

Монголын аялал жуулчлалын өсөлтийн таамаглалууд

2014 онд Улаанбаатар хотын захиргаа, Голомт банкны эдийн засагч нарын хийсэн таамаглал, тооцооноос үзэхэд, 2030 онд Монгол улсын ДНБ 25 их наяд төгрөг болох бөгөөд үүнээс 28 орчим хувь аялал жуулчлалын салбараас олох орлогоос бүрдэх юм [5].



Монголыг зорин ирэх жуулчдын хэтийн төлвийг 2021 он хүртэл 3 хувилбараар тооцож үзвэл, дараах байдалтай байна.

ӨСӨЛТИЙН А ХУВИЛБАР

Хүснэгт 12. Өсөлтийн А хувилбар /бага өсөлт/

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.6900	35,045	10,864	10,614	10,370	10,131	9,898	9,671	9,448	9,231
Хувийн	299,306	62.9	0.0000	299,306	326,842	356,912	389,748	425,604	464,760	507,518	554,209	605,197
Албан	151,398	31.8	0.0000	151,398	163,510	176,591	190,718	205,975	222,453	240,250	259,470	280,227
Дамжин	2,850	0.6	-0.7500	713	556	433	338	264	206	160	125	98
Бусад	5,597	1.2	-0.7700	1,287	1,017	803	635	501	396	313	247	195
Нийт	475,917			487,748	502,789	545,353	591,808	642,476	697,713	757,911	823,500	894,948

Өнөөдрийг хүртэлх өсөлтийн хурдцийг өмнөх жилүүдийн хэлбэлзлийн дунджаар тооцоход 2020 онд Монгол улс 823500 жуулчин хүлээн авах боломжтой гэсэн тооцоо гарч байна.

Харин өмнөх жилүүдийн өсөлтийн дундаж хурдцийг хэвээр хадгална гэж үзсэн нөхцөлд 2021 онд аялагчдын тоо 1056183 – д хүрэхээр байна.

ӨСӨЛТИЙН В ХУВИЛБАР

Хүснэгт 13. Өсөлтийн В хувилбар /дунд өсөлт/

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.02	110,447	107,907	105,425	103,000	100,631	98,317	96,055	93,846	91,687
Хувийн	299,306	62.9	0.09	326,842	356,912	389,747	425,604	464,760	507,518	554,209	605,197	660,875
Албан	151,398	31.8	0.08	163,510	176,591	190,718	205,975	222,453	240,250	259,470	280,227	302,645
Дамжин	2,850	0.6	-0.22	2,223	1,734	1,352	1,055	823	642	501	390	305
Бусад	5,597	1.2	-0.21	4,422	3,493	2,760	2,180	1,722	1,361	1,075	849	671
Нийт	475,917			607,444	646,636	690,002	737,815	790,389	848,086	911,310	980,509	1,056,183

ӨСӨЛТИЙН С ХУВИЛБАР

Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, Монгол улсад тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө, Аймаг орон нутгуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг уялдаа холбоотойгоор хэрэгжүүлж чадвал 2021 он гэхэд 1763284 жуулчин хүлээн авах боломжтой.

Хүснэгт 14. Өсөлтийн С хувилбар /өндөр өсөлт/

Аялалын зорилго	2012	Proportion of Total 2012 (%)	AAG of Total (2007-2012)	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Жуулчлал	113,047	23.8	-0.0023	112,787	112,528	109,939	107,411	104,940	102,527	100,169	97,865	95,614
Хувийн	299,306	62.9	0.9200	574,668	627,537	685,270	748,315	817,160	892,339	974,434	1,064,082	1,161,978
Албан	151,398	31.8	0.8000	272,516	294,318	317,863	343,292	370,756	400,416	432,449	467,045	504,409
Дамжин	2,850	0.6	-0.0220	2,787	2,174	1,696	1,323	1,032	805	628	490	382
Бусад	5,597	1.2	-0.0210	5,479	4,329	3,420	2,702	2,134	1,686	1,332	1,052	831
Нийт	475,917			968,238	1,040,885	1,118,188	1,203,043	1,296,022	1,397,773	1,509,012	1,630,534	1,763,214

4. ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

4.1. Зорих газрын оновчтой засаглалыг хөгжүүлэх, институцын тогтолцоог сайжруулах

ҮНДСЭН ЗОРИЛТ: Монгол улсын хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогч бүх талуудын хамтын ажиллагааг дэмжиж, үйл ажиллагааны менежментийг сайжруулах, салбарын засаглалын шинэ системийг зохицуулалтын механизмыг бий болгох.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Монголд аялал жуулчлалыг “хүмүүсийн үйлчилгээний үйлдвэрлэл” болгох,
- ДНБ-д аялал жуулчлалын салбарын хувийг нэмэгдүүлэх,
- Аялал жуулчлалын дэд бүтэц, байгууламжийн хөрөнгө оруулалтыг татах,
- Зочид буудал, амралтын цогцолборын төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Орон нутгийн эдийн засагт аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх,
- Зорих газрын орчны хөгжлийг төлөвлөж, салбарын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах,
- Салбарын сонирхогч талуудыг үнэн зөв, хэрэгцээт статистик мэдээллээр хангах,
- Жуулчны аюулгүй байдлыг хангах,
- Монголын аялал жуулчлалын менежментийг үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг шуурхай хүлээн авч шийдвэрлэж чадах зорих газрын менежментийн байгууллагыг байгуулах,
- Монголын аялал жуулчлалын нөөцийн тогтвортой хөгжил, менежментийн урт хугацааны стратегийг салбарынхантай хамтран боловсруулах,
- Өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа нөхцөл байдлыг хариуцлагатайгаар анхаарч, аялал жуулчлалын шинэ идэвхи санаачилга гаргаж байгаа гол байгууллагууд, сонирхогч талууд хамтран ажиллах оновчтой механизм, тогтолцоог бий болгох,
- Аялал жуулчлалын сонирхогч талуудтай хамтран ажиллаж, нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалын ашиг тус, ач холбогдлыг сурталчилж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

Бодлогын зөвлөмжүүд:

- 1) Аялал жуулчлалын харилцааны эрх зүйн шинэ тогтолцоог бий болгох

Аялал жуулчлалын бизнесийн амжилтанд аялал жуулчлалын тогтвортой өсөлтийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангах орчныг бүрдүүлсэн байдал шууд нөлөөлдөг болно. Жуулчны зорих газруудад аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн шаардлагатай менежментийг хийхэд шаардлагатай санг жуулчны татвар, хураамжийн оновчтой системээр шийдвэрлэнэ. Орон нутагт аялал жуулчлалын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд жуулчны хөтөч болон зочид буудал, жуулчны бааз, аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор зэрэг холбогдох үйлчилгээний үйл ажиллагаанд лиценз, зөвшөөрөл олгох зөв механизмыг бий болгож, хөгжүүлэх нь зүйтэй байж болох юм. Иймд одоо мөрдөж байгаа “Аялал жуулчлалын тухай” хуулийг Монгол улсын аялал жуулчлалын одоогийн ба цаашдын хөгжлийн шаардлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн олон улсын шилдэг туршлагын дагуу шинэчлэн боловсруулж, улмаар уг шинэ хуульд үндэслэн эрх зүйн шинэ тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Аялал жуулчлалын шинэ хуулиар аялал жуулчлалын нөөцийн хөгжил, менежментийг сайжруулах, маркетинг болон салбарын мэргэжлийн боловсон хүчний ур чадварыг хангах, мэргэжлийн сургалтын нэр хүнд, ач холбогдлыг дээшлүүлэх зэрэг асуудлуудыг хамруулах нь зүйтэй. Аялал жуулчлалын эрх зүйн шинэ зохицуулалтаар шийдвэрлэх шаардлагатай байгаа нэн чухал асуудлууд нь:

- Төр, хувийн хэвшлийн харилцаа, хамтын ажиллагаа
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Орон нутагт аялал жуулчлалаас олох орлогооснутгийн иргэдэд өгөөжийг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын төслийг дэмжих
- Дотоодын болон гадагшаа аялах аяллыг хариуцлагатайгаар хөгжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тусгай зохицуулалтууд зэрэг болно.

2) Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийг Ерөнхий Сайдын дэргэд байгуулж ажиллуулах

Монгол улсын Ерөнхий Сайдын дэргэд Аялал Жуулчлалын Зөвлөлийг байгуулж “...аялал жуулчлалын талаархи төрийн нэгдсэн бодлого болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөлгөө өгөх, санал дүгнэлт гаргах үүрэгтэй” гэж “Аялал жуулчлалын тухай” хуулийн 15.2-р зүйлд заасан байдаг. Энэхүү зөвлөлийн талаархи хуулийн заалтыг одоогийн нөхцөл байдалд зохицуулан өөрчилж хэрэгжүүлэх нь Монгол улсын аялал жуулчлалын цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой билээ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд ССАЖЯ, БОНХЯ, ЭЗХЯ, ГХЯ, БШУЯ, ЗТЯ болон бусад холбогдох Яамдын Газрын даргаас дээш албан тушаалтнууд болон Аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтнууд,

мөн мэргэжлийн байгууллага, Холбоодоос оролцуулах шаардлагатай. Зөвлөлийн хурлаар хэлэлцэхэд хамаарах асуудлууд нь:

- Аялал жуулчлалын мэдээллийн системийг бий болгож хөгжүүлэх
- Маркетинг, сурталчилгаа
- Олон улсын агаарын болон төмөр замын зорчигч тээврийн зохицуулалт
- Монгол улсад зорчих визийн хөнгөлөлт
- Салбарын хөдөлмөр эрхлэлт, хүний нөөц
- Аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулах
- Дэд бүтэц
- Хөрөнгө оруулалт
- Байгаль орчны зэрэг стратегийн асуудлууд байна.

3) Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бүтцийг бий болгох

Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь үндэсний, бүс нутгийн болон тухайн орон нутгийн түвшинд аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг боловсруулж, стратегийн төлөвлөлтийг батлах, хэрэгжилтийг уялдуулан зохицуулах явдал юм. Үүний тулд бүх түвшний төлөвлөлтийн нэгдмэл байдал, шаардагдах мэдээллийг иж бүрэн хангах зорилгоор:

- Бусад Яамдын бүрэлдэхүүнд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн нэгжийг байгуулах
- Аймаг, орон нутагт аялал жуулчлалын хөгжлийн зөвлөлийг байгуулах
- Аялал жуулчлалын төрийн байгууллага, орон нутаг дахь нэгжүүдийн чадавхийг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх бүтцийг бий болгох шаардлагатай болно.

4) Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх

Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн системийг улсын хэмжээнд бий болгож, хөгжүүлснээр Аялал Жуулчлалын Зөвлөл болон шийдвэр гаргагчдыг төдийгүй гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг Монголын аялал жуулчлалын хөгжил, амжилт болон салбарын мэдээ, тайлангуудаар цаг тухай бүрт нь үнэн зөв хангах боломжтой болно. Энэ зорилгоор Аялал Жуулчлалын Үндэсний Төв нь одоогийн туршлага, практикт үндэслэн Монгол улсын, аялал жуулчлалын бүс нутаг, жуулчны зорих газрын аялал жуулчлалын мэдээлэл болон Монгол улсын нутагт аялсан гадаад, дотоодын жуулчдын төлөв, сэтгэгдлийн судалгаа, мониторингийг хийх ажлыг хэрэгжүүлэхэд гол зохицуулагч байх бүрэн боломжтой юм. Аялал жуулчлалын мэдээллийн үр дүнгийн гол хэмжүүрүүд нь:

- Жуулчдын тооны өсөлт, дахин ирэх жуулчдын тоо, санал сэтгэгдэл
- Гадаад, дотоодын жуулчдын аяллын явцад зарцуулсан зардлын хэмжээ ба төрлүүд
- ДНБ-д аялал жуулчлалаас орох орлогын өсөлт
- Салбарын хөрөнгө оруулалт
- Ажлын байрны өсөлт
- Өртгийн сүлжээний өгөөж
- Аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллүүд зэрэг болно.

5) Жуулчны аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах системийг улам сайжруулах

ССАЖЯ нь холбогдох төрийн болон ТББ-уудтай хамтран аюул, гамшгийн нөхцөл байдалд (газар хөдлөл, зуд, үер, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн гамшиг болон хүн, малын гоц халдварт өвчний үед) жуулчны байгууллагууд хэрхэн ажиллах, гамшгийг хохирол багатай өнгөрөөх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг бий болгож, гамшгийн удирдлагын системийг сайжруулах талаар санаачлагатай ажиллах шаардлагатай юм.

Сүүлийн жилүүдэд олон улсын аялал жуулчлалын практикт эрсдэлийн менежментийн тухай ойлголтыг жуулчны аюулгүй байдлыг хангахад ашиглах болсон бөгөөд жуулчны эрсдэлийн санг байгуулж, урьдчилан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны болон бусад шаардлагатай зардалд зарцуулж байгааг нэвтрүүлж болох юм. Гэхдээ аялал жуулчлалын гол бүс, төвүүдэд жуулчны аюулгүй байдлыг хангах ажлыг жилийн ажлын төлөвлөгөөнд заавал тусгасан байх хэрэгтэй.

Мөн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн хүрээнд аялал жуулчлалын үйлчилгээг хэрхэн зохицуулах, жуулчин-хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг хийж, холбогдох журам, заавруудыг боловсруулан мөрдүүлнэ. Энэ хүрээнд хулгайн болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд Улаанбаатар хотод жуулчны цагдаа ажиллуулж байгаа нь үр дүнтэй байгааг анхаарч, цаашид дэмжин дэлгэрүүлэх нь чухал байна.

4.2.Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх

ҮНДСЭН ЗОРИЛТ:Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрэлдүүлэгч байгаль, соёлын нөөцийг хадгалж хамгаалан, зөв зохистой ашиглах, орон нутгийн иргэдийг хүндэтгэн хамгаалж, тэдний амьдралын түвшинг нь сайжруулах.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Аялал жуулчлалын сөрөг нөлөөллүүдийг багасгаж, тогтвортой аялал жуулчлалыг дэмжин сурталчлах,

- Ногоон бүс, соёл, ахуй зан заншлаа хадгалж хамгаалахад нь орон нутагт дэмжлэг, туслалцаа үзүүлэх
- Байгаль орчныг дээд зэргээр хамгаалахын хамт зүй зохистой ашиглах.
- Байгалийн нөөц баялаг, биологийн төрөл зүйлүүд, түүх, архитектор, соёлын өвүүдийг хадгалан хамгаалж, нүүдэлчдийн соёлыг хэвээр хадгалахад тусгайлан анхаарч ажиллах,
- Аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг орон нутагт өргөжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх,
- Тусгай тодорхойлсон буюу хөгжлөөрөө хоцорч яваа газар нутгуудын нийгэм-эдийн засгийн хөгжилд аялал жуулчлалаар дамжуулан дэмжлэг үзүүлэх,
- Бэлэг дурсгалын өргөн үйлдвэрлэлд зориулсан зах зээлийг бий болгож, соёл урлагийнхний нийгмийн халамжийг баталгаажуулах,
- Үзэсгэлэн, их наадмуудаар дамжуулан соёлын хамтын ажиллагааг дэмжих
- Аялал жуулчлалын байгаль орчны стандартыг түшиглэн ногоон гэрчилгээжүүлэлтийг нэвтрүүлэх.

Бодлогын зөвлөмжүүд:

➤ Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын хөгжил /НИТАЖ/

Аялал жуулчлалын эдийн засгийн нэг чухал тал нь түүний нийт улс орны хэмжээнд орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах боломж билээ. Нутгийн иргэдийг аялал жуулчлалыг дэмжих үйл ажиллагаанд хамруулан амжилттай хэрэгжсэн олон улсын хандивлагч байгууллагууд болон хувийн хэвшлийнхний санал санаачлагууд Монголд олон байдаг. Зарим газарт хэдхэн жилийн дотор орон нутгийн өрхийн орлого 400 хувиар өссөн жишээ байна. Иймэрхүү ажиллагаанууд нэг талаас тухайн орон нутгийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, нөгөө талаас аялал жуулчлалын нийлүүлэгчдийн өртөг зардлыг бууруулан хэн хэндээ ашигтай байх зарчим хэрэгждэг. Ийм амжилттай хэрэгжсэн загваруудыг бусад газарт хэрэгжүүлбэл аялал жуулчлалын эдийн засгийн шинэ салбаруудыг хөгжүүлэх ач холбогдлыг нэмэгдүүлж, салбарын нийлүүлэлтийг хялбарчлан, орон нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн болон нийгмийн үр шимийг дээшлүүлэх боломжтой.

Орон нутагт илүү чанар сайтай, илүү найдвартай нэмэлт үйлчилгээ үзүүлэх чадвар бий болгох нь эдийн засагт өгөх үр ашгийн хуваарилалтыг сайжруулахад чухал алхам болно. Түүнээс гадна орон нутагт үйлчилгээ үзүүлдэг болоход хөдөөгийн аж ахуй эрхлэгчдэд санхүүжих боломж нээлттэй байх шаардлагатай. Хоол хүнс боловсруулах тогтолцоог сайжруулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөшүүрэг хэрэглэх нь салбар

хоорондын холбоог бэхжүүлэх түүнчлэн хөдөөд уламжлалт амьдралын хэв маягийг хадгалан үлдээнгээ эдийн засгийн үр ашгийг нь дээшлүүлэхэд тустай.

Мөн газар ашиглалт нь хөдөөд тулгамдсан асуудал болж байна. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн газар өмчлөх буюу ашиглах тухай эрхийг шийдвэрлэхгүйгээр НИТАЖ амжилтанд хүрэхгүй байгаа нь бусад орнуудын туршлагаас тодорхой байгаа юм..

Зээлийн хүндрэл нь орон нутагт шаардагдах хөрөнгө оруулалтыг хойшлуулсаар байна.

Орон нутгийнханд ач холбогдолтой аяллын үйл ажиллагаанууд нь байгалийн байдалтай танилцаж малчин айлд хоноглох аяллууд, айл-гэрт байрлахыг бусад аяллуудтай багцалсан төрөл бүрийн аяллууд болон морь, тэмээн аяллууд зэрэг болно.

НИТАЖ-ын үйл ажиллагаанууд бол гар урлалын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүх байгальтай танилцаж малчин айлуудад хоноглох болон гэр баазуудад бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэх зэрэг болно. Орон нутгаас аялал жуулчлалын нэмэлт үйлчилгээнд мах, сүү, сүүн бүтээгдэхүүн болон хүнсний ногоо нийлүүлэх оролдлогуудыг амжилттай хэрэгжүүлж буй туршлагаууд нь Монголд аялал жуулчлалыг хөдөө аж ахуйн салбартай холбох загвар болох боломжтой.

Орон нутагт аялал жуулчлал эрхлэгчдийн хувьд зориулалтын байгууламж, үзүүлж буй үйлчилгээг хөгжүүлж, боловсронгуй болгоход нь тулгарч буй гол саад тотгор нь санхүүжилт олж авч чаддаггүйд оршдог. Ялангуяа аялал жуулчлалын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хүндрэл багатай, хямд зээл олгох механизм бий болгож хөгжүүлэх нь хувийн хэвшлийнхэн, аж ахуй эрхлэгчдэд улирал бүрийн эхэнд хөрөнгө оруулалт хийж барилга байгууламж, үйлчилгээгээ сайжруулах боломж олгохоор байна.

➤ *Аялал жуулчлалын салбарт байгаль орчны стандартууд ба ногоон гэрчилгээжүүлэлтийг нэвтрүүлэх*

Сүүлийн хориод жилийн турш аялал жуулчлалын үйлдвэрлэлийг “ногоон” болгох оролдлого янз бүрийн түвшинд төрөл бүрийн аргуудаар хийгдэж байна. Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд, холбогдох ТББ-ууд, НҮБ-ын ДАЖБ (UNWTO), байгаль орчныг хамгаалах болон мэргэжлийн бусад байгууллагууд, судлаачид байгаль орчинд хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагааг стандартжуулах, баталгаажуулахад чиглэгдсэн гол төлөв сайн дурын санал, санаачилгууд олныг дэвшүүлжээ. Үүний дотор хариуцлагатай болон эко аяллын ойлголт, тодорхойлолтууд, үйл ажиллагааны зарчим, жуулчны ёс зүйн журам (НҮБ-ын ДАЖБ-аас гаргасан олон улсын жуулчны ёс зүйн журмыг 1–р хавсралтанд товчлон үзүүлэв), тэргүүн туршлагаууд, арга зүйн зөвлөмж, гарын авлага зэрэг багтаж байна. Эдгээр санал, санаачилгын арга хэмжээнүүд нь гурван үндсэн нийтлэг зорилготой:

- a) Салбарын холбогдох стандарт, практикийг бий болгох, хөхүүлэн дэмжих,
- b) Байгаль орчин болон нийгэм, соёлын хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлэх,

- с) “Ногоон” үйл ажиллагаатай байгууллага, үйлчилгээ, үзэх зүйлүүдийн талаар мэдээллийг аялагчдад сурталчлан хүргэх.

Аялал жуулчлалын салбарын хувьд олон улсын болон төр, засгийн холбогдох хууль тогтоомжоос хамааралгүй өөрийн сайн дурын дүрмийг тогтоох нь бас ач холбогдолтой юм. Дэлхийн Аялал Жуулчлалын Зөвлөлөөс (World Travel and Tourism Council) аялал жуулчлалын салбарын өөрийн нийтлэг дүрэмтэй байх нь байгаль орчныг хамгаалах үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд нийцнэ гэж үзсэн бөгөөд энэ талаар 1997 онд гаргасан “Байгаль орчны зөвлөмж”-д тодорхой заасан байна. Мөн ДАЖЗ нь 1994 оноос “Ногоон бөмбөлөг” хөтөлбөрийг санаачлан дэмжсэн нь угтаа төр, засгийн бус салбарын өөрийн дүрмийг бий болгож тогтоох гэсэн эрмэлзэл хэмээн үздэг.

Төр, засгийн бий болгосон хууль, дүрмүүд нь байгаль орчныг хамгаалах үзэл баримтлалтай нийцэхгүй байна гэж үзсэн учраас Дэлхийн Зөвлөл (Earth Council), Дэлхийн аялал жуулчлалын зөвлөл (WTTC) ба Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO) гэсэн гурван том байгууллагуудаас 1995 онд Риогийн тунхаглалыг дэмжиж “Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн хэлэлцэх асуудал 21” (**Agenda 21 for Travel and Tourism Industry**) баримт бичгийг гаргасан байна.

Хэдийгээр аялал жуулчлалын салбар нь өөрсдөө үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоосон дүрэм, журмыг санаачлан хэрэгжүүлж болох ч угаасаа бизнесийн бусад салбаруудын нэгэн адил төр, засгийн хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байдаг. Улс орон бүр өөрийн онцлогт тохируулан хүн-байгалийн зохистой байдлыг хадгалсан эдийн засаг, технологийн хөгжилд тулгуурласан стандартын хэм хэмжээг тогтоодог билээ. Тогтоосон стандартанд нийцэх байдлыг лиценз буюу тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтын механизмаар хянаж байдаг нийтлэг үндэстэй.

Аялал жуулчлалд оролцогч олон талууд янз бүрийн шалтгаанаар гэрчилгээжүүлэлтийг дэмжиж байгаа явдал юм. Хамгийн сайн гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөр нь оролцогч талуудын хүсэл, сонирхлыг жигд тусгасан байх шаардлагатай болдог (2-р хавсралт). Оролцогч талуудын ашиг, сонирхлуудыг авч үзвэл:

- ❖ *Байгаль хамгаалагчид, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааныхан* аялал жуулчлалын уламжлалт төрөл, хэлбэрүүд, үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад анхаарч байгаа тул экосистемийг урт хуагцаанд хадгалан, улмаар аялал жуулчлалын байгууллагуудын байгаль орчны нөлөөллийг багасгах, байгаль хамгаалах нэг үндсэн арга зам нь гэрчилгээжүүлэлт хэмээн үзэж байна.
- ❖ *Аялал жуулчлалын салбарынхны* хувьд аялал жуулчлалын компаниудын үйл ажиллагаа нь тодорхой стандартанд нийцэж байгаад үнэлгээ хийлгэх, техникийн

зөвлөлгөө авах, сайжруулах болон цаашилбал, зах зээлийн ялгааг тодотгох, харилцагчдаар хүлээн зөвшөөрүүлэх, улмаар бизнесийн амжилтанд хүрэхэд сайн дурын гэрчилгээжүүлэлт, эко шошготой болох нь ач холбогдолтой гэж хүлээн зөвшөөрч байна.

- ❖ *Аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа улс орнууд* нь олон улсад нэр хүндээ өсгөж, аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх болон төр, засгаас тогтоосон стандарт, журмуудаа харьцуулан дүгнэх, бизнесийн үйл ажиллагааны байгаль, нийгэм, соёл, эдийн засгийн эерэг нөлөөллийг сайжруулахад гэрчилгээжүүлэлт нь чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн дэмжиж байна.
- ❖ *Аялал жуулчлалын бүс нутгийнхан, орон нутгийнхний* хувьд гэрчилгээжүүлэлтийг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгмийн эерэг үр дүнг хэмжих, улам сайжруулах боломжтой болно.
- ❖ *Жуулчдын* хувьд гэрчилгээжүүлэлт нь байгаль орчныг хайрлан хамгаалж, орон нутгийн нийгэм, соёл, улс төр, зан заншлыг хүндэтгэн, нутгийн иргэдийн амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон ялгах бололцоог бүрдүүлнэ.
- ❖ *Олон улсын дэмжигч, санхүүжүүлэгч байгууллагууд* нь одоогийн нийтлэг дүрэм, журмыг хэрэгжүүлэх, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий төслүүдийг дэмжихэд гэрчилгээжүүлэлт нь хувь нэмэр оруулах юм. Гэрчилгээжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж цаашид өргөжин хөгжих баталгаатай болно.

➤ **Байгаль, нийгэмд аялал жуулчлалаас үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах**

Монголд айлчилж буй гадаадын жуулчидын ихэнх нь Монголын байгалийн үзэсгэлэнт байдал, өргөн уудам орон зай, нүүдэлчин амьдралын хэв маяг, зэрлэг амьтан ургамлыг харах гэж ирдэг. Гэтэл улс орны нилээд чухал байгаль, соёлын өв болсон газруудад зохион байгуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулсаны улмаас зарим газар нутагт хүний тоо, унаа хөсөг ихээрээ төвлөрч, харин зарим сонирхол татахаар газруудад нь хүрч болохгүй, хөгжил нь хоцорсон хэвээр байна. Жуулчдын баазын тоо төлөвлөлтгүйгээр хурдан хугацаанд газар авсан нь Тэрэлж, Хөвсгөл зэрэг нийтийн сонирхол татсан газруудад бөөгнөрөл үүсч, аялагчдын сонирхлыг бууруулахад хүрч байна.

Ахуйн үйлчилгээ үзүүлэх, зорьсон газарт хүргэх тээврийн асуудлыг зохицуулах талаар ихэнх газарт батлагдсан төлөвлөгөө байхгүй, нилээд газруудад бохир усны менежментийг шаардлагын хэмжээнд хүртэл хийж чадахгүй байна. Түүнчлэн уул уурхайн


үйл ажиллагаа явуулах, мод огтлох зэрэг олборлолтын үйл ажиллагаа, зэрлэг амьтан ургамал, соёлын эд зүйлсийн хулгайгаар худалдаалах явдал байгаль орчинд шууд занал учруулж байна. Үүний гол шалтгаан нь эдгээр газруудыг хөгжүүлэх төлөвлөлт хийгдэггүй, аялагчдын хөдөлгөөнийг зохицуулах дэд бүтэц дутагдалтай, эдийн засгийн үйл ажиллагааны тархалт, байршил, гарах үр нөлөөг бууруулах асуудал зохицуулагдаагүйд оршиж байна.

Аялал жуулчлалын өсөлтийг даган гарч байгаа санхүүгийн болон хүний нөөцийн менежментийн шийдвэрлээгүй байгаа асуудлуудаас хамаарч Монголын байгаль, түүх соёлын хосгүй нөөц, үзмэрүүдийн бүсэдбайгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллүүд үүсч эхлээд байна. Нөгөөтэйгүүр, аялал жуулчлалын олон тооны нөөц үзмэрүүдэд хүрч очиход хүндрэлтэй, зах зээлийн мэдлэг дутуу,хөрөнгө оруулалт хангалтгүй, аялал жуулчлалын төлөвлөлт байхгүйгээс одоогоор бүрэн зөв ашиглаж чадахгүй байгаа юм.

Байгаль орчинд жуулчны баазын үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг жуулчны баазууд өөрсдөө хог хаягдал, газрын доройтол, зохицуулалтгүй зам харгуй гаргах, усны бохирдол хэмээн тодорхойлсон байна [4]. Түүнчлэн нэмэлт нөлөөлөл гэж ойр орчмын уул уурхайн үйл ажиллагаа, хяналтгүй кемпинг болон мод, бусад байгалийн нөөц баялгийг тогтвортой бус байдлаар ашиглах гэж оруулжээ.

Байгалт орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа болон ирээдүйд зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа арга хэмжээнүүдийн талаар харьцуулсан судалгааг 7 –р зургаар үзүүлэв [4].

Зураг 7. Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээнүүд



Мөн Засгийн Газраас болон өөрсдийн зүгээс авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа арга хэмжээнүүдийн саналуудыг 15-16 –р хүснэгтүүдэд үзүүлэв[4].

Хүснэгт 15. Засгийн Газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Арга хэмжээний төрөл	Саналын тоо	%
Жуулчны баазуудын хяналтыг бэхжүүлж, стандартчлах	18	23,7
Байгаль орчны хамгааллыг бэхжүүлэх	18	23,7
Байгаль орчинд ээлтэй технологид хөрөнгө оруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	16	21,1
Дэд бүтцийг сайжруулах	12	15,8
Уурхайн менежмент, хяналтыг сайжруулах	6	7,9
Аялал жуулчлалын салбар дахь гадаад хамтын ажиллагааг дэмжих	4	5,3
Хүчин чадавхийг бэхжүүлэх	1	1,3
Жуулчны баазуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих	1	1,3

Хүснэгт 16. Жуулчны баазын өөрсдийн авах арга хэмжээ

Арга хэмжээний төрөл	Саналын тоо	%
Ландшафт болон хүрээлэн буй орчны сайжруулалт	16	28,1
Нөөцийн ухамсартай болон тогтвортой ашиглалт	11	19,3
Байгаль орчны хамгааллын сурталчилгаа	9	15,8
Хаягдлыг багасгах	7	12,3
Байгаль орчны хяналтыг сайжруулах	5	8,8
Зэрлэг ан амьтныг хамгаалах	4	7,0
Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх	2	3,5
Ногоон хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих	2	3,5
Хамгаалалтыг нөхцөлдүүлэх	1	1,8

Иймд аялал жуулчлалын зорих газар, үзмэрүүдийн орчны төлөвлөлтийг дээд зэргээр хийж гүйцэтгэх нь тэргүүн зэргийн ач холбогдолтой юм. Байгаль, түүх соёлын нөөцтэй газруудын хувьд ийм төлөвлөлтийг хийхдээ даян дэлхийн цаг агаарын болон бусад өөрчлөлт, зах зээлийн хөгжилтэй холбогдуулан тогтвортой хөгжлийн зарчмаар нөөцийг хадгалах, хамгаалах асуудлыг гол зорилгоо болгох шаардлагатай. Аялал жуулчлалын тухайн орон нутгийн байгаль, нийгэм, эдийн засагт үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг тооцож үзсэний үндсэн дээр байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, нийгэм, эдийн засгийн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр газар ашиглалтыг зохион байгуулах шаардлагатай болно. Нөлөөллийн үнэлгээг –3 аас +3 – ийн хооронд баллаар үнэлэхээр тодорхойлсон бөгөөд аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, аялал жуулчлалын

нөлөөлөл тодорхой хэмжээнд үүсээд байгаа газар нутгуудад ялгаатай байхаар заасан байдаг(Хавсралт 3).

Монголыг зорин ирж буй жуулчдын дийлэнх хувь нь ТХГН – уудыг зорин очсон байдаг. Монголд аялж байгаа гадаадын 10 жуулчдын 8 нь Монголын аль нэг ТХГН-т зочлохдоо аяллын хөтөлбөрийн дагуу нэгээс дээш газруудад аялж үзсэн байна. “Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн тасалбар”-ын зарцуулалтын тайлангийн дүнгээс үзэхэд, ТХГН-уудад 2011 оны байдлаар нийт 247,497 жуулчид аялсны 79,3% нь дотоодын, тэдний 71,3% нь Хан Хэнтийн УТХГ, Богд хан уулын ДЦГ, Хөвсгөлийн УТХГ-уудад аялжээ.

Зураг 8. Монгол улсын ТХГН-ын сүлжээ



Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа улсын ТХГН-ууд

1. Горхи Тэрэлж БЦГ
2. Богд Хаан уул ДЦГ
3. Хөвсгөл нуур БЦГ
4. Хан Хэнтийн ДЦГ
5. Говь Гурван Сайхан БЦГ
6. Хангайн нуруу БЦГ
7. Орхоны хөндий БЦГ
8. Хөгнө Тарна БЦГ
9. Хорго Тэрхийн Цагаан нуур БЦГ
10. Хүйсийн найман нуур БДГ

Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа орон нутгийн ТХГН-ууд

11. Өгий нуур
12. Хархорин

Аялал жуулчлалын нөлөөлөл тодорхой гарч эхлэх хандлагатай байгаа улсын ТХГН-ууд:

1. Дарьганга БЦГ
2. Хустайн нуруу БЦГ
3. Молцог элс БЦГ
4. Онон Балж БЦГ
5. Даян дээрхийн агуй БДГ
6. Ээж хайрхан БДГ
7. Шилийн Богд БДГ
8. Уран тогоо-тулга уул БДГ

➤ **Аялал жуулчлалын хүчин чадлын даацыг тодорхойлох**

Аялал жуулчлалын даац гэдэг нь өргөн хүрээтэй, маргаантай ойлголт бөгөөд ерөнхийдөө *“Нэгж нутаг дэвсгэрээр нэгж хугацаанд аялж, зорчиж болох жуулчдын дундаж стандарт хэмжээ”* юм. Энэхүү дундаж стандарт хэмжээ нь тухайн газар орны экосистемийн онцлог, дэд бүтэц, үйлчилгээний байгууллагын хүчин чадал зэргээс хамаараад газар орон бүрт адилгүй байна. Аялал жуулчлалын даацыг тодорхойлохын тулд аялал жуулчлалын хүчин чадал гэсэн ойлголтыг авч үзнэ. Бүс нутаг, газар орны аялал жуулчлалын хүчин чадал нь жуулчдын сэтгэл ханамжтай байгаа эсэхээр хэмжигддэг болно.

Жуулчны баазуудын дунд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд, Горхи Тэрэлжийн БЦГ, Өгий нуур, Цэнхэрийн халуун рашаан, Хорго Тэрхийн Цагаан нуур, Хатгал, Хөвсгөл нуур, Жаргалантын халуун рашаан, Хонгорын элс, Ёлын ам, Элсэн Тасархай, Хархорин, Хөгнөхаан уул зэрэг газруудыг гадаадын жуулчдын тооны дарамтанд байдаг гэж үзжээ [4].

Мөн Архангай аймгийн Цэнхэрийн халуун рашаан, Тайхар чулуу, Тэрхийн Цагаан нуур, Төв аймгийн Горхи Тэрэлжийн БЦГ, Өмнөговь аймгийн Булган, Сэврэй сумууд, Ёлын ам, Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант хийд, Өвөрхангай аймгийн Хархорин зэрэг газруудыг дотоодын жуулчны тооны улмаас дарамтанд байгаа газрууд гэж нэрлэжээ [4]. Одоо нэмж Хэнтийн аймгийн Дадал сум, Хамрын хийд болон Аварга Тосон, Хужирт, Шаргалжуутын рашаан зэрэг багагүй тооны газруудыг нэмж болно.

Аялал жуулчлалын хүчин чадал гэдэг нь *“Тухайн газар нутагт айлчилан ирж буй жуулчид хүрээлэн буй орчинд хамгийн бага хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж, дээд зэргээр сэтгэл ханамж авч чадах хамгийн зохимжтой түвшний хэмжээг хэлнэ”*[10]. Өөрөөр хэлбэл тодорхой газар нутгаар байгалийн иж бүрдэлд төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр өндөр сэтгэгдэлтэй аялж, зугаалах жуулчдын зохистой тоо юм. Монгол

орны нөхцөлд аялал жуулчлалын хүчин чадлыг хүн амын, дэд бүтцийн, уламжлалт ахуйн соёл, байгалийн иж бүрдлийн онцлогоор тодорхойлох нь зүйтэй. Аялал жуулчлалын хүчин чадлыг (АЖХЧ) тооны хэлээр илэрхийлбэл:

$$\text{АЖХЧ} = \text{Жуулчин хүлээн авч буй газар нутгийн хэмжээ} / \text{Дундаж стандарт хэмжээ}$$

Харин хүчин чадлын эрэлтийн коэффициенттэй харьцуулан үржүүлсэн үржвэр нь өдрийн аяллын нийлбэр юм. Энэ нь:

$$\begin{aligned} \text{Нэг өдөрт аялах хүлээн авах жуулчдын тоо} &= \text{Хүчин чадал} * \text{Эрэлтийн коэффициент} \\ \text{Эрэлтийн коэффициент} &= \text{Нэг өдөрт жуулчдыг хүлээн авах хугацаа} / \text{жуулчдын байрлах} \\ &\quad \text{дундаж хугацаа} \end{aligned}$$

Олон улсын төвшинд түгээмэл хэрэглэж буй энэхүү арга зүйд тулгуурлан Баянхонгор аймгийн аялал жуулчлалын голлох зорин очих газруудад даац тодорхойлох шаардлагатай бөгөөд рашаан сувиллын жишээг доор үзүүлээ.

Хүснэгт 17. Зорин очих газрын даацын үнэлгээ

ЖИШЭЭ. Улаан цутгалан орчмын даацын үнэлгээ. Хамрагдах газар нутгийн хэмжээ 2 га газар

Ойр хавьд байрлах жуулчны баазууд: Guest house – 12 жуулчин байрлах зочны гэр, нэг зочны гэр дунджаар 4 гэр, гэр тус бүр 3-4 ортой

Жуулчны бааз- 3 жуулчны бааз, нэг жуулчны бааз 12 гэр, гэр тус бүр 2 ортой

Улаан цутгаланг үзэн сонирхож байгаа жуулчидын дийлэнх хувь нь энэ газар 1 хонодог байна.

Нэг өдөрт хүлээн авах жуулчдын тоо

$$\text{АЖХЧ} = 20000\text{м}^2 / 100\text{м}^2 = 200$$

$$\text{Эрэлтийн коэффициент} = 11 \text{ цаг} / 3 \text{ цаг} = 3,7$$

$$\text{Нэг өдөрт хүлээн авах жуулчдын тоо} = 200 * 3,7 = 740 \text{ хүн}$$

Нэгж хугацаан дахь амрагчдын нягтыг олох дунджаар

$$D_n = \text{Ирж буй жуулчдын тоог/судалгаа хийгдэх газарын хэмжээ/ажиглах хугацаа}$$

$$D_n = \text{нэг цагийн хугацаан дахь амрагчдын нягт, хүн/га}$$

$$D_n = 350 / 2\text{га} / 24 \text{ цаг} = 7,5 \text{ хүн} / \text{га хцаг}$$

Нэг цагт үзүүлэх рекреацийн ачаалал

$$N_n = D_n * t$$

$$N_n = \text{нэг цаг дахь рекреацийн ачаалал, хүн/ га хцаг}$$

$$D_n = \text{нэг цагийн хугацаан дахь амрагчдын нягт, хүн/га}$$

$$T = \text{амрагчдын байх хугацаа}$$

$$N_n = 7,5 * 3 \text{цаг} = 22,5 \text{ хүн} / \text{га хцаг}$$

4.3. Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох

ҮНДСЭН ЗОРИЛТ: Олон улсын зах зээлд Монголыг өрсөлдөх чадвартай газар нутаг болгох зорилгоор дүр төрх, имиж, маркетинг, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Гадаад, дотоодын аялагчдыг хамгийн ихээр татахын тулд аялал жуулчлалын нөөц баялгаа зохистой ашиглах байдлаар Монгол улсаа дэлхийн топ зорих газар болохыг сурталчлах маркетингийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх,
- Гадаад, дотоодын жуулчдын тоог төдийгүй хоноглох хугацаа, нэг жуулчнаас орон нутагт орох орлогыг өсгөх, /Өнөөгийн байдлаар гадаадын жуулчдын орон нутагт өнгөрүүлэх дундаж хугацаа 1 – 2 хоног, дотоодын аялагчдын дундаж хугацаа 3 – 5 хоног байна/
- Жуулчид зочдыг халуун дотноор угтаж, тэднийг шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангаж, холбогдох үйлчилгээний захиалгыг авах үүрэг бүхий Жуулчны мэдээллийн төвүүдийг бэхжүүлэн, цаашид хөгжүүлэх,
- Зах зээлийн зорилтот хэсгүүдийн эрэлт хэрэгцээнд нийцэх бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх чадварыг сайжруулах,
- Үйлчлүүлэгчдэд хамгийн тохирсон борлуулалтын олон улсын сувгийг бий болгох, сайжруулах,
- Олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монголын аяллыг онлайн захиалгын системээр борлуулахад анхаарч, урьдчилсан захиалгын иж бүрэн системийг нэвтрүүлэх,

Бодлогын зөвлөмжүүд:

➤ **Зорих газрын хувьд Монголын ялгарах брэнд тэмдгийг тодорхойлох**

Одоогийн байдлаар Монгол нь олон улсын аялал жуулчлалын зах зээлд нэгдсэн ялгарах тэмдэггүй байгаа нь түүнийг үндэсний болон олон улсын хэмжээнд сурталчлах ажиллагааг хязгаарлаж байна. Иймээс нэгдмэл сэдэвтэй брэнд бий болгох нь үндэсний маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх маркетинг харилцааны шинэ стратегийн үндэс болно.

Олон улсын аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, арга хэмжээнүүдэд оролцохдоо тодорхой сэдвийн дагуу буюу Discover Mongolia, Visit Mongolia, Truly Nomads, Land of Blue Sky, Nomadic by Nature зэрэг уриаг бүрдүүлэн тэрхүү урианд нийцсэн брэнд тэмдгийг бүрдүүлэн оролцдог болох.

➤ **Зорилтот зах зээлийн сонголт ба Аяллын хэлбэр**

Олон улсын зах зээлийг сегментчлэх энгийн арга байхгүй тул Монгол улс нь тухайн харилцагчдад таатай байх үндэс, арга замаар сонголт хийх болно.

Сегментийг сонгох нь:

- 1) Монгол нь зорих газрын хувьд ямар байгаа, цаашид ямар болох,

- 2) Байж болох аялагчдын сегментийг судалж, Монгол нь энэхүү сегментийг хүлээн авч, аюулгүй байдлыг нь хангах сонирхолтой бөгөөд даацын хүчин чадалд нийцэх байдлыг тогтоох,
- 3) Бүтээгдэхүүн-зах зээлийн хослолын сонирхлын нийцийг тодотгох ажлуудын үр дүн байдаг.

Ерөнхийдөө зөвхөн Монголд аялах буюу эсвэл Орос, Хятадтай хослуулсан аяллын аль нь ч байж болно. Хослуулсан аялал нь Монголд дахин аялагчдыг нэмэгдүүлэх сайн талтай. Ийм аяллаар аялах газрууд, цаг хугацаа ба замнал нь аялал жуулчлалынханд тодорхой тул энэ бүлгийнхнийг татахад хялбар байж болно. ОХУ болон БНХАУ-ын холбогдох байгууллагууд, маркетингийн мэргэжилтнүүдтэй хамтарсан маркетингийн сурталчилгааг зохион байгуулснаар хослуулсан аяллын бүлгийг татахад хялбар болно.

Монголд бүлэг буюу багц аялагчид, эсвэл бие даасан аялагчид гэсэн хоёр төрлийн жуулчид давамгайлж ирдэг. Эдгээр жуулчдыг хоёр тусад нь авч үзэх шаардлагатай. Багц аялагчид нь зорих газрын тухай болон үйлчилгээний мэдээллүүдээ тур оператораас авдаг бол, бие даасан аялагчид эдгээр мэдээллүүдээ өөрсдөө олж авна. Иймээс мэдээж бие даасан аялагчдыг бодоход багц аялагчдыг татахад хялбар байна. Гэхдээ, аялал жуулчлалын болон бусад холбогдох мэдээллийн хангамжийг сайжруулах шаардлагатай.

Монгол нь А) Барууны зах зээл (Европ, АНУ, Австрали, Шинэ Зеланд), В) Азийн зах зээл (Япон, Өмнөд Солонгос ба хөрш орнууд), С) дотоодын зах зээлийг тус тус ойрын жилүүдэд зорилтот зах зээлээ гэж үзэх нь зүйтэй юм.

А) Барууны зах зээл

○ Европын зах зээл

Монголын маркетингийн үйл ажиллагааг Баруун Европт сайн тогтсон одоогийн харилцааг ашиглан явуулах нь зүйтэй болно. Франц, Нэгдсэн Вант улс, Герман ба Итали.

Европын хэвлэл, мэдээллээр Монгол нь аюулгүй, шинэ, нээгдээгүй байгаа соёлын сүлэлдээнтэй аялах газар болохыг үзүүлж байна.

○ АНУ-ын зах зээл

Европын зах зээлтэй харьцуулбал амралтын хугацаа нь бага, паспорттай иргэд нь бага байдаг болон цагийн зөрүү зэрэг шалтгаануудын улмаас АНУ-ын зах зээл нь арай ач холбогдол багтай байх талтай. Тэгээд ч холын зайд аялах хугацаанаас хамааран аяллын жинхэнэ хугацаа багатай байдаг.

АНУ-ын иргэд хослуулсан аяллыг илүү сонирхдог учраас Хятадын тур операторуудтай хамтран маркетинг хийж, аялал зохион байгуулбал илүү үр дүнтэй байна. Хэвлэл, мэдээллээр нь төдийлөн хангалттай сурталчилдаггүй тул АНУ-ын зах зээлд Монголын тухай ерөнхий мэдээллийг илүү сайн хүргэх шаардлагатай.

○ *Австралийн зах зээл*

Австрали нь жижиг боловч цаашид тун ирээдүйтэй зах зээл юм. Хол зайтай байдаг нь гол асуудал бөгөөд Гонконг, Япон, Сөүлээр дамжиж ирэх нь илүү дөхөмтэй.

Зөвлөмжүүд

Монгол улс цаашдаа Европын зах зээлд илүү анхаарах нь зүйтэй байна. Баруун Европын аялагчид Европын нийт зах зээлд илүү давамгайлах болно.

Дунд хугацаанд Зүүн Европоос аялагчид төдийлөн өсөхгүй боловч тэдний өөрсдийнх нь амьдралын түвшин нэмэгдмэгц аялагчид өсөх хандлагатай. Энэ үед тэдний аяллын эрэл хэрэгцээ нь Баруун Европынхонтой ижил болно.

Европын зах зээлийг авч үзэхдээ Дани, Швед, Норвеги, Финлянд улсуудын зах зээлийг цаашид тусад нь авч үзэх хэрэгтэй.

Барууны зах зээлд дээд зэргийн бүтээгдэхүүний стратегийг боловсруулж хөгжлүүлэх шаардлагатай. Бүтээгдэхүүнийг одоогийн эрэлт хэрэгцээ ба зах зээлийн цаашдын чиг хандлагыг харгалзан бий болгох ёстой.

В) Азийн зах зээл

○ *Төв Ази ба БНХАУ-ын хөрш орнууд*

Хятадын зах зээл нь цаашид улам сонирхол татах болно. Одоогоор хөрш зэргэлдээ байрлалаас шалтгаалан Хятадаас Монгол руу амралтаар аялагчдын тоо хязгаарлагдмал байгаа бөгөөд ижил төсөөтэй зүйлүүд олонтой Өвөр Монгол нь өрсөлдөгчийн шинжтэй байна.

Казахстан нь Баруун Монголтой хиллэдэг бөгөөд эдийн засаг нь хөгжиж байна. Энэ замналаар хийх аяллууд болон наймаа худалдаа нь чухал ач холбогдолтой.

Оросын зах зээл нь наймаа, худалдааны үйл ажиллагаа давамгайлах шинжтэй байгаа ба Оросын бизнес аялагчид Монгол руу галт тэргээр юм уу автомашинаар ирцгээдэг.

○ *Зүүн Ази*

Японы зах зээл нь Азийн хамгийн чухал зах зээл болно. Энэ нь зөвхөн Улаанбаатарын нисэх онгоцны буудалд буух зорчигчдын тоогоор бус мөн хамгийн их орлого оруулагчид (бэлэг, дурсгал худалдан авах байдал) төдийгүй

аяллын зайн хувьд хол бус, Монголын бөхчүүд асар их нэр хүндтэй байдаг зэрэг шалтгаантай.

Түүнчлэн, монголын үндэсний болон англи хэлний дараа япон хэл гуравдах түгээмэл хэл болсон ба Япон улсаас Монголын эдийн засгийн хөгжилд бодитой тусламж үзүүлдэг.

Өмнөд Солонгос нь аялал жуулчлалын бизнесийн босоо интеграци (Солонгосын агаарын тээврийн компани, солонгосын тур оператор, солонгос хөтчүүд, солонгос зочид буудал) болон соёлын зарим муу нөлөөллөөс шалтгаалан тийм ч чухал бус зах зээл юм.

Зөвлөмжүүд

Одоо Монголын амьдрал болон Монголын бөхчүүдэд тулгуурлан Японы зах зээлд төвлөрч ажиллах нь чухал байна.

Хятадын багц аялагчдад визийн хөнгөлөлт үзүүлэх, боломжийн үнэтэй бүтээгдэхүүн санал болгох замаар Хятадын зах зээлд ажиллах боломжтой. Ингэхдээ нэг их өргөжүүлэлгүй одоогийн хүчин чадал, бололцоондоо үндэслэвэл зохино.

Мөн Өвөр Монголтой хамтарсан маркетинг явуулах, бүтээгдэхүүн бий болгох нь өргөн бололцоог нээж өгнө. Монголын түүхэн эх сурвалжуудийг ч Хятадын зах зээлд цаашид санал болгож болно.

Хилээр дамжин өнгөрөх аяллыг Казахстаны зах зээлд цаашид сурталчлах хэрэгтэй.

Бизнес аялагчдад мөн цөөн тооны загаслах аялагчдад (fly fishing) зориулсан хандлагыг Оросын зах зээлд хэрэгжүүлэх шаардлагатай.

С) Дотоодын зах зээл

Эдийн засгийн хөгжлийн байдалтай уялдан Монголчуудын аяллын төр байдал, хандлагад өөрчлөлт гарах бөгөөд хүмүүс одоо байгаа аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг илүү үндэслэн аялах болно.

Дотоодын хамгийн боломжтой аяллын төрлүүд нь:


- Хувиараа аялах аяллууд
- Тойрон аяллууд
- Найз нөхөд, хамаатан садныдаа айлчлах аялал
- Эрүүл мэнд, сувиллын аяллууд
- Өвлийн аяллууд
- Өөрөө майхантай аялах

- Адал явдалт аяллын бүх төрлүүд
- Байгалийн аяллууд
- Чингис Хааны түүхийн аяллууд
- Хурал, зөвлөлгөөн, уулзалтын
- Шашин, мөргөлийн аяллууд
- Дунд сургууль төгсөгчид, сурагчдын танилцах аяллууд
- Хамт олноороо аялах аяллууд зэрэг болно.

➤ **Идэвхжүүлэлтийн оновчтой багцыг бүрдүүлэх**

- Олон улсын жуулчдын зах зээлийн сегмент тус бүрээр хэрэглэгчийн зан төлөвийн нарийвчилсан судалгаа хийж, идэвхжүүлэлтийн бодлогыг тодорхойлох
- Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсоны дараах жуулчдын тооны өсөлт болон орлогын өсөлтөд дүн шинжилгээ хийж хэвших
- Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцох гарын авлагыг жил бүр шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагуудад тараах
- Зар сурталчилгаанд онлайн хэлбэрийг түлхүү ашиглах, төрийн болон бизнесийн байгууллагуудын вебийн бүтцийг ёайжруулах, урьдчилсан захиалга хийх боломжийг бүх түвшинд хангахаас гадна оролцогч талуудын линкийг нэмэгдүүлэх
- Технологийн дэвшлийг ашиглан гар утсанд гадаадын болон дотоодын аялагчдад зориулсан аялал жуулчлалын мэдээлэл авах аппликейшнүүдийг суулгах
- Орон нутгийн нөхөрлөлүүд болон НИТАЖ – ын талаарх мэдээллийг жуулчдад хүргэх асуудалд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх
- Гадаад сурталчилгааны ажилд төрийн болон үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд, гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэдийг татан оролцуулах, тэдний дэмжлэг, оролцоог түшиглэн олон талт сурталчилгааг зохион байгуулах
- Монгол орны ТХГН – уудар аялсан аяллын нэвтрүүлгүүдийг зорилтот зах зээлийн гол хэл дээр бэлтгэн гадны телевизүүдэд санал болгох
- Шууд маркетингийг аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдэд түлхүү ашиглах
- Сошиал медиаг зар сурталчилгаанд ашиглах

Зураг 8 . Аялал жуулчлалын зар сурталчилгаанд сошиал медиа ашиглах боломж



4.4.Зорих газрын дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

ҮНДСЭН ЗОРИЛТ: Монголын аялал жуулчлалын дэд бүтцийн төрөл, чанарыг сайжруулах.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Аялал жуулчлалын дэд бүтцийг нутгийн иргэд, зочлогчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд хохиролгүйгээр хөгжүүлэх,
- Монголын түүхэн ба нүүдэлчин уламжлалыг хадгалахын зэрэгцээ тухайн газар нутгаар тав тухтай зорчих хэрэгслийг сонгох бололцоотойгоор тээвэр, газар ашиглалтын системээр хангах,
- Зах зээлийн эрэлт хэрэгцээнд хүчин чадал, бололцоотой тээврийн хэрэгслээр хангах,
- Дэд бүтцийн хөгжлийн шинэ төслүүдийг хэрэгжүүлэхдээ байгаль орчныг хамгаалах,
- Байгаль орчинд эвсэг экологийн ач холбогдолтой тээвэр, байрны хэрэгслүүдийн хөгжлийг дэмжих,
- Аялал жуулчлалын улирлыг уртасгахад чиглэсэн үзэх зүйлүүдийг бий болгох, хөгжүүлэхийг улам дэмжих.

Бодлогын зөвлөмж:

Одоогийн зам тээврийн дэд бүтцийг боломжийн хирээр цаашид сайжруулах шаардлагатай байна. Хучилтгүй замуудад засвар үйлчилгээ хийж найдвартай, аюулгүй болгох нь зүйтэй. Хөдөө орон нутагт зам тээврийн аюулгүй байдлыг дээшлүүлэхэд тэмдэгжүүлэлт хийх, GPS буюу газар зүйн мэдээллийн системийг өргөнөөр ашиглах, үүрэн телефоны барих хүрээг өргөжүүлэх, эрж хайх, авран хамгаалах ажиллагааг

нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ авах нь хамгаас чухал байна. Орон нутгийн найдвартай нислэгийн үйлчилгээ байгаа нь аялал жуулчлалын хөгжилд ялангуяа өндөр үнэтэй, тусгай сонирхлын аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх таатай боломж олгож байна.

Монгол улсад одоогоор зам тээвэр, аялал жуулчлалын дэд бүтэц сулхан хөгжсөн нь бэршээл учруулж байгаа боловч энэ байдлыг өөрчлөх боломжтой. Монгол орны аялал жуулчлалын гол нөөц, бүтээгдэхүүн газрууд нь заавал хатуу хучилттай замын сүлжээтэй байхыг шаардахгүй онцлогтой. Жуулчдын машинд заавал GPS хэрэглэж байх, үүрэн телефоны үйлчлэх хүрээг өргөтгөх, хайх аврах үйлчилгээг хүртээмжтэй байлгах зэрэг заавал баримтлах норм журмыг бий болгож чадвал зам тээврийн аюулгүй ажиллагааг сайжруулах боломжтой.

Соёлын болоод байгалийн үзэсгэлэнт газрууд, түүний орчмын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө, дэд бүтцийг хөгжүүлэх нь Монголын байгаль соёлын өв болсон газар нутгууд, аялал жуулчлалын үнэт зүйлсийг хадгалан хамгаалахад зайлшгүй чухал.

Энэ чиглэлээр хийх шаардлагатай ажил нь:


- Агаарын харилцаандшинэ агаарын тээвэрлэгч компаниудыг Монголд оруулах ба аялал жуулчлалыг өргөжүүлэх
- Иргэний агаарын тээврийн олон улсын нислэгийн хуваарь, үнийг аялал жуулчлалын салбарын хөгжлийн өнөөгийн байдал, чиг хандлагад үндэслэн, холбогдох ТББ, хувийн хэвшилтэй харилцан тохиролцох замаар урьдчилан тогтоох нөхцөлийг дэмжих
- Аялал жуулчлалын гол зам, маршрутын дагуу замын тэмдэг, тэмдэглэгээг нэгдсэн стандартаар сайжруулах ажлыг зохион байгуулах
- Зам, тээврийн хөгжлийн бодлого, шинэ нисэх онгоцны буудлын төлөвлөлтөнд аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага, эрэлт хэрэгцээг тооцсон албан уулзалт зохиох
- Дотоодын зорчигч тээврийнүйлчилгээг сайжруулах, нэгдсэн захиалгын системд оруулах
- IT болон үүрэн телефоны оператор компаниуд,төр, орон нутгийн байгууллагуудтай хамтран газар нутаг, байршлын GPS, зам тодорхойлох, цаг агаарын болон бусад мэдээллүүдийг чөлөөтэй авч ашиглах, шаардлагатай нөхцөлд авран хамгаалах ажилд хэрэглэх боломжийг байнгын оршин суугчид, жуулчдад бүрдүүлэх зэрэг болно.

➤ **Авто замын сүлжээ, ашиглалт, цаашдын бодлого**

Аялал жуулчлал нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, төвлөрлийг сааруулах, орон нутгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, түүгээрээ дамжуулан эдийн засгийн өсөлтийг бий болгохчухал салбарын нэгд тооцогддог. Гадаадын жуулчид төдийгүй, дотоодын аялагчдын хувьд аялал жуулчлалын үйлчилгээг авах гол хүчин зүйлийн нэг нь аюулгүй тээвэр, авто замын асуудал байдаг. Монгол улсын авто

замын сүлжээг авч үзвэл, эдийн засгийн таван бүс болох УБ, баруун, зүүн, төвийн, хангайн бүсүүдийн хувьд тэнцвэргүй байдалтай байна. Монгол улс нь Азийн авто замын сүлжээнд гурван үндсэн чиглэлээр буюу “мянганы зам”, “босоо тэнхлэгийн авто зам”, “хэвтээ тэнхлэгийн авто зам” гэсэн чиглэлүүдээр холбогдсон байдаг. Хөгжлийн дээрх таван бүсийг холбосон замуудыг сонгон авахдаа ирээдүйн бүсийн зах зээлийн хөгжил, олон улсын боомтуудтай уялдах байдал зэргийг харгалзсан байна. Хэдийгээр авто замын сүлжээ нь бүсүүдийг холбох гол гүүр болж байгаа боловч, аймгийн төвүүдийг холбосон гол замууд дийлэнх хувийг эзэлж буй учир жуулчдын хувьд тааламжтай нөхцлийг бүрдүүлж чадахгүй байна. Замын нөхцлийн үзүүлэлтийг авч үзэхэд сайн үнэлгээтэй замын эзлэх хувь одоогийн байдлаар 50 хувиас хэтрэхгүй үзүүлэлттэй байгаа нь дараах зургаас харагдаж байна.

Зураг 9. Замын нөхцлийн үзүүлэлт /өнөөгийн байдал, ирээдүйн төлөв/



Эх сурвалж: Үндэсний зам, тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого, 2008

Монгол улсын Азийн авто замын сүлжээнд холбогдох 3 үндсэн чиглэл нь,

1. Сибирийн бүсийн зах зээлийг Монгол улсын нутаг дэвсгэрээр Алтанбулаг /ОХУ – тай хил залгаа хилийн боомт/ - Дархан – Улаанбаатар – Налайх – Чойр – Сайншанд – Замын Үүд /БНХАУ – тай хил залгаа хилийн боомт/ чиглэлийн авто замаар БНХАУ – ын эргийн олон улсын далайн боомтуудтай холбох
2. Сибирийн бүсийн зах зээлийг баруун босоо тэнхлэгийн буюу Цагааннуур /ОХУ – тай хил залгаа боомт/ - Өлгий – Ховд – Ярант ын чиглэлээр БНХАУ – ын Шинжаань Уйгарын Өөртөө Засах орны зах зээлтэй холбох
3. Зүүн хязгаарыг баруун хязгаартай холбох, цаашлаад Солонгосын хойгоор дамжин өнгөрөх Азийн авто замтай холбогдох хэвтээ тэнхлэгийн буюу Ховд – Улиастай – Улаанбаатар – Чойбалсан – Сүмбэр – Нөмрөг – ийн чиглэлүүд байна.

Дээрх 3 чиглэлийн авто замын сүлжээг хөгжүүлсэнээр

- ✓ Гадаад худалдаа эрхлэх боломж нэмэгдэх

- ✓ Зүүн Хойд Азийн бүсийн зах зээлд нэвтрэх, хямд өртөгтэй бараа таваараар хангагдах боломж бүрдэх
- ✓ Хоёр буюу түүнээс дээш худалдааны гарцтай болсноор олон улсын зах зээлийн үнээр тээвэрлэлт явуулах боломж бүрдэх
- ✓ Гадаадын жуулчид болон дотоодын аялагчдын чөлөөт хөдөлгөөн бий болох боломж бүрдэх боломжтой болно хэмээн үзсэн байна.

Хүснэгт 16. Замын нөхцлийн мэдээлэл


Захиргааны түвшин	Хатуу хучилттай		Хучилтгүй			Бүгд
	Бетон	Асфальт бетон	Хайрган	Сайжруулсан хөрсөн	Хөрсөн	
Улсын	56.6	2007.3	1508.4	1312.3	6282.6	11136.2
Орон нутгийн	55.0	276.0	498.0	499.0	36637	38031
Бүгд	111.6	2283.3	2006.4	1811.3	42919.6	49186.2

Эх үүсвэр: ЗТАЖЯ-ны мэдээлэлд тулгуурлан Зөвлөхүүд гаргав, 2007

Тайлбар: Орон нутгийн чанартай замын уртыг өөрчлөөгүй.

Замын нөхцлийн байдлыг бүсүүдээр нь авч үзвэл, хөрсөн замын хувьд төвийн бүс замынхаа 55 хувьд хөрсөн ба сайжруулсан хөрсөн замтай байхад баруун бүс хамгийн өндөр буюу 82 хувьтай байна. Зүүн бүсийн хувьд замын 63 хувь нь, Хангайн бүсийн хувьд 29 хувь нь хөрсөн зам байна.

Зураг 10. Замын төрлүүд /бүсээр/



Монгол улсын авто замын сүлжээний гол хэсэг болох мянганы замын тухайд, 2008 онд өдрийн дундаж хөдөлгөөний эрчим (ӨДХЭ) замын баруун хэсгүүдэд өдөрт 300-с 600 тээврийн хэрэгсэл, төв ба зүүн хэсэгт 300-с 400, зүүн хязгаарт 100-с бага тээврийн хэрэгсэл өнгөрч байсан бол 2028 он гэхэд ӨДХЭ баруун хэсгүүдэд 1550-с 3000-д хүрч нэмэгдэх, төв болон зүүн хэсгүүдэд 1500-с 2000, Хятадын хилтэй ойр зүүн хэсгүүдэд 400 болж өснө хэмээн үзсэн байна. Үүнээс үндэслэн авто замын сүлжээг өргөтгөх бодлогыг Монгол улсын засгийн газраас баримтлан “Монгол улсын тээврийн стратеги 2005 - 2015”, “Авто замын ерөнхий төлөвлөгөө 2008 – 2020” бодлогын баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Авто замын ерөнхий төлөвлөгөөнд дунд хугацааны хөтөлбөр буюу 2011–2015 онуудад авто замын сүлжээнд холбогдоогүй байгаа, тээвэр ашиглалтын зардал өндөртэй замуудыг сайжруулах, УБ, Орос, БНХАУ – тай хил залгаа орших харилцаа муутай аймгийн төвүүдийг хооронд нь холбох асуудлыг шийдэхээр тусгасан байна.

➤ **Иргэний нисэхийн үйлчилгээ, цаашдын бодлого**

Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэлх баримтлах бодлогыг 2013 онд баталсан бөгөөд АЖ – ын харилцаанд шууд нөлөөлж болохуйц дараах гол зорилтууд байна.

- Хөшигтийн хөнгөнд олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барьж, ашиглалтанд оруулах. Энэхүү буудал нь 2016 онд бүтээн байгуулалтын ажил дуусч, ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байгаа бөгөөд 250 – 350 зорчигч суулгасан Боинг, Аэробус зэрэг хүнд даацын онгоц хүлээн авах хүчин чадалтай буудал болно. Одоогийн “Чингис хаан” буудлын нисэх, буух зурвасын ашиглалт 73 хувьтай байдаг бол шинэ буудал ашиглалтанд орсоноор ашиглалтын хувь нэмэгдэх болно. Энэхүү буудал ашиглалтанд орсоноор жилдээ 22000 онгоц буулгахаас гадна 12 сая зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болохоор төлөвлөгдөж байна.
- Монгол улсыг чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг 2016 онд 2012 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлэх.
- Европын Холбооны гишүүн оронтой байгуулсан хоёр талын агаарын харилцааны хэлэлцээрт тээврийн 5 дугаар эрхийг хэрэгжүүлэх.
- Мөрөн, Ховд, Чойбалсан, Даланзадгад хотын нисэх буудлын хатуу хучилттай зурваст өргөтгөл хийж олон улсын 4С ангиллын буудал болгох.
- Сайншандад олон улсын зэрэглэлийн нисэх буудал байгуулах.
- УБ хотод “Эйрсервис интернейшнл парк” байгуулах.

4.5. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих

ҮНДСЭН ЗОРИЛТ: Олон улсын зах зээлд Монголыг өрсөлдөх чадвартай газар нутаг болгох зорилгоор дүр төрх, имидж, маркетинг, зохион байгуулалтын бүтцийг сайжруулах.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Зорилтот зах зээлд чиглэсэн бүтээгдэхүүний ялгарлыг бий болгосноор жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Гадаад, дотоодын аялагчдыг хамгийн ихээр татахын тулд аялал жуулчлалын үзмэр газруудад хүрч очих бололцоо, аюулгүй байдлыг хангах,
- Монголын аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар шинэ зах зээл, шинэ зорилтот бүлгүүдийг татах,
- Зах зээлийн зорилтот хэсгүүдийн эрэлт хэрэгцээнд нийцэх бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх чадварыг сайжруулах,
- Монголын аялал жуулчлалын сор бүтээгдэхүүнийг бий болгож, зах зээлд сурталчлах,
- Адал явдалт, экологийн баримжаат Тусгай сонирхлын болон танин мэдэхүйн аяллын төрлүүдийг илүү түлхүү дэмжин хөгжүүлэх,

Бодлогын зөвлөмжүүд:

- ✓ Дэлхийн хэмжээний ТСАЖ газар болох төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх,
- ✓ ЮНЕСКО-гийн биет болон биет бус соёлын өвийн аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх,
- ✓ Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих санхүүжилтийг бий болгох дэс дараатай, байнгын арга хэмжээг авах,
- ✓ Аялал жуулчлалын одоогийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх буюу сайжруулахад төрөөс ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлтэй зээлэнд тур оператор, жуулчны баазуудыг хамруулах,
- ✓ Үлэг гүрвэлийн үндэсний музейг орчин үеийн дизайн, технологиор байгуулах,
- ✓ Эвент, арга хэмжээний тоо, чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн соёл урлаг, спортын болон аялал жуулчлал, орон нутгийн байгууллагуудын хамтын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг төрөөс эргэн төлөгдөх болон бусад нөхцөлөөр дэмжих шаардлагатай байна.
- ✓ Аяллын галт тэрэг, зориулалтын тусгай автобусны үйлчилгээг улам сайжруулах нь чухал ач холбогдолтой.
- ✓ Монголын үндэсний бэлэг дурсгал, бараа бүтээгдэхүүнийг чанар, үнийн хувьд улам сайжруулж, сор бүтээгдэхүүнийг “баталгаат” болгон шошгожуулах.

➤ **Зорих газруудыг төрөлжүүлэн хөгжүүлэх**

Зорих газрын хувьд Монгол нь жуулчдын сонирхлыг татах чадвар өндөр бөгөөд энэ нь цаашдаа ч улам нэмэгдэх хандлагатай байна. Гол анхаарах асуудал бол цаашид шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоосоо илүү одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулан хөгжүүлэх явдал болно. Одоо байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулан,

шинийг санал болгохын тулд бүс нутгуудын төлөвлөлтийг хийхдээ жуулчдын зорих газрыг бий болгох үйл ажиллагааг анхаарах ёстой болно. Үүнд:

- Одоогийн зорих газруудыг бэхжүүлэх
 - Төв Монгол - Өвөрхангай, Архангай, Булган
 - Говь – Дундговь, Өмнөговь
 - Баруун Хойд – Хөвсгөл
- Шинээр бий болсон газрууд
 - Баруун – Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан
 - Зүүн – Хэнтий, Сүхбаатар, Дорнод
- Төрөлжүүлэлт
 - Зүүн хэсэгт – Түүх_ соёлын ба идэвхтэй аяллууд
 - Баруун хэсэгт – Адал явдлын, уулын спортын, идэвхтэй, соёлын (угсаатны) аяллууд
 - Төвийн хэсэгт – Байгалийн, шашны, түүхийн болон уралдаан тэмцээн-аяллууд
 - Өмнөд хэсэгт – Танин мэдэхүйн (антропологи, палеотологийн) ба байгалийн аяллууд гэсэн төлөвлөлтийг хийх нь зүйтэй юм.

➤ Бүтээгдэхүүний стратеги

Жуулчдын сэтгэл хөдөлгөж татах, аяллын хэв шинжэд гарч буй өөрчлөлтүүдийн дагуу зорилтот бүлгүүдэд чиглэсэн дараах стратегиудыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Одоогийн санал болгож байгаа бүтээгдэхүүний төрөлжилт (санваартны аялал, нэмэгдэл үйл ажиллагаанууд бүхий эко-аялал, үзмэрүүд)
- Шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, хурал, зөвлөлгөөний аялал, Нутгийн иргэдэд тулгуурласан ба дотоодын аялал жуулчлалыг дэмжих.
- Стандартжуулалт. Үр өгөөж, тооцоолох байдал, харьцуулах бололцоо, урьдчилан төсөөлөлт ба хяналтуудыг үйлчлүүлэгчид бий болгох зэрэг давуу талуудтай.
- Мэргэшүүлэлт. Өрсөлдөгчдөөс ялгагдах тусгай зохицуулалт, үзмэрүүд, онцгой хэмжүүрүүд зэрэг болно.
- Бүтээгдэхүүний иж бүрдэлт. Өнөөгийн сонирхол, хүслийн багц ба үйл ажиллагаанд нийцэхүйцээр амралтын үйл ажиллагааг олон талт болгох.
- Үе шатлал. Нэмэлт орчин ба сэтгэл хөдлөлүүд үүсгэсэн ердийн бус аяллууд нь үе шатлал бүхий бүтээлч бүтээгдэхүүнүүд байна.
- Чанарыг сайжруулах ба үзмэрийн баяжилт. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулан, байжуулах нь Хархорин, Говь, Архангайн Тэрхийн Цагаан нуур, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Увс, Хэнтий гэсэн жуулчдын гол аялдаг газруудад заавал чухал болно.

Одоогийн ба ойрын ирээдүйн аялал жуулчлалын бүтээгдэхүүний талаар Голланд улсын Засгийн Газрын СВІ байгууллагын захиалгаар 2012 онд хийсэн судалгааны дүн

шинжилгээнээс үзэхэд, олон улсын аялал жуулчлалд өрсөлдөх чадвар өндөртэй бөгөөд жилийн өсөлт их байгаа Монголын аяллын төрлүүд нь амралт чөлөөт цагийн (Leisure) ба адал явдалт (Adventure) аяллууд байна (Хүснэгт17). Монгол улс адал явдалт аяллын индексээр дэлхийн 164 орноос 17-д эрэмблэгдсэн байгаа нь энэ төрлийг хөгжүүлэх бүрэн бололцоотой болохыг харуулж байна [7].

Хүснэгт 17. Аялал жуулчлалын төрлүүд ба өсөлтийн таамаглал

Аялал жуулчлалын гол төрлүүд	Голлох зах зээл	Өндөр өсөлт, (жилд 5%-аас дээш)	Дундаж өсөлт, (жилд 2-5%)	Бага өсөлт, (0,5-2%)	Зэрэглэл
Амралт, чөлөөт цагийн аяллууд	БНХАУ, БНСУ, Япон, АНУ, ХБНГУ, Франц, Англи, Голланд, Итали, Бельги.	√			1
Байгалийн аялал жуулчлал	ХБНГУ, Голланд, Англи, АНУ, Бельги		√		3
Адал явдалт аялал жуулчлал	АНУ, Итали, Австри, Голланд	√			2
Рашаан, сувиллын аялал жуулчлал	ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ			√	5
Соёлын аялал жуулчлал	БНСУ, Япон, Евродын орнууд, Австрали, Канад	√			3
МIСЕ аялал жуулчлал	Канад, Англи, АНУ, ХБНГУ	√			4
НИТАЖ	Европын орнууд, АНУ, Австрали		√		4

Монгол улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай төрлүүдээс гадаад, дотоодын зах зээлд илүү танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд цаашид Монголын аялал жуулчлалын сор бүтээгдэхүүн болж хөгжих боломжтой зарим бүтээгдэхүүн, арга хэмжээнүүдийг 18–р хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 18. Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой бүтээгдэхүүнүүд

Байгалийн өвд тулгуурласан аяллууд	Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд	Тусгай сонирхлын аяллууд	Рашаан, сувиллын аяллууд	MICE аялал жуулчлал
Говь-Хангайн аяллууд	Үндэсний Их Баяр-Наадам	Улаанбаатар марафон	Хэнтий-Аварга Тосон	Олон улсын хурал, зөвлөлгөөн
Эко аяллууд	Дээлтэй Монгол	Мөсний баяр	Өвөрхангай-Хужирт	Спортын уралдаан, тэмцээн
Үүргэвчтэй аялал	Буриад зоны Алтаргана наадам (2 жилд нэг удаа)	Автомашин, мотоциклийн ралли-уралдаан	Баянхонгор-Шаргалжуут	Бүс нутгийн арга хэмжээнүүд
	Наурызын баяр	Шувуу ажиглах, Динозаврын аялал		Үзэсгэлэн, яармагууд
	Адууны баяр, тэмээний баяр, сарлагийн баяр	Ууланд авирах		
	Цагаан сар	Шинэ оны анхны нар харах галт тэрэгний аялал		
	Бүргэдийн баяр (Ш,Х)	Тэмээн поло		
	Казах зан заншил, ахуйн аялал	Буян хураах мөргөлийн аялал		

Тусгай сонирхлын аялал жуулчлал

Тусгай сонирхлын аялал жуулчлалыг дэмжиж хөгжүүлэх нь Монгол улсад тэргүүлэх ач холбогдолтой байх юм. Олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монголын аялал жуулчлалыг авч үзвэл, үндсэндээ **niche tourism products** буюу тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлүүд өрсөлдөх чадвар өндөртэй байгаа юм. ТСАЖ-г хөгжүүлснээр Монгол улсын Засгийн Газар 1) аяллын улирлын хуагцааг сунгах, ирээдүйд дөрвөн улирлын жуулчлалыг хөгжүүлэх, 2) жуулчдын улам бүр өсөн нэмэгдэж байгаа онцлог, тусгай сонирхол бүхий аяллуудыг нэмэгдүүлэх, 3) Дахин аялж ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх бололцоо байгаа анхаарч, төрийн бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Монголд хөгжиж байгаа, цаашид өрсөлдөх чадвар өндөртэй ТСАЖ-д дараахь аяллууд, бүтээгдэхүүнийг хамруулан ойлгоно. Үүнд:

1. Адал явдалт аялал /Adventure /
2. Байгалийн аялал/Wild life /
3. Нүүдэлчний ахуйн аялал /Nomad/
4. Хурал зөвлөлгөө, үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох /MICE/
5. Шувуу ажиглах /Bird watching/
6. Тэмээн поло /Camel polo/
7. Шашин, мөргөлийн аялал /Pilgrimage/spiritual/
8. Эрүүл мэнд, сувилал /Medical, wellness/
9. Гольф тоглох /Golf/
10. Үлэг гүрвэлийн мөрөөр /Dino/ зэрэг болно.

ТСАЖ-г төрөөс бодлогоор дэмжих хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- ТСАЖ-н бүс, орныг тодорхойлох
- ТСАЖ-н бүтээгдэхүүн бий болгож, хөгжүүлэх тур операторуудыг ангилан дэд бүлэг болгох
- ТСАЖ-н төрлүүдийг хөгжүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн гаалийн татвараас чөлөөлөх
- ТСАЖ-н хөтөч, зааварлагч нарыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, аттестатчлах оновчтой механизмыг бүрдүүлэх зэрэг болно.

➤ Тогтвортой аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепц

Аялал жуулчлалын кластерын ба аялал жуулчлалын коридорын онолуудад үндэслэн Монгол улсын аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн концепцийг боловсруулан хөгжүүлэх нь хамгийн зөв үндэслэл байх юм [11][13].

Тогтвортой аялал жуулчлалыг Хотын, Говийн, Хангайн, Хөвсгөлийн гэсэн үндсэн дөрвөн **кластерын бүсүүдээр** төрөлжүүлэн хөгжүүлэх төлөвлөлтийн концепцийг 4-р х авсралтанд зургаар, төлөвлөгөөний хуваарийг 15-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 19. Бүтээгдэхүүний хөгжлийн төлөвлөлтийн хуваарь

Кластер бүхий бүсүүд	Аяллын төрлүүд	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Өвөрхангай төвтэй Хангайн бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд							
	Тусгай сонирхлын							

	аяллууд							
	Рашаан, сувиллын аяллууд							
	МIСE аялал жуулчлал							
Өмнөговь төвтэй Говийн бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	<i>Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд</i>							
	Тусгай сонирхлын аяллууд							
	<i>Рашаан, сувиллын аяллууд</i>							
	МIСE аялал жуулчлал							
Хатгал төвтэй Хөвсгөлийн бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	<i>Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд</i>							
	Тусгай сонирхлын аяллууд <i>/өвлийн мөсний баяр-аялал/</i>							
	<i>Рашаан, сувиллын аяллууд</i>							
	<i>МIСE аялал жуулчлал</i>							
Улаанбаатар төвтэй Хот орчмын бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд <i>/хотын аялал/</i>							
	Тусгай сонирхлын аяллууд							
	<i>Рашаан, сувиллын аяллууд</i>							
	МIСE аялал жуулчлал							
Ховд төвтэй Баруун бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд							
	Тусгай сонирхлын аяллууд <i>/уулын аялал/</i>							
	<i>Рашаан, сувиллын аяллууд</i>							
	<i>МIСE аялал жуулчлал</i>							
Хэнтий төвтэй Зүүн бүс	Байгалийн үзэсгэлэн, өвд тулгуурласан аяллууд							
	Соёлын өв, нөөцөд тулгуурласан аяллууд							
	Тусгай сонирхлын аяллууд							

	аяллууд							
	Рашаан, сувиллын аяллууд							
	МIСE аялал жуулчлал							

➤ **Үйлчилгээний чанарыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх**

Олон улсын аялал жуулчлал эрчимтэй хөгжиж олон улсын жуулчдын тоо нэг жилд 1 тэрбум давсан өнөөгийн шатанд жуулчид аялан зорих газраа сонгож, аяллыг худалдан авах тухай шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл бол зах зээлд сурталчлан амлаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын асуудал юм. Үйлчилгээний чанар нь *үйлчилгээний ажилтнуудын ур чадвар ба мотиваци, хүний нөөцийн хөгжлийн бодлого, менежмент, сургалт зааварчилгааны түвшин, мэдээллийн технологи, инновацийн үйл ажиллагаанаас хамаардаг нэгдмэл цогц процессийн үр дүн* байдаг. Монгол улсад үйлчилгээний чанарын стандартын тогтолцоог сайжруулж, төрийн болон хөндлөнгийн үнэлгээний механизмыг хослуулан хэрэгжүүлэх нь үр дүнтэй байж болох юм. Иймд:

- Зочид буудал, жуулчны бааз, ресторан зоогийн газрын стандартуудыг шинэчлэх
- Таксины стандартыг боловсруулах
- Үйлчилгээний стандартын үнэлгээчин-шалгагч нарыг тусгайлан бэлтгэх
- Үйлчилгээний байгууллагуудыг олон улсын чанарын стандартын хөтөлбөрт хамруулах
- Байгал орчин, нийгмийн хариуцлагын стандарт, хэмжүүрийн орчинг дэмжин сурталчлах
- Үйлчилгээний чанарын стандартыг зохих шатанд хангасан байгууллагын үйл ажиллагааг дэмжих оновчтой механизмыг бий болгох зэрэг арга хэмжээнүүдийг санал болгож байна.

4.6. Хүний нөөцийн хөгжил, сургалт, судалгааг хөгжүүлэх

ҮНДСЭН ЗОРИЛТ: Үйлчилгээний дээд зэргийн чанарыг үзүүлэхэд шаардагдах ур чадвартай хөдөлмөрлөх хүчнийг аялал жуулчлалын салбарт бий болгох.

БУСАД ЗОРИЛТУУД:

- Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн байрлуулах салбарын үйл ажиллагааг сайжруулах,
- Аялал жуулчлалын хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирэгсдийн тоо, чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг дэмжих,
- Хүний нөөцийн янз бүрийн түвшний мэдлэг, ур чадварыг илэрхийлэх чадавхийг хэмжих хэмжүүрийг ашиглах,
- Аялал жуулчлалын төрийн салбарын хүний нөөцийн хөгжил, ойлголтын ухамсрыг нийгэмд дээшлүүлэх,
- Салбарын хуучин ба шинэ төрлийн бизнесийн үйл ажиллагаануудад зориулж, маркетингийн менежментийн хандлагуудаас суралцах замаар зах зээлийн өрсөлдөх чадварыг сайжруулах,
- Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн боловсрол, сургалтыг улам бэхжүүлэх.


Бодлогын зөвлөмж:

- Аялал жуулчлалын салбарт шууд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээг тодотгох,
- Албан тушаал, мэргэжлийн тодорхойлолтыг баталгаажуулах
- Аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн зах зээлийн хандлагын талаар статистик мэдээллийг ажиллах хүчний судалгаагаар гаргаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх
- Салбарын хүний нөөцийн бодлого, хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах
- Их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрүүд төдийгүй мөн мэргэжлийн сургалт, түүний дотроос аяллын хөтчийн сургалтын стандартыг тогтоох, үнэлгээ хийх
- Аялал жуулчлалын багш, сургагч нарын мэргэжлийг дээшлүүлэх, тэднийг цаашид мэргэжлийн аттестатчлалд хамруулах
- Аялал жуулчлалын судалгааны санг бий болгож, судлаач нарыг сонгон шалгаруулах замаар судалгааны ажлын тэргүүлэх чиглэлүүдийг тогтоож ажиллах
- Холбогдох төрийн байгууллагууд, бизнесийг дэмжигч ТББ-ууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг салбарын хүний нөөцийн өрсөлдөх чадварыг сайжруулахад идэвхтэй ашигласан үйл ажиллагааг явуулах зэрэг болно.

➤ **Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн стратеги**

Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн стратегийг боловсруулахад аялал жуулчлалын салбарын хөдөлмөр эрхлэлт, ажилтнуудын албан тушаал, мэргэжлийн мэдлэг, ур чадварын үнэлгээг хийж, эрэлт хэрэгцээг өргөн хүрээнд тодорхойлох шаардлагатай болно. Үүнд дараах асуудлуудыг хамааруулна.

- Аялал жуулчлалын салбартай хамаарах боловсрол, сургалтын өнөөгийн байдлын дүн шинжилгээ
- Аялал жуулчлалын салбарын өсөлтийн таамаглалд үндэслэн оролцогч талуудын хүний нөөцийн одоогийн ба ирээдүйн эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг (шинээр бий болох эсвэл өөрчлөгдөж байгаа ажлын байр, шаардлагатай шинэ ур чадварууд, эрэлт хэрэгцээ ба ханган нийлүүлэлтийн харьцаа зэрэг) тодорхойлох
- Төр, засгаас аялал жуулчлалын талаар баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай хүний нөөцийн төлөвлөлтийн асуудлууд
- Хүний нөөцийн хөгжлийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих мониторингийн системийг бий болгох
- Аялал жуулчлалын салбарын бүх шатны сургалтыг сайжруулах, магадлан итгэмжлэл болон бусад хэлбэрээр сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, дүгнэлт хийх механизмыг бий болгох.

 **Аялал жуулчлалын хүний нөөцийн стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах**

Аялал жуулчлалын хүний нөөцийн стратеги нь “биет буюу hardware” ба “биет бус буюу software” хэмээн нэрлэх хоёр үндсэн нөөцөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээ, төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнгээс шууд хамаарах болохыг зураг 11-ээс харж болно.

Зураг 11. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн сургалт



Аялал жуулчлалын хүний нөөцийн бодлого төлөвлөлтөнд анхаарал татаж байгаа асуудлуудын нэг бол өндөр мэдлэг, чадвартай ажилтнуудыг тогтвортой ажиллуулах явдал юм. Сүүлийн жилүүдэд уул уурхай зэрэг өндөр цалин хөлс олгодог зарим салбарт ажлын байрны тоо эрчимтэй нэмэгдсээр байгаатай холбоотойгоор чадварлаг менежер, орчуулагчид, тогооч зэрэг ажилтнууд өөр салбарт шилжин ажиллах нь нэмэгдэх хандлагатай байна.

Өөр нэг асуудал бол ажилтныг ажилд авах практик, хүний нөөцийн мэдээлэл солилцоо хангалтгүй байдлаас үүдэлтэйгээр нэг байгууллагад хариуцлагагүй ажиллаад халагдсан хүн өөр байгууллагад буюу эсвэл байгууллага дамжин ажлын байрыг сольж, сайн ажилтан авах орон тоог хаадаг явдал үйлчилгээний түвшний ажилтнуудын дунд байнга гарсаар байна. Бусад салбаруудын практикаас үзэхэд, салбарын хүний нөөцийн нэгдмэл мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцоог сайжруулснаар “муу” хүнийг ажилд авахгүй байх гарцыг олж шийдвэрлэсэн нь аялал жуулчлалын салбарт ч хэрэглэх бүрэн боломжтой юм.

Салбарын хөдөлмөр эрхлэлтийн судалгааг дэмжих

Монголын аялал жуулчлалын өнөөгийн ба цаашдын хөгжлийн нэг тулгамдсан асуудал нь салбарын хүний нөөц, хөдөлмөр эрхлэлтийн шинэчилсэн судалгаа байхгүй байгаа явдал юм. Үндсэндээ бид 2000 онд Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн “Монголын аялал жуулчлалын стратеги”, Япон улсын ЖАЙКА хөтөлбөрийн “Аялал жуулчлалын мастер

төлөвлөгөө”-ний тайлангуудаас хойш хүний нөөцийн ямар нэгэн дорвитой судалгаа хийгээгүй гэж хэлэхэд болно.

2010 онд Голландын Засгийн Газрын дэмжлэгээр эхэлсэн “Аялал жуулчлалын экспортыг дэмжих” төслийн хүрээнд нийт 50 томоохон тур операторуудын дунд явуулсан судалгааны дүнгээс тур операторуудын хүний нөөцийн талаар гарсан зарим үр дүнг авч үзвэл:

Судалгаанд хамрагдсан тур оператор компаниуд Монгол улсын аялал жуулчлалын салбарын захирал, менежерүүдийн 30% нь эрэгтэй, харин 70% нь эмэгтэй байна.

- Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй удирдах ажилтнуудын 60 гаруй хувийг 40 хүртэлх насны залуучууд эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан тур операторууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй ба 8.0% нь улирлын ажилтнуудыг оролцуулаад 101 - ээс дээш ажилтантай Монголын зах зээлд томоохонд тооцогдох тур операторууд бол 80% нь 11-100 ажилтантай, үлдсэн хэсэг нь 1-10 ажилтантай жижиг тур операторууд байна.

- Судалгаанд хамрагдсан тур операторуудын 96% нь ажилчдын тоо хангалттай ба цаашид нэмэгдэнэ гэж хариулсан нь энэ салбарт цаашид ажилтнуудын тоо буухааргүй тогтвортой байх ба чадварлаг ажилчид нэмж авах эрэлтэй байгаа юм.

- Мөн 53% нь ажилчидаа тогтвортой ажиллуулж байгаа нь эдгээр компаниудын хувьд ажиллаж буй ажилтнууд нь харьцангуй тогтвортой ажиллах боломж байна.

Дээр өгүүлсэн Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаанаас үзэхэд 2010 оны аялал жуулчлалын салбарт 13000 хүн ажиллаж, улмаар 2015 он гэхэд 17000 илүү хүмүүс ажиллаж байхаар тооцсон байна. Мөн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний прогнозыг жилд 3-4 мянга байхаар тооцсоныг хүснэгт 16 – аас харж болно.

Хүснэгт 20. Аялал жуулчлалын салбар дахь хүний нөөцийн эрэлт

	2006-2010 онууд	2011-2015 онууд	Салбарт эзлэх %
Тур оператор, аяллын агентуудад	186	226	5,2
Аяллын хөтөч-гид	406	495	11,4
Зочид буудал	601	906	20,9
Гэр бааз	1098	1596	36,8
Тогооч, жолооч	173	212	4,9
Зоогийн газар, баар, шөнийн клуб	619	899	20,7
Дүн	3083	4334	100

Энэ тооцооноос үзэхэд аялал жуулчлалын үйлчилгээний салбарт хамгийн их ажлын байр бий болох хандлагатай байна.

2010 оны байдлаар улсын ба хувийн хэвшлийн 40 гаруй их, дээд сургуулиуд, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн 40 гаруй төвүүдэд аялал жуулчлал, зочид буудлын мэргэжлээр дунд шатны 3, бакалаврын дээд боловсролын 11, магистрын түвшний боловсролын 8, нийтдээ 20 илүү сургалтын хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Эдгээр сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, бүтэц, төлөвлөлт, хичээлийн агуулга зэрэг нь нийгмийн болон ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцээгүй, багшлах боловсон хүчин залуу, ном, сурах бичиг, материаллаг бааз муу, үйлдвэрлэлийн ба сургалтын практик дадлага алдагдсан зэрэг нь нийтлэг байдалтай байгаа юм.

Хэдийгээр их, дээд боловсрол эзэмших нь ирээдүйн ажил, мэргэжилд сайнаар нөлөөлнө гэсэн түгээмэл ойлголт хүүхэд залуучууд, тэдний эцэг эхчүүдэд байгаа ч аялал жуулчлалын хөтөлбөрөөр их, дээд сургууль төгсөгчдийн тоо нь тэдэнд зориулсан ажлын байрны тооноос илүү олон байна.

Тур операторуудын хувьд 2010 оны судалгаагаар аялал жуулчлалын мэргэжлээр төгсөгчид нийт судалгаанд хамрагдагсдын 30%-ийг эзэлж, мөн 30%-ийг гадаад хэлний мэргэжлээр төгссөн менежерүүд эзэлж байгаа нь гадаад хэлний мэдлэгтэй боловсон хүчин энэ салбарт ажиллах нь мэргэжлийн хүмүүстэй адил илүү өргөн боломжтой байгааг харуулж байна.

Монголд статистикийн бүх асуудлыг Статистикийн Төв Газар (СТГ) хариуцдаг. Хилийн шалган өнгөрүүлэх бүртгэлийн хуудаснаас авсан мэдээнд түшиглэн гадаадаас ирсэн зочдын тоо, хаанаас ирсэн болон ирсэн зорилгыг нэгтгэн гаргадаг. Бүх зорчигчдын 30 хувь нь чөлөөт цагийн аялагчид гэж гарч байгаа боловч дээр дурьдсанчлан энэ тоог хэрэглэхдээ болгоомжтой хандвал зохино. Харин бие даан зорчигчид ирсний дараа хаагуур аялж байгаа талаар мэдээлэл байхгүй тул аяллын төрөл, хэлбэрийн талаар мэдээллийн цоорхой бий болдог. Статистикийн мэдээ авах хоёрдох эх сурвалж нь СТГ-аас аж ахуйн нэгжүүдийн дунд явуулдаг судалгаа болдог. Асуулгын аргыг ашиглан олж буй ашиг, ажилчдын тоо, үйлчлүүлэгчдийн тоо зэргийн талаар мэдээлэл авдаг. Салбараас ДНБ-д оруулж буй нөлөөллийг үнэлэхэд ашиглаж байгаа СТГ-ын аргачлалд зочид буудал, ресторан болон тээврийн байгууллагуудын мэдээлэл хамрагддаггүй учраас аялал жуулчлалын эдийн засгийн үр нөлөө бүрэн хэмжээгээр гарч чаддаггүй байна.

- Үйлчилгээний соёл болон бусад дутагдалтай байгаа тусгай ур чадваруудыг тусгай мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж шийдвэрлэх боломжтой. Орон нутгийн аж ахуй эрхлэгчид болон жижиг үйлчилгээ үзүүлэгчидэд тэдний бизнесийн төлөвлөлт, менежментийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт явуулах шаардлагатай байна. Үүнийг

бэлтгэгдсэн багш, сургагч бүхий сургалтын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй.

- Эрүүл мэндийн халамж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үзүүлэх, аюулгүй байдлыг хангах зэрэг жуулчдад зориулсан нийгмийн үйлчилгээний чанар дорой байна. Салбарын тэргүүний байгууллагууд нь энэ асуудлыг дотооддоо шийдвэрлэх арга хэмжээ авч, байгууллагадаа анхны тусламжийн хичээл заах, аялалд эмч (зарим тохиолдолд АНУ болон Европоос) авч явах, олон улсын аялал тээврийн даатгал хийлгэхийг шаардах (ихэнхдээ SOS Интернейшинл) болжээ. Хэрэв Монголд жуулчдыг татахыг хүсч байгаа бол ялангуяа төлбөрийн өндөр чадвартай жуулчдыг ирүүлэхийг хүсч байгаа бол эдгээр дутагдлыг арилгахын тулд хууль эрх зүйн өөрчлөлтүүдийг хийж, салбарын чадавхийг дээшлүүлэх шаардлагатай байна. Хөтөч-тайлбарлагчийг сургах, аврах үйл ажиллагаа бий болгох, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зэргээр зохих шатны чадавхийг бий болгох нь хамгийн чухал байна.

Хэрэгжилтийн хяналт үнэлгээ

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлснээс хяналт шалгалт ба үнэлгээний арга зүйг тогтооно. Хяналтууд нь:

- Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэлтээр харагдах хоёр жилд нэг удаа зохиох Улаанбаатарын аялал жуулчлалын форум;
- Соёл, Спорт, Аялал Жуулчлалын Яамны Аялал Жуулчлалын Газар нь Монголын аялал жуулчлалын хөгжлийг болон үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг жил болгон тайлагнаж байна. Энэхүү тайланг бүх хамтрагч байгууллагуудад хүргүүлнэ;
- Монголын аялал жуулчлалын асуудлаар үйл ажиллагааны шаардлагатай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор хамтарсан судалгаануудыг явуулах;
- Тухайн жилийн амжилт болон бусад холбогдох асуудлыг хэлэлцэх зорилгоор Улаанбаатар хотноо жил бүр тайлан уулзалтуудыг зохион байгуулах.

11-р хүснэгтэнд тодорхойлогдсон зорилго ба гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн дагуу Аялал Жуулчлалын Форум нь хоёр жилд нэг удаа явагдана.

Хүснэгт 21. Үйл ажиллагааны хөтөлбөр

Үзүүлэлтүүд	Одоогийн байдал	Зорилт	Хаана
Хангамжийн үзүүлэлтүүд			
Байр, сууц	Зочид буудлын өрөөнүүд	Зочид буудлын өрөөнүүдийн тоог нэмэгдүүлэх	Улаанбаатар
	Гэрүүд	Жуулчны баазуудыг тоо, чанарын	Орон нутагт

		хувьд сайжруулах	
Хэрэгцээний үзүүлэлтүүд			
Улирлын хамаарал	Жуулчлалын нийт аяллуудаас улиралд ноогдох %	Европоос хийх аяллуудыг улирал бүр одоогийн түвшинд хадгалах. Гол улирлаас бусад үед хийх аяллыг жигд хуваарилах.	Хот
Дүүргэлт	Жилийн дүүргэлтийн %: Зочид буудлын өрөөний дүүргэлтүүд зочны байрууд гэрүүдийн дүүргэлтүүд	Байрны нөхцөлийг нэмэгдүүлэх байдлаар одоогийн түвшинг хадгалах (орны хураамж)	Улаанбаатар
Жуулчдын үзэх үзмэрүүдийн тоог нэмэгдүүлэх	Монголд ирсэн жуулчдын гол үзмэрүүдийн тоог нэмэгдүүлэх	Жуулчдын үзэх зүйлүүдийг одоогийн байдлаар нь хадгалах буюу нэмэгдүүлэх	Хот
Хүний нөөцийн үзүүлэлтүүд			
	Ажиллагсдын тоо: 2012 онд 24.000 байна	Зочид буудлуудад техник үйлчилгээний ажлын байрыг 10-20% нэмэгдүүлэх.	Улаанбаатар

6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

6.1.Зорих газрын оновчтой засаглал, институцын тогтолцоог сайжруулах

№	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
1	Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийг шинэ бүрэлдэхүүнээр байгуулж ажиллуулах	Засгийн Газрын түвшинд холбогдох Яамд, Газрууд болон аймаг, нийслэлийн төрийн захиргааны аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах бодлогыг зохицуулах	ССАЖЯ	ЭЗХЯ, БОНХЯ, ЗТЯ, ГХЯ, БШУЯ, УБ АЖ – ын байгууллага, холбоодууд	дунд	2014 оноос эхлэн хагас жил бүр тогтмол хуралдаж, шийдвэр гаргах
2	Холбогдох Яамд, төрийн захиргааны байгууллагуудад аялал жуулчлалын асуудал эрхэлсэн нэгж/ажилтныг ажиллуулах	Яамд, төрийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа, холбоог сайжруулж, нэгдсэн бодлогын хамаарах асуудлуудыг хариуцуулна.	ССАЖЯ	ЭЗХЯ, БОНХЯ, ЗТЯ, ГХЯ, БШУЯ, УБ	дунд	Ажлын чиг үүрэг, төлөвлөгөөг 2014 онд багтаан батлах
3	Аймаг, нийслэлийн түвшинд аялал жуулчлалын зөвлөлийг хувийн болон бусад холбогдох талуудын оролцоотойгоор байгуулж, ажиллуулах	Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих бүтцийг бий болгоно.	Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг Даргын Зөвлөлүүд	ССАЖЯ, БОНХЯ, МАЖХ	чухал	Улирал бүр хуралдаж, холбогдох асуудлаар зөвлөмж гаргах
4	Аялал жуулчлалын гол бүсүүдийн ТХГН-ын (Тэрэлж, Говь Гурвансайхан, Орхоны Хөндий,	Зорих газрын менежментийн байгууллагын статусыг албан ёсоор тодорхойлж, маркетингийн эрх үүргийг шилжүүлэх	БОНХЯ		чухал	2015-2016 онуудад 5 төвийг бий болгоно.

	Хөвсгөл)хамгаалалтын захиргаанд түшиглэн “Зорих газрын менежментийн төвүүд” байгуулах			ССАЖЯ ТХГНУГ		
5	Аялал Жуулчлалын Үндэсний мониторингийг хөгжүүлэх	Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн системийг бий болгох	АЖҮТ	ССАЖЯ БОНХЯ	дунд	2015 оноос, мониторингийн тайлан
6	Аялал жуулчлалын төрийн ба бизнесийг дэмжигч ТББ-уудын менежмент, чадавхийг сайжруулах	Аялал жуулчлалын төрийн ба бизнесийг дэмжигч байгууллагуудад олон улсын төсөл хэрэгжүүлэх замаар чадамжийг сайжруулна.	АЖҮТ	ССАЖЯ, олон улсын байгууллага, хандивлагчид	чухал	2015 оноос
7	Төрийн байгууллагууд: Зорих газрын менежментын сургалтууд	Холбогдох төрийн албан хаагч ба аялал жуулчлалын шийдвэр гаргагчдын сургалт, семинарыг зохион байгуулах	АЖҮТ	ССАЖЯ, (их сургуулиуд, гадаад дотоодын зөвлөхүүд); Мэргэжлийн холбоодууд	дунд	2015 оноос эхлэн жил бүр

6.2.Тогтвортой аялал жуулчлалыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах зарчмаар хөгжүүлэх

Но	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
1	Монгол улсын тогтвортой аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр боловсруулах	Үндэсний хэмжээнд аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичигтэй болно.	ССАЖЯ	БОНХЯ, АЖТХТ	Маш чухал	Үндэсний хөтөлбөр, 2014 онд
2	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, сөрөг нөлөөллийг багасгах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Аялал жуулчлалын гол бүсүүдэд аялал жуулчлалын сөрөг нөлөөллийг багасгах хөтөлбөрийг боловсруулна	БОНХЯ	ССАЖЯ, ЗТЯ, БШУЯ, УБ	чухал	2014 оноос эхлэн гол 5 бүсүүдэд нэвтрүүлэх
3	Ногоон	Аялал жуулчлалын тур		ЭЗХЯ,		Хөтөлбөрийг 2014

	гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	оператор, жуулчны бааз, зочид буудлуудыг ногоон гэрчилгээжүүлэлтэнд хамруулна.	ССАЖЯ	БОНХЯ, МҮХАҮТ, УБ	дунд	онд багтаан боловсруулж, 2015 оноос хэрэгжүүлэх
4	Түүх, соёлын өвүүдийг хадгалж хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих бүтцийг бий болгоно.	ССАЖЯ	БШУЯ, Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг Даргын Зөвлөлүүд	чухал	Улирал бүр хуралдаж, холбогдох асуудлаар зөвлөмж гаргах
5	Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын төслүүдэд байгаль орчин, нийгэм соёлын нөлөөллийн үнэлгээ хийх механизмыг бий болгох	Хөрөнгө оруулалтын төслүүдэд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн амьдралын хэв маяг зан заншлын сөрөг нөлөөллийг багасгах, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.	ЭЗХЯ	ССАЖЯ, Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг Даргын Зөвлөлүүд	чухал	Холбогдох журмыг 2014 онд боловсруулж, 2015 оноос бүрэн хэрэгжүүлэх
6	Аяллын төрлүүд болон орон нутгийн амралтын цогцолбор, зочид буудлуудыг бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөгөөр хөгжүүлэх	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөтэй болно.	ССАЖЯ	ЭЗХЯ, БОНХЯ, Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг Даргын Зөвлөлүүд	дунд	Төлөвлөгөөг 2015 онд боловсруулж, 2016-2020 онуудад хэрэгжүүлнэ.
7	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих санхүүгийнх үүсвэрийг бий болгох	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих өрсөлдөх чадвартай зээлийн нөхцөл, бололцоог бий болгох.	ЭЗХЯ, Арилжааны банк	ССАЖЯ	дунд	2016 оноос
8	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сургалт	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжих хүрээнд зорих газруудын эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэх туршлагыг солилцож аялал	АЖҮТ	ССАЖЯ, холбогдох аймгууд	дунд	2014 оноос

		жуулчлалын үйлчилгээг сайжруулна.				
9	Ажилгүйчүүдэд: Богино хугацааны сургалтууд	Зочлох үйлчилгээний салбарын техникийн түвшинд ажил хайгчдад зориулсан богино хугацааны мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах.	АЖҮТ	ХЯ	чухал	Жил бүр
10	Аялал жуулчлалын туслах дансны тооцоо: Ажлын хэсэг байгуулах	Статистикийн хэмжүүрийн системийг бүрдүүлэх: Үндэсний статистикийн байгууллагын хүрээнд аялал жуулчлалын хиймэл дагуулын тооцоог бүрдүүлэх, байгуулах.	Ажлын хэсэг	ССАЖЯ, ҮСХ, Монгол банк	Маш чухал	2015 оноос

6.3. Зорих газрын менежмент, дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

№	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
1	Аялал жуулчлалын топ аймгууд, газар нутгуудын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг нэгтгэн өөрчлөх	Улаанбаатар хот, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Архангай, Булган аймгуудын аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг үндэсний түвшинд уялдуулан өөрчлөх	Холбогдох аймаг, нийслэлийн аялал жуулчлалын зөвлөлүүд	ССАЖЯ, БОНХЯ, МАЖХ	чухал	2014-2015 онууд
2	Аялал жуулчлалын хоёрдогч газар нутгуудын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг тогтвортой хөгжлийн зарчмаар боловсруулах	Хэнтий, Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь зэрэг аймгуудын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг Үндэсний аялал жуулчлалын хөгжлийн бодлогын дагуу шинээр боловсруулна.	Холбогдох аймаг, нийслэлийн аялал жуулчлалын зөвлөлүүд	ССАЖЯ, БОНХЯ, МАЖХ	Дунд	2016-2018 онууд, 5-8 аймгууд
3	Хууль эрх зүйн болон даатгалын хүрээнд	Гадаад, дотоодын жуулчдын аюулгүй байдал, хамгаалалтыг	АЖҮТ	ССАЖЯ, ХЗЯ	чухал	2015 оноос

	жуулчныаюулгүй байдлыг хангах	хангах зорилгоор Жуулчны цагдаагийн үйл ажиллагааг өргөтгөж, даатгалын журмыг шинэчлэх.				хэрэгжүүлнэ.
4	Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүй, бизнесийн орчныг бий болгох	Аялал жуулчлалын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд таатай орчныг бүрдүүлнэ.	ССАЖЯ	ЭЗХЯ, ХЗЯ	Маш чухал	2015-2016
5	Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын форумыг зохион байгуулах	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татна.	ССАЖЯ	ЭЗХЯ	чухал	2016-Улаанбаатар, 2018-Баруун бүс
6	Аялал жуулчлалын салбарт мэдээлэл, холбооны технологийн дэд бүтцийг өргөнөөр оновчтой нэвтрүүлэх	Жуулчдад зориулсан Монголын аялал ба үйлчилгээний онлайн системийг нэвтрүүлж, зорих газрын тусгай вэб портал, гар утасны аппликэшн хөгжүүлнэ.	ССАЖЯ	МХХГ, АЖҮТ	дунд	2014 оноос
7	Газрын тээвэр: Дэд бүтцийг сайжруулах	Замын байдал хүнд ба аялах, хүрч очих нөхцөл хүнд байдгаас шалтгаалан аялал жуулчлалаар зорих гол газруудын газрын тээврийг сайжруулах	ЗТЯ	ССАЖЯ	чухал	2014 оноос
8	Агаарын тээвэр: Олон улсын нислэгүүд	Олон улсын зорчигч тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тарифийг бууруулах боломжийг судлах	ЗТЯ	ССАЖЯ	чухал	2015 оноос
9	Зочлогчдын үзэх зүйлүүд: Хөрөнгө оруулалтын шаардлагыг тодорхойлох	Гадаадын хөрөнгө оруулалтыг шууд татах зорилгоор аялал жуулчлалын үзэх зүйлүүдийн стратегийн төлөвлөгөө ба судалгааг бий болгож хөгжүүлэх	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2015
10	Зочлогчдын үзэх зүйлүүд: Таних тэмдгүүдийг	Аялал жуулчлалын онцлон сонирхсон газруудын үндэсний хүрээлэнд зориулсан таних	ЗТЯ			2014 оноос

	тодорхойлох чиглэлүүд	тэмдэгүүдийг бий болгож хөгжүүлэх (Жуулчны мэдээлэл, гэр баазууд, хандивлагчдын чиглэл хандлага)		ССАЖЯ	чухал	
11	Жуулчны гудамж: Явган хүмүүст зориулсан хэсгийг сайжруулах	Гол хүмүүсийг улам татаж чадахуйцаар явган хүмүүст зориулсан хэсгийг сайжруулж жуулчны гудамжийг хөгжүүлэх	УБ захиргаа	ССАЖЯ	Дунд	2014-2016
12	Ариун цэвэр: Бололцоог нэмэгдүүлэх	Улаанбаатар хот болон Тэрэлж, Хархорин, Хөвсгөл зэрэг жуулчдын зорих гол газруудад нийтийн бие засах үйлчилгээг бүрдүүлэх:	АЖҮТ	ССАЖЯ, аймгууд	Чухал	2014-2016
13	Урлагийн үзмэрүүд ба музей түүнийг сайжруулалт	Боломжит стандартад хүргэх зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа урлагийн газрын музейнуудыг сайжруулах.	УБ захиргаа	ССАЖЯ	дунд	2015-2018
14	Судалгаа: Гэр баазын даацын бололцоо	Монголын гэр баазуудын байгаль орчны даацын хүчин чадлын судалгаа хийх	АЖҮТ	ССАЖЯ	Дунд	2015

6.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих

№	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжил						
1	Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг шинэчлэх	Аялал жуулчлалын үйлчилгээний чанар сайжирна.	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2014 оноос эхлэн 1-2 стандартуудыг шинэчлэнэ.
2	Монгол улсад ТСАЖ-г хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах	ТСАЖ-ын топ өрсөлдөгч болно.	ССАЖЯ	БОНХЯ	дунд	2015 оны эхний хагас, мастер төлөвлөгөө
3	Аймгууд болон аялал жуулчлалын бүс	Жилд нэгээс (нийт6) доошгүй		ССАЖЯ, АЖҮТ,		

	дамжсан бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах хэлэлцүүлгийг дараахь сэдвүүдээр зохиох: <ul style="list-style-type: none"> Зах зээл Маркетинг, сурталчилгаа, Online Marketing Ногоон буюу эко гэрчилгээжүүлэлт Харилцагчийн үйлчилгээ 	бүсчилсэн хэлэлцүүлэг болно.	АЖҮТ	Холбогдох аймгууд	дунд	Улаанбаатар-2014, Хангай-2015, Говь-2016, Хөвсгөл-2017, Баруун бүс-2018, Зүүн бүс-2019
4	Үндэсний аялал жуулчлалын шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг шалгаруулах журам боловсруулж хэрэгжүүлэх	Аялал жуулчлалын сор бүтээгдэхүүнийг бий болгоно.	АЖҮТ	ССАЖЯ, МАЖХ, МЗБХ	дунд	Сор бүтээгдэхүүн, 2014 оноос эхлэн
5	Аялал жуулчлалын бүс, аймгуудад бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарлыг бий болгох	Зах зээлийн сегментүүдэд тохирсон ялгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлнэ.	Аймаг, нийслэлийн АЖ зөвлөлүүд	ССАЖЯ, АЖҮТ, МАЖХ, МЗБХ	дунд	2015 оноос
6	Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын судалгаа явуулах	Олон улсын нийтлэг практик, зөвлөмжийн дагуу чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ,	чухал	2014 оноос эхлэн гурван жил тутам
7	ТСАЖ-ын аялагчдын судалгаа явуулах	Тусгай сонирхлын аялагч, жуулчдын эрэлт хэрэгцээ, бүтээгдэхүүний чиг хандлагыг тодорхойлно.	АЖҮТ	ССАЖЯ	дунд	2016

8	Ан агнуур: Тогтвортой байдлыг баталгаажуулах	Монголын маркетингийн албан ёсны сурталчилгаанаас хамаарахгүйгээр ан агнуурын ажлыг тогтвортойгоор зохицуулах (хязгаарлагдмал тооны маш сайн хяналтын дор) Ан агнуурыг хэт хөгжүүлбэл ан агнуурыг эвдэх аюултай.	БОНХЯ	ССАЖЯ	Дунд	2015
Нүүдэлчдийн соёл, ахуйн аяллыг НИТАЖ-ын үндсэн хэлбэр болгон хөгжүүлэх						
9	Нүүдэлчдийн соёл, ахуйн аяллыг хөгжүүлэхэд дэмжлэг болох үндэсний стандартыг бий болгох	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын стандарттай болно.	АЖТХТ	ССАЖЯ	дунд	2015
10	Монголын нүүдэлчний аяллын маршрутыг тогтоох	Нүүдэлчний аяллын газрын зургийг хэвлэх	АЖҮТ	ССАЖЯ, АЖТХТ	бага	2016
11	Нүүдэлчдийн соёлын аяллын шилдэг бүтээгдэхүүнийг хөгжүүлэх санг бий болгох	Нүүдэлчний соёлын аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх сантай болно.	ССАЖЯ	UNDP, USAID, WB, GIS зэрэг донорууд	дунд	2014-2015
12	Тэмээний баяр, Сарлагийн байр, Мөсний наадам, Цагаан Сарыг олон улсын аялал жуулчлалын тодорхой зах зээлд соёлын аяллын тусгай бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, байршуулах	<ul style="list-style-type: none"> Төлөвлөлт, зохион байгуулалт, үйлчилгээг сайжруулах Мэдээллийн сувгуудийг бүрэн ашиглах 	Зохион байгуулагчид	ССАЖЯ, МАЖХ, холбогдох аймгууд	дунд	2014 оноос
Адалт явдалт аяллуудыг мэргэжлийн түвшинд хүргэх						
13	Адал явдалт аялал жуулчлалын	“Адал явдалт аяллыг 2015-2020 онуудад хөгжүүлэх төлөвлөгөөг”	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2015 он

	төрлүүдийг Монголд хөгжүүлэх боломж, газар нутгууд болон зах зээлийн судалгаа хийх	боловсруулах				
14	Адал явдалт аяллуудын аюулгүй байдлын стандартыг боловсруулах	Адал явдалт аяллын аюулгүй байдлыг хангах үндсийг бүрдүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ, СХЗГ	дунд	Q1-Q2, 2015
15	Адал явдалт аяллын бааз-төвүүдийг хөгжүүлэх	Тусгай сонирхлын, нэн ялангуяа уулын аяллын хөтөч-зааварлагч нарыг бэлтгэх	АЖҮТ	ССАЖЯ, Ховд аймаг	дунд	Улаанбаатар, Ховд, 2015-2016
16	Адал явдалт аяллын зааварлагч, сургагч нарыг бэлтгэх, давтан сургах тогтолцоог бүрдүүлэх	Үндэсний сургагч, багш нарыг гэрчилгээжүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ	бага	2016 оноос
“Үлэг гүрвэлийн мөрөөр” аяллуудыг бий болгох						
17	Үлэг гүрвэлийн музейн (Улаанбаатар ба Баянхонгор) төсөл боловсруулах	Шинээр үлэг гүрвэлийн музейтэй болно.	ССАЖЯ	АЖҮТ, Баянхонгор аймаг	дунд	2014-2015
18	Үлэг гүрвэлийн олдвор, үзмэрүүдийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох	Үлэг гүрвэлийн аяллын бүтээгдэхүүнийг бий болгоно.	ССАЖЯ	БШУЯ, ШУА	дунд	2015 он
19	Үлэг гүрвэлийн аяллын бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг хийж, тодорхой сегментэд сурталчлах, байршуулах	Үлэг гүрвэлийн аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ.	АЖҮТ, тур операторууд	ССАЖЯ	чухал	2016 оноос
20	Үлэг гүрвэлийн аяллын хөтөч-тайлбарлагчыг бэлтгэх, сургах	Үлэг гүрвэлийн аяллын хөтөч-тайлбарлагч нарыг гэрчилгээжүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2015
Шувуу ажиглах аяллууд						

21	Шувуу ажиглах аяллыг Үндэсний аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	Шувуу ажиглах аяллыг хөгжүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ, БОНХЯ, МУИС, ШУА	дунд	2014-2015
22	Шувуу ажиглах аяллын бүтээгдэхүүний ялгарлыг бий болгох	<ul style="list-style-type: none"> • Шувуу ажиглах аяллууд • Шувууны зураг авах • Судалгааны зорилгоор шувууг байгальд ажиглах • Шувуу хамгаалах санг дэмжих хандив цуглуулах • Хунгийн чуулган • Шувуу ажиглагчдын баяр (<i>Ornis Mongolica in June</i>) 	АЖҮТ	ССАЖЯ, МУИС, Нийгэмлэг	дунд	2015
23	Шувуу ажиглах аяллын тур оператор компаниудыг мэргэшүүлэх	Мэргэшсэн тур операторуудыг гэрчилгээжүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ	дунд	2015-2017
24	Шувуу ажиглах аяллын хөтөч-тайлбарлагчдыг бэлтгэх, сургах	Шувууны аяллын хөтөч-тайлбарлагч нарыг гэрчилгээжүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ	дунд	2015
4 улирлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх						
26	Цагаан сар, Тэмээний баяр, Мөсний баяруудыг олон улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон төлөвлөн хөгжүүлэх	Өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сайжруулан хөгжүүлнэ.	АЖҮТ, Зохион байгуулагчид	ССАЖЯ, холбогдох аймгууд	Чухал	2014-2016
27	Монголын аялал жуулчлалын үзэсгэлэн (ITM), зочлох үйлчилгээний (HORECA) үзэсгэлэнг	Зүүн Хойд Азийн бүсийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний төв болно.	АЖҮТ, МАЖХ, МЗБХ, Нийслэлийн АЖГ	ССАЖЯ	дунд	2015 оноос жил бүр

	бүс нутгийн чанартай арга хэмжээ болгон хөгжүүлэх					
28	Намрын улиралд говийн аяллыг эвент арга хэмжээтэй уялдуулан хөгжүүлэх, хаврын улиралд рашаан сувиллын аяллуудыг дотоодын зах зээлд хөгжүүлэн сурталчлах	Дотоодын аялал жуулчлалын зах зээлд хавар, намрын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг байршуулах	АЖҮТ	ССАЖЯ, ЭМЯ, Холбогдох аймгууд	чухал	Q3, 2014
29	Шашин мөргөл, буяны аяллуудыг хийд, шашны байгууллагуудтай хамтран гадаад, дотоодын зах зээлд хөгжүүлэх	Шашин мөргөлийн аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгож хөгжүүлэх	АЖҮТ	ССАЖЯ, Тур операторууд, хийдүүд	дунд	2014
30	Өвөл, хавар, намрын улиралд идэвхитэй аялал, хөнгөлөлттэй үйлчилгээг үзүүлдэг аялал жуулчлал, зорчигч тээвэр, үйлчилгээний байгууллагуудыг сурталчлах, дэмжих хөшүүрэг бий болгох	Жуулчны идэвхитэй бус удирлуудад үйл ажиллагаагаа хэвийн явуулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх байгууллагад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ.	ССАЖЯ	Холбогдох Яам, газрууд	чухал	2015 онд шинж журам Q4, 2014

6.5. Аялал жуулчлалын зах зээлийг өргөжүүлэх үндэсний маркетингийг бий болгох

No	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
1	Монголын аялал жуулчлалын маркетингийн төлөвлөгөө,	Аялал жуулчлалын маркетингийн төлөвлөгөө, тайланг олон улсын	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2015 оноос эхлэн

	тайланг жил бүр боловсруулан хэрэгжүүлэх	түвшинд хийнэ.				жил бүр
2	Жуулчны мэдээллийн төв: Тогтвортой ажиллагаа	Жуулчны мэдээллийн төвийн үйл ажиллагаа нь Монголд ирсэн бүхий л жуулчдын сонирхол зорилгуудад нийцсэн үйл ажиллагаа явуулбал зохино.	НАЖГ	ССАЖЯ	Маш чухал	2014 оноос
3	Жуулчны мэдээллийн төв: Өргөжүүлэх	Аялал жуулчлалын гол бүс нутгуудад салбаруудтай болох.	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2016 он гэхэд 3 аймагт
4	Судалгаа: Нэгдсэн маркетинг	Аймаг бүс нутгуудад салбаруудтай болон НҮБ, ДАЖБ-ын “Торгоны зам” төслийн гишүүн орнуудтай хамтарсан маркетинг явуулах, үр өгөөжийг бүрэн дүүрэн ашиглах.	АЖҮТ	ССАЖЯ	дунд	2016 оноос
5	Судалгаа: Сэдэвчилсэн маркетинг	Жуулчдын үзэх зүйлүүдийг сэдвүүдээр нь холбосон судалгааг нэмэгдүүлэх.	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2015
6	Үндэсний хэмжээнд хэвлэл мэдээллээр ТСАЖ-ын сурталчилгаа, аяллын сэтгэгдлийн мэдээллүүдийг нэмэгдүүлэх	Аялал жуулчлалын зах зээлд ТСАЖ-ын талаархи мэдлэгийг түгээж, бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах. Тодорхой сэдвийн хүрээнд мэдээлэл бэлтгэх.	АЖҮТ	ССАЖЯ	дунд	2014 оноос
7	Үзэсгэлэн-яармагууд: Оролцоо ба үйл ажиллагааг сайжруулах	Берлины олон улсын аялал жуулчлалын зэрэг үзэсгэлэнгийн хувиаруудыг урьдчилан мэдэж, тэдгээрт санхүүгийн ба бусад үйл ажиллагааны хариуцлагыг мэдэж урьдчилан бэлтгэл сайжирна.	АЖҮТ	ССАЖЯ, МАЖХ	чухал	2014-2015
8	Монголын элчин сайдын яамдууд: Маркетингийн багц	Элчин сайдуудын яамдуудад зориулсан маркетингийн иж бүрдлийг бий болгох.	ГХЯ	ССАЖЯ	чухал	2014-2015
9	Олон нийттэй харилцах: Төлөөлөгч нартай болох	Аялал жуулчлалын гол зах зээлүүдэд олон нийттэй харилцах төлөөлөгч нарыг дэлхий даяар	АЖҮТ	ССАЖЯ, ГХЯ	дунд	Q1, 2014 and 2015

		бий болгох; хийх ажлыг нь тодорхойлж холбогдох материалуудаар хангах.				
10	Олон улсын болон дотоодын аялагч, жуулчдын дунд санал асуулгын судалгаа явуулах	Олон улсын болон дотоодын жуулчдын байдал, эрэлт хэрэгцээ, чиг хандлагыг тодорхойлох	АЖҮТ	ССАЖЯ	чухал	Гурван жилд нэг удаа
11	Танилцуулах аялал: Боломжийн үнээр	Гол оролцогчидод (агаарийн тээврийн компаниуд, зочид буудлууд, гэр баазууд болон тур операторууд) боломжийн үнийн санал болгох зарчмаар олон улсын тур операторуудад танилцуулах аяллыг зохион байгуулах. Энэ нь (Монголд жуулчин илгээх тур операторуудын мэдлэг) бүтээгдэхүүн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	АЖҮТ	ССАЖЯ	чухал	2016

6.6.Хүний нөөцийн хөгжил, сургалт, судалгааг хөгжүүлэх

No	Үйл ажиллагаа	Хэмжүүр/Үндэслэл	Хариуцагч	Хамтран оролцогчид	Ач холбогдол	Гарах үр дүн ба хугацаа
1	Аялал жуулчлалын хүний нөөцийн хөгжлийн стратеги	Хүний нөөцийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлал, зочид буудлын салбарын үндэсний стратегийг боловсруулах	АЖҮТ	ССАЖЯ, ХЯ	чухал	2015 онд, төлөвлөгөө
2	Үнэлгээ: Сургалтын байдал ба хөтөлбөрүүд	Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын сургалтыг явуулдаг их дээд сургуулиудын одоогийн сургалтын төлөвлөгөө ба сургалтын байдалд үнэлгээ хийх.	БШУЯ	ССАЖЯ	дунд	2016 онд
3	Тур операторууд:	Тур операторуудын	АЖҮТ	ССАЖЯ, их дээд	чухал	2016 оноос

	Маркетингийн сургалтууд	маркетингийн сургалтыг зохион байгуулах.		сургуулиуд		
4	Аялалын хөтөчүүд: Техникийн сургалтууд	Аяллын хөтөчүүдийн холбоо нь өөрийн хүчин чадлаа сайжруулж хөтөчүүдэд зориулсан сургалтыг шинэчлэх.	АЖҮТ	ССАЖЯ Мэргэжлийн холбоодууд	чухал	2016 оноос
	Төрийн байгууллагууд: Зорих газрын менежментын сургалтууд	Дотоод бололцоогоо ашиглан төрийн албан хаагч ба аялал жуулчлалын шийдвэр гаргагчдын семинарыг зохион байгуулах (их сургуулиуд, гадаад дотоодын зөвлөхүүд); олон улсын гол үр дүнгүүд ба зорих газрын маркетингийн менежмент.	ССАЖЯ	АЖҮТ, АЖТХТ, их дээд сургуулиуд	дунд	2015 онд
	Мэргэжлийн боловсрол ба сургалт: Төсөл боловсруулах	Зочлох үйлчилгээний мэргэжлийн боловсролийг дэмжих. Аялал жуулчлал, зочид буудлын мэргэжлийн салбарын мэргэжлийн сургалт байгуулахад олон улсын хандивлагчдад зориулсан төслийн саналыг боловсруулах.	ССАЖЯ	АЖҮТ, АЖТХТ, их дээд сургуулиуд	дунд	2015 онд
	Аймгуудад аялал жуулчлал хариуцсан түшмэлүүд: Зорих газрын менежментын сургалтууд	Улаанбаатар хот болон аймгуудын орон нутгийн аялал жуулчлалын салбаруудыг мэргэжлийн боловсон хүчнүүдээр бэхжүүлэх. Бүтээгдэхүүн бий болгох стратеги үйл ажиллагааний төлөвлөлтийн тухай зорих газрын менежментын сургалтыг явуулах. Төр засгийн төлөвлөлтийн стратеги ба бодлого зохицуулалтын мэдээлэл, харилцааг сайжруулах.	ССАЖЯ	Орон нутгийн ИТХ, ЗДТГ	дунд	2015 онд

Ашигласан материалууд

1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
2. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3. Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгааны тайлан. Улаанбаатар хот, 2013 он.
4. Монгол орны байгалийн чухал нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан баталгаажуулах нь. 2009 оны 1 сар.
5. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн танилцуулга. 2014 он
6. Тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлалын үзүүлэх байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд. НҮБХХ-БОАЖЯ. 2011 он
7. Adventure tourism development index, 2009 report
8. Economic Contribution of Mongolia’s Tourism Markets. Discussion paper. 2012
9. EU, European Tourism Indicator System. Toolkit for Sustainable Destinations, February 2013
10. Héctor Ceballos-Lascuráin (1996). *“Tourism, ecotourism, and protected areas: the state of nature-based tourism”* IUCN Protected Areas Programme
11. Prideaux, B. and Cooper, M. (2002), Nature Corridors: A Strategy for Regional Tourism Development in Indonesia, ASEAN Journal on Hospitality and Tourism, 1(1), 23-34.
12. Report UN-WTO, Making Tourism More Sustainable, 2006
13. Tourism Cluster Competitiveness and Sustainability: Proposal for a Systematic Model to Measure the Impact of Tourism on Local Development. Sieglinde Kindle da Cunha. Joao Carlos de Cunha. BAR, v. 2, n. 2, art. 4, p. 47-62, july/dec. 2005
14. UNWTO, Tourism 2020 Vision. 2001
15. World Economic Forum. The Travel & Tourism Competitiveness Report 2013.
16. World Travel & Tourism Council. Travel & Tourism, Economic Impact 2014 WORLD.
17. World Travel & Tourism Council. Travel & Tourism, Economic Impact 2012, Mongolia

Хавсралт 1. Олон улсын жуулчны ёс зүйн журам

ОРШИЛ

Бид дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (ДАЖБ) гишүүд, дэлхийн аялал жуулчлалын үйлдвэрлэл, улс гүрэн, нутаг дэвсгэр, үйлдвэр, салбар байгууллагуудын төлөөлөгчид 1999 оны 10-р сарын 1-ний энэ өдөр Сантьяго /Чили/ хотод Ерөнхий Ассамблейн хуралд хурал цугларч,

Дэлхийн аялал жуулчлалын дүрмийн 3-т заасан зорилгыг дахин нотлон тус байгууллагын эдийн засгийн хөгжил, аялал жуулчлалыг хөгжүүлэх, улс хоорондын харилцан ойлголцол, энхтайван, цэцэглэн хөгжилт, бүх нийтийг хүндэтгэх, хүний эрх болон явдал үндэс, хүйс, хэл шашны ялгааг үлхамааран хүний үндсэн эрх чөлөөг эрхэмлэх хэрэгт НҮБ-ын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн түүний тэрүүлэх, шийдвэрлэх үүргийг гухамсарлан,

Янз бүрийн соёл, амьдралын хэв маягийг төлөөлж буй эмэгтэй, эрэгтэй хүмүүс хоорондын шууд, залхаах бус хэлбэрээр аяндаа үүсэх харилцааны ачаар аялал жуулчлал нь дэлхийн улс үндэстнүүдийн дунд энх тайван байдлыг хангах, найрамдал, харилцан ойлголцолыг бэхжүүлэх маш чухал хүчин зүйл гэдэгт гүнээ итгэн,

Хүрээлэн байгаа орчноо хамгаалах, эдийн засгаа хөгжүүлэх, ядууралтай тэмцэх энэхүү бат бэх үндсэн дээр эвсэх хандлагыг 1992 оны Рио-деЖанейрогийн "Гариг Дэлхий" дэлхийн улс гүрнүүдийн дээд хэмжээний уулзалт дээр НҮБ-ын зүгээс томъёолсны дагуу мөн үүнтэй холбоотойгоор гаргасан "Хэлэлцэх асуудал-21" баримт дээр тулгуурлан,

Соёл, шашин, эрүүл мэндийн чиглэлийн аялал жуулчлалын салбарын ажил хэрэгч үйл ажиллагааны өнгөрсөн ба ирээдүйн тасралтгүй хурдацтай өсөлт, хүлээн авч буй хийгээд илгээж буй талуудын хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгэм болон орон нутгийн нийгэмлэг, уугуул үндэстнүүд, мөн улс хоорондын харилцаа, худалдаа зэрэгт үзүүлэх түүний маш хүчтэй эерэг, сөрөг нөлөөллийг **харгалзан үзэж,**

Чөлөөт цагаа амралт, аялал жуулчлалд зориулах хүн бүрийн эрх, бүх улс үндэстнүүдийн сонголтыг хүндэтгэн. хариуцлагатай, тогтвортой, олон түмэнд хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх **зорилго тавин,**

Дэлхийн аялал жуулчлалын үйлдвэрлэлийн зах зээлийн эдийн засаг, хувийн аж ахуй эрхлэх, чөлөөт худалдаа явуулахад маш таатай мөн хүн амын амьжиргааны түвшин, ажлын байрыг нэмэгдүүлэх түүний эерэг үйлдлийг эрчимжүүлдэг нөхцөлд үйл ажиллагаа явуулваас ихийг хожино хэмээн **бат итгэн,**

Мөн зарим нэгэн тодорхой зарчим, дүрмийг мөрдснөөр хариуцлагатай, тогтвортой аялал жуулчлал нь аялал жуулчлалын үйл ажиллагааны үндэс болсон худалдааг үйлчилгээгээр зохицуулдаг улам бүр либералчлагдаж буй нөхцөлтэй зохицож чадах, мөнхүү салбарт эдийн засгийг экологитой, хүрээлэн буй орчныг хөгжилтэй, улс хоорондын солилцооны нээлттэй хэлбэрийг нийгмийн болон соёлын өвөрмөц шинжийн хамгаалалттай тус тус хослуульж болно хэмээн **гүнээ итгэн,**

Энэхүү нөхцөлд аялал жуулчлалын үйл явцад оролцогчид-үндэсний, бус нутгийн болон орон нутгийн засаг захиргаа, үйлдвэр, мэргэжлийн ассоциаци, засгийн газрын бус байгууллагууд, аялал жуулчлалын салбарын ажилтнууд, мөн хүлээн авч буй нийгэмлэгүүд, хэвлэл мэдээллийн хэн хийгээд жуулчид аялал жуулчлалын хувьд хүний болон нийгмийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд харилцан уялдаа холбоотой боловч бүгд тус тусийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрийн эрх үүргийг нь тодорхойлсноор дээрх зорилгод хүрэхэд хялбар болон хэмээн **үзэж.**

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага 1997 онд Ерөнхий Ассамблей дээр тавьсан зорилтын дагуу улсын болон хувийн зүгээс аялал жуулчлалын үйл явцад оролцогчдын хооронд жинэхэн ёсны хамтын ажиллагааг бий болгохыг зорино. Мөнхүү хамтын ажиллагааг хүлээн авч буй болон илгээж буй орнууд, тэдгээрийн аялал жуулчлалын байгууллагуудын дунд дэлгэрүүлэхийг **эрмэлзэн**.

1980 онд дэлхийн аялал жуулчлалын тухай, 1997 онд аялал жуулчлалын зүгээс нийгэмд үзүүлэх нөлөөллийн тухай Манилийн тунхаглалууд Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын эвээл дор 1985 онд Софи хотноо баталсан аялал жуулчлалын харти, аялал жуулчлалын хуулийн үзэл санааг баяжуулан **хөгжүүлэх зорилгоор**.

Дээрхи баримтуудад 21-р зууны аялал жуулчлалын үйл явцад оролцогч үндсэн оролцогчдын үйл ажиллагааны үнэтэй болох зарим зарчмуудыг нэмэх шаардлагатай хэмээн **үзэж**.

Тухайн баримтуудад нэмэлт засвар хийхдээ 1991 оны 6 сарын 24-өөс 28-нд болсон Оттовын олон улсын их хурлаар баталсан хийгээд НҮБ-ийн 1997 оны 7-р чуулганаар стратегийн хорооноос баталгаажуулсан аялал жуулчлалд хамааралтай тодорхой ангилал, ялангуяа “Жуулчин” “Аялал жуулчлал” хэмээх ойлголтуудыг **ашиглан**.

Доорх баримтуудыг иш **үндэс** болгон

- 1948 оны 12-р сарын 10-ны Хүний эрхийн талаар бүх нийтийн тунхаглал;
- 1966 оны 12-р сарын 16-ны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаархи олон улсын пакт;
- 1966 оны 12-р сарын 16-ны иргэнийболон улс төрийн эрхийн талаархи олон улсын пакт;
- 1929 онуулы 10-р сарын 12-ны агаарын тээврийн талаархи Варшавынконвенци;
- 1944 оны 12-р сарын 7-ны иргэний Агаарын тээврийн талаархиикагогийн олон улсын конвенци мөн тухайн асуудлаархи Токио, Гааг, Монреалийн конвенцууд;
- 1954 оны 6-р сарын аялал жуулчлалд үзүүлэх гаалийн татварын хөнгөлөлтийн талаархи конвенци ба хавсралт Протокол;
- 1972 оны 11-р сарын 23-ны дэлхийнсоёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци;
- 1980 оны 10-р сарын дэлхийн аялалжуулчлалын талаархи Манилийн тунхаглал;
- 1985 оны 9-р сарын 26-нд ДАЖБ -ын Ерөнхий Ассамблей дээр баталсан Аялал жуулчлалын харти, аялал жуулчлалын хууль;
- 1990 оны 1-р сарын 26-ны хүүхдийнэрхийн талаархи конвенци;
- 1991 оны 10-р сарын 4-ний жуулчдынтээвэрлэлтийг хялбарчлах, тэдний аюулгүй байдал, хамгаалалтын талаархи ДАЖБ-ийн (Буэнос-Айрес) 6 дахь удаагийн Ерөнхий Ассамблейнтогтоол;
- 1992 оны 6-р сарын 13-ны хүрээлэн бүй орчин ба хөгжлийн талаархи Рио-де Жанейрогийн тунхаглал;
- 1994 оны 4-р сарын 15-ны худалдаа,үйлчилгээний талаархи ерөнхий гэрээ;
- 1995 оны 12-р сарын 6-ны биологийн төрөл зүйлийн талаархи конвенци;
- 1995 оны 10-р сарын 22-ны ДАЖБ-ийн 11 дэх удаагийн Ерөнхий Ассамблейн (Каир) зохионбайгуулалттай секс-жуулчлалыг хориглох тогтоол;
- 1996 оны 8-р сарын 28-ны ашиг олох зорилгоор үйлдэж буй хүүхдийн секс дарангуйлалын эсрэг тэмцэх Стокгольмын тунхаглал;
- 1997 оны 5-р сарын 22-ны аялал жуулчлалын зүгээс үзүүлэх нийгмийн талын нөлөөллийн талаархи Манилийн тунхаглал;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зүгээс хамтын гэрээ,албадан болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, уугуул үндэстнүүдийн эрхийг хамгаалах ажлын байранд ялгаварлан гадуурхах байдлыг үүсгэхгүй байх талаар баталсан конвенци болон гаргасан зөвлөмжүүд;

Аялан жуулчлах эрх болон аялан жуулчлалын эрх чөлөөг тунхаглан, нээлттэй либералчлагдсан дэлхийн зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бүхий л секторт ашиг тусаа өгөх шудрага, хариуцлагатай, тогтвортой дэлхийн аялал жуулчлалын дэг журмыг тогтоох хүслээ илэрхийлэн энэхүү зорилгоор дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны хуулийг ёс төгөлдөр хүлээн зөвшөөрч байна.

ЗҮЙЛ АНГИ 1. Улс үндэстэн, нийгмүүдийн хооронд харилцан ойлголцох, хүндэтгэх уур амьсгал бий болгоход аялал жуулчлалын оруулах хувь нэмэр

ЗҮЙЛ АНГИ 2. Аялал жуулчлал нь хувь хүн болон хамт олныг төлөвшүүлэх хүчин зүйл мөн

ЗҮЙЛ АНГИ 3. Аялал жуулчлал бол тогтвортой хөгжлийн хүчин зүйл мөн

ЗҮЙЛ АНГИ 4. Аялал жуулчлал бол хүн төрөлхтөний соёлын өвийг ашиглах, түүнийг баяжуулахад хувь нэмэр оруулдаг салбар мөн

ЗҮЙЛ АНГИ 5. Аялал жуулчлал нь хүлээн авч буй орон, нийгэмлэгт тустай үйл ажиллагаа юм

ЗҮЙЛ АНГИ 6. Аялал жуулчлалын үйл явцад оролцож буй гишүүдийн үүрэг

ЗҮЙЛ АНГИ 7. Аялан жуулчлах эрх

ЗҮЙЛ АНГИ 8. Аялал жуулчлалын эрх чөлөө

ЗҮЙЛ АНГИ 9. Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид болон ажилтан нарын эрх үүрэг

ЗҮЙЛ АНГИ 10. Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрмийн зарчмын хэрэгжилт

Хавсралт 2. Аялал жуулчлалын ногоон гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрүүд

1. Ногоон Дэлхий /Green Globe/



“Ногоон Дэлхий” хөтөлбөр нь өөртөө дэлхийн 100 гаруй орныг багтаасан бөгөөд хөтөлбөрийн эрхэм зорилго нь аялал жуулчлалын салбарт зардал багатайгаар хүрээлэн буй орчныг хамгаалах, олон улсын туршлага дээр үндэслэсэн шинжээчдээр хангах явдал юм. Энэхүү хөтөлбөр нь Карибын орнуудад идэвхитэй хэрэгжиж байна.

“Ногоон Дэлхий” хөтөлбөр нь анх 1994 онд Дэлхийн Аялал жуулчлалын Зөвлөлийн ивээл дор анх байгуулагдсан ба дэлхийн томоохон хянан баталгаажуулагч SGS (Societe-Generale de Surveillance Group) байгууллагатай хамтран хэрэгжүүлж эхэлсэн байна. SGS байгууллага нь дэлхийн 140 гаруй салбар гишүүдээрээ дамжуулан орон нутагт гэрчилгээжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байна. Хөтөлбөр нь Нэгдсэн Үнлэсний Хүрээлэн буй орчны Хөтөлбөрийн/UNEP/ болон Дэлхийн Зөвлөл /Earth Council/-н үзэл баримтлалын хүрээнд АНУ-ын төрийн бус байгууллагуудын бий болгосон “Ногоон шошго”/Green seal/ хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлдэг байна.

Карибын орнуудад хөтөлбөрийн гишүүнчлэл нь Карибын Зочид буудлуудын Холбоо/СНА/-тай хамтран зочид буудлуудын хүрээлэн буй орчинд хийж буй гүйцэтгэлийг хянах зорилгоор явагддаг байна.

Гишүүнчлэлийн хураамж нь 1 сая ам.дол-ын эргэлттэй компаниас 200\$, 30 сая ам.дол-ын эргэлттэй компаниас 5000\$-н хооронд ялгаатай байдаг. Карибын Зочид буудлуудын Холбооны гишүүн бол хөтөлбөрийн хураамжийг багаар тогтоодог байна. Гэрчилгээжүүлэлтийн бүртгэлийн хураамж 200\$ бөгөөд “Ногоон Дэлхий” хөтөлбөрийн бүрэн гишүүн болоход энэ хураамж хэлбэлздэг байна. Тухайлбал хянан баталгаажуулах зардал нь 50-иас доош өрөөтэй зочид буудлуудад 700\$, 50-100 өрөөтэй зочид буудлуудад 1400\$, 100-аас дээш өрөөтэй зочид буудлуудад 3000\$-н ялгавартай тогтоогддог байна.

Гэрчилгээжүүлэлтийн үндсэн шалгуур нь Agenda 21 болон ISO14001 хүрээнд байх бөгөөд хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, ашиглах, эрчим хүчний эх үүсвэрийг үр дүнтэй ашиглах, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн хэрэглэх, нийгэм соёлыг хөгжүүлэх, байгальд ээлтэй тээврийн хэрэгсэл хэрэглэх, газар ашиглалтыг зөв зохистой төлөвлөх зэргийг багтаасан байдаг.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэд хэдэн баримт бичгүүд хэвлүүлэн гаргасан ба гишүүдэд зөвлөмж, сургалтуудыг зохион байгуулж өгдөг байна.

Гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагаа 1998 оны 6-р сараас эхэлж бүртгэж эхэлснээс хойш 37 орны 240 байгууллага хүсэлт гаргасан байна. Хөтөлбөрт хамрагдснаар ECoNETT/European Community Network for Environmental Travel and Tourism/-г байрлах “Ногоон Дэлхий” хөтөлбөрийн веб хуудсанд тавигддаг байна.

2. “Ногоон түлхүүр”/Green key/



“Ногоон түлхүүр” нь Дани улсын зочид буудал, амралтын газруудын хоолны газарт зориулагдсан дэлхийн хамгийн хатуу чанга гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөр юм.

Хөтөлбөр нь өөртөө Данийн Аялал жуулчлал, Зочид буудал, Рестораны Холбоо, Данийн Аялал жуулчлалын газар, Данийн Аялал жуулчлалын Холбоо зэргийг өөртөө багтаасан.

Хөтөлбөрийн гишүүнчлэл нь 600\$ нэмэх нь нэг өрөөний 6\$ бөгөөд орон нутгийн эрчим хүч байгаль

орчны төрийн байгууллагаар хянан баталгаажуулах төлбөр нь 400\$ байдаг байна. “Ногоон түлхүүр” хөтөлбөр нь хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, ус болон эрчим хүчний хэрэглээг багасгах, байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг хэрэглэх, хоолны цэсэнд өөх тос багатай нэр төрлийн хоол санал болгох зэрэг нийт 55 шалгуур үзүүлэлтээс багтана.

Уг хөтөлбөрт нийт хүсэлт гаргагсдын 98 хувь гэрчилгээжсэн ба Radisson зочид буудлын сүлжээг багтаасан нийт 97 гишүүнтэй тэдгээрийг англи, герман, дани хэл дээрх бүхий өөрийн веб хуудсандаа байрлуулсан байдаг.

3. Тогтвортой аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт /CST/



Энэхүү хөтөлбөр нь баруунд экотуризмын чиглэлээр маш амжилттай хэрэгжиж буй Коста Рикад үндэсний хэмжээнд засгийн газраараа дамжуулан хэрэгждэг томоохон хөтөлбөрийн нэг юм. Хөтөлбөр нь гишүүнчлэлийн хураамжгүй, хянан баталгаажуулах, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг үнэ төлбөргүйгээр Коста Рика улсын Аялал Жуулчлалын Яамны Байгалийн Нөөцийн Хэлтэст багтах Аялал жуулчлалын Институтын дор 6 сард нэг удаа явагддаг байна.

“Тогтвортой аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт нь байгаль орчинг хамгаалахтай холбоотой бодлого, үйл ажиллагааг багтаасан харилцаа, орон нутгийн нийгэм, ждийн засагт хувь нэмэр оруулахуйц хэрэглэгчидтэй харилцах харилцааг багтаасан байдаг байна.

Уг хөтөлбөр нь хүсэлт гаргах, үйл ажиллагааны ангилалтай холбоотой 2 төрлийн удирдамжийг өгдөг бөгөөд гишүүдэд төр засгийн зүгээс тодорхой дэмжлэгүүдийг үзүүлдэг байна. 1997 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн энэхүү хөтөлбөр нь одоогоор 106 зочид буудлуудыг өөртөө багтаагаад байна. Шалгуур үзүүлэлтийн 95 хувийг хангасан тохиолдолд 5 төрлийн бүч/тууз олгодог бөгөөд түүз бүхэн улсын болон олон улсын түвшинд үзэсгэлэн яармагт оролцох, сургалтанд хамрагдах зэрэг идэвхижүүлэлтийн янз бүрийн хөтөлбөрт багтдаг байна. Мөн гэрчилгээжсэн компани нь CGT-ийн веб хуудсанд зочид буудлын нэрээ байршуулдаг байна.

4. Канадын Зочид буудлуудын Холбооны “Ногоон навч” хөтөлбөр



“Ногоон навч” хөтөлбөр нь өөртөө жижиг буудлуудаас эхлүүлээд томоохон амралтын цогцолборуудыг хамруулсан 327 000 өрөө бүхий 7502 зочид буудлуудын гишүүнийг багтаасан байна. Хөтөлбөрийн гол зорилго нь гишүүдийн зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, компани нэр хүндийг өсгөх, зардал хэмнэхэд чиглэгдсэн байна.

Гишүүнчлэлийн хураамж нь хүчин чадлаас хамаараад нэг жилд 25-500\$, эхний хянан баталгаажуулах төлбөр 25-200\$, жил бүрийн баталгаажуулалт нь 20-100\$ байдаг байна.

Хөтөлбөр нь компани хүрээлэн буй орчны менежмент, эрчим хүч хэмнэлт, ус хамгаалах, хог хаягдлыг багасгах чиглэгдсэн шалгуур үзүүлэлтүүдээс багтсан бөгөөд гишүүдэд бичмэл болон видео бичлэг, гарын авлага зэргээр хангадаг байна. Хөтөлбөрт хүсэлт гаргагчдын 90 хувь нь 1-5 зэрэглэл бүхий “Ногоон навч” системээр гэрчилгээжсэн байна. “Ногоон навч” хөтөлбөрийн 1-р зэрэглэл нь эрчим хүч хэмнэлт, ус хадгалалт, хог хаягдлыг бууруулах зэрэг байгаль орчны наад захын шаардлыг хангасан тохиодолд, 2-р зэрэглэл нь компани үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл мэдрэгдэхүйц багассан тохиодолд, 3-р зэрэглэл нь хүрээлэн буй орчин гүйцэтгэх үүрэгт онцгой дэвшил гарсан тохиодолд, 4-р зэрэглэл нь хүрээлэн буй орчны гүйцэтгэлд улсдаа тэргүүлэх байр суурийг эзэлсэн нөхцөлд, харин 5-р зэрэглэл нь олон улсын түвшинд голлох байр эзэлсэн тохиодолд олгогддог байна. “Ногоон навч” хөтөлбөр нь ингэж ялгаатай зэрэглэлийн системийг тогтоосноороо компаниуд уг хөтөлбөрт хамрагдахад хялбар болж өгч байна.

5. HVS Eco Services



Eco Services хөтөлбөр нь АНУ болон Өмнөд Америкийн орнуудад зочлох үйлдвэрлэлийн салбарт хүрээлэн буй орчны зөвлөгөө өгдөг байгууллага дээр

үндэслэгдэн хийгдсэн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн гол зорилго нь үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар орлогыг нэмэгдүүлэх явдал юм. HVS International нь дэлхийн хамгийн том хувийн зочид буудлын зөвлөгөө өгдөг байгууллага юм. Хөтөлбөрийн гэрчилгээжүүлэлт нь ECOTEL-ийн хүрээнд явагддаг.

Хөтөлбөрийн гишүүнчлэлийн хураамж үнэ төлбөргүй ба хянан баталгаажуулах зардал нь компани байршил, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хүчин чадлаас хамаараад 1000-15000 \$ хооронд байдаг байна. Үйл ажиллагааны явц дунд HVS International байгууллагаар хийгдэх төлбөр нь эхний 24 сард үнэ төлбөргүй бөгөөд дахин гэрчилгээжүүлэх ажиллагаа ECOTEL-ийн шаардлагын хүрээнд 2 жил тутамд эхний зардлаас доогуур үнэлгээтэйгээр хийгдэнэ.

Уг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт нь үр дүнтэй эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент, ус хамгаалалт, дүрэм журмыг сахин биелүүлэх (АНУ-д зайлшгүй), албан хаагчдыг байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургах зэргийг багтаасан байна.

HVS International нь 1000 гаруй түншүүдтэй бөгөөд ECOTEL гэрчилгээжүүлэлтийг 34 байгууллага хүртсэн байна.

Энэхүү хөтөлбөрт хамрагдснаар зочид буудал, амралтын байгууллагуудад зориулагдсан “HVS:ECOTEL Collection”-т материал хэвлүүлэх зэргээр үс нутгийн болон олон улсын компани ажилд хамруулдаг байна. Түүнчлэн хамрагдсан зочид буудлуудын нэрсийг Америкийн Зочид буудал, Мотелийн Холбооны Лавлахад байршуулах, ECOTEL-ийн веб хуудсанд байршуулан үнэ төлбөргүйгээр мэдээлэл цацах, үйл ажиллагаа сурталчилах боломжийг олгодог байна.

6. *Touristik Union International (TUI)*



TUI нь анх 1986 онд дэлхийн томоохон тур операторуудын бүс нутгийн сонирхлыг хангах үүднээс Доминика, Куба, Мексик орнуудад байгуулагдан Антигуа, Барбадос, Гренада, Ямайка, Тобаго зэрэг Карибын зарим орнуудаар эгнээгээ өргөжүүлжээ.

TUI нь зочид буудлуудын байгаль орчинд үзүүлэх талаар нэлээдгүй туршлага хуримтлуулсан бөгөөд гол зорилго нь байгаль орчин болон түншүүдэд нийцтэй үйл ажиллагаа явуулахад оршино.

TUI нь өөртөө аялал жуулчлалын олон байгууллагуудыг өөртөө багтаасан бөгөөд одоогоор дэлхийн хэмжээнд 7 мянга гаруй зочид буудлуудыг хамраад байна.

Гишүүнчлэл нь үнэ төлбөргүй ба жил бүр байгаль орчны судалгаанд хамрагддаг байна. Зочид буудлуудын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөлийг 14 шалгуур үзүүлэлтээс багтсан шалгах хуудасаар/checklist/ үнэлэх бөгөөд эрчим хүч хэмнэлт, ус хадгалалт, хамгаалалт, хог хаягдлыг ялгах, бууруулах зэрэг асуудлыг хөндөж эдгээр шалгууруудыг биелүүлсэн тохиолдолд “Хүрээлэн буй орчинд ээлтэй зочид буудал” гэсэн өргөмжлөлийг олгодог байна. Одоогоор 195 зочид буудал энэхүү өргөмжлөлийг хүртээд байна.

Энэхүү хөтөлбөрт хамрагдснаар TUI-гийн Германд гарах брошур, хэвлэмэл материалд хэвлэн нийтлүүлэх, хэвлэлийн бага хуралд оролцуулах, веб хуудсанд мэдээлэл байршуулах зэргээр идэвхижүүлдэг байна.

	Байгалийн нөөцийг хамгаалах	Биологийн төрөл зүйлийг хамгаалах	Аялал жуулчлалын хөгжлийн нийгмийн асуудал	Аялал жуулчлалын хөгжлийн эдийн засгийн асуудал
Ногоон дэлхий - 21	😊	😊	😊	😐
Ногоон навч	😊	😊	😞	😐
Эко лабел	😊	😊	😞	😞
Тогтвортой аялал жуулчлалын гэрчилгээжүүлэлт	😊	😊	😊	😊
Экотел	😊	😊	😐	😞
NEAP	😊	😊	😊	😊
Тайлбар:	😊- Хөтөлбөрт уг асуудлыг тодорхой дурдсан 😐- Хөтөлбөрт уг асуудал товч дурдсан 😞- Хөтөлбөрт уг асуудлыг огт дурдаагүй			

Хавсралт 3. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний үзүүлэлтүүд

Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойлно.

1. ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлыг хадгалах

Тухайн ТХГН-ын аялал жуулчлалын бүс (БЦГ) болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй газрын (ДЦГ, БНГ) хэдэн хувь нь аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй байдал, жуулчны баазуудын хоорондын зайн харьцаа хадгалагдаж буй эсэх, аялал жуулчлалаас үүдэлтэй газрын хэв шинжид гарч буй өөрчлөлт зэргийг үнэлэх. Үнэлгээний баллыг дараах байдлаар тооцоолно.

+3 (эрэг нөлөө маш их): Аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөл бүхий жуулчны баазуудын хоорондын зай 5 км буюу түүнээс дээш, зугаа цэнгээний болон спорт, үзмэрийн зориулалтын барилга байгууламжууд стандартын хүрээнд баригдсан, гадаргын хэв шинжид нөлөө үзүүлээгүй. Тухайн жуулчны байгууламжийг барихад хийгдсэн БОНБҮ-тэй бодит үйл ажиллагаа бүрэн нийцэж байгаа тохиолдолд.

-3 (сөрөг нөлөө маш их): Жуулчны баазуудын хоорондын зай маш ойрхон (1 км буюу түүнээс дотогш), аялал жуулчлалын зориулалтын барилга байгууламжууд газрын гадаргын хэв шинж, өнгө үзэмжид зохицоогүй, БОНБҮ-ний дүгнэлт бодит үйл ажиллагааны хооронд зөрчил ихтэй.

Анхаарах зүйл: Газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдлын үнэлгээг байгаль хамгаалагчдын өдөр тутмын тэмдэглэлд тулгуурлан ТХГН-ын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн хийх буюу, мэргэжлийн судлаачдаар хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай.

2. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаврыг бууруулах

Аялал жуулчлалын улирлын хугацаанд тухайн ТХГН-аар нэвтэрч буй тээврийн хэрэгслийн тоо хэмжээ, давтамж, төрөл, ангилал, ашиглалтын хугацаа болон тээврийн хэрэгслүүдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, барилга байгууламж, замын төрөл, хэв шинж, зам ашиглалтын байдал.

+3 (эрэг нөлөө маш их): ТХГН-ын дотоодод тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын хэмжээ харьцангуй бага, ердийн хөсгийн хэрэглээ өндөр, зориулалтын зам харгуйг бүрэн ашигладаг, хууль бусаар зам, салаа гаргах үзэгдэл байхгүй, жуулчдын тээврийн хэрэгслүүд стандартын шаардлага хангасан.

-3 (сөрөг нөлөө маш их): Төвлөрсөн зам харгуй багатайгаас үүдэн зохион байгуулалтгүйгээр олон салаа зам гаргаж, хөрс маш ихээр сүйдсэн, ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн чанар муу, стандартын шаардлага хангахгүй, агаарт хүлэмжийн хий маш их хаядаг.

Анхаарах зүйл: Тухайн ТХГН-т нэвтрэн орж буй машин тус бүрийн мэдээлэл постод тэмдэглэгддэг байх, байгаль хамгаалагчдын өдөр тутмын тэмдэглэлд тулгуурлан ТХГН-ын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн хийх буюу, мэргэжлийн судлаачдаар хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай.

3. Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих

ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, үйлчилгээний газрууд, жуулчны баазуудын эрчим хүчний хангамжийн эх үүсвэр, хэрэглээний хэмжээний мэдээлэлд үндэслэнэ.

+3 (эерэг нөлөө маш их): Жуулчны байгууллагууд эрчим хүчний эх үүсвэрээ 100 хувь сэргээгдэх эрчим хүчээр хангасан тохиолдолд эерэг нөлөө маш ихтэй гэсэн үнэлгээг өгнө.

-3 (сөрөг нөлөө маш их): Эрчим хүчний эх үүсвэрээ дизель түлшээр хангадаг, ой модыг 100 хувь дулааны эх үүсвэр болгон ашигладаг зэргийг харгалзан энэхүү үнэлгээг өгнө.

Анхаарах зүйл: ТХГН-ын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, тухайн бүс нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран дүгнэлт гаргах.

4. Усны зохистой хэрэглээ, усны нөөц баялгийг хамгаалах

Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэж буй усны эх үүсвэр, ашиглалтын хэмжээ, чанар, бохир усыг зайлуулах буюу дахин цэвэршүүлэх технологи зэргийг үнэлэх, аялал жуулчлалаар дамжуулан усны нөөц хэмнэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор үнэлнэ.

+3 (эерэг нөлөө маш их): Жуулчны байгууллагуудын ус ашиглалтын эх үүсвэр, ус ашиглалтын үр ашигт байдал өндөр, хур борооны ус цуглуулан ахуйн зориултаар ашигладаг, бохир усыг биологийн аргаар цэвэршүүлэн дахин ашигладаг тохиолдолд эерэг нөлөө маш ихтэй гэж үнэлнэ.

-3 (сөрөг нөлөө маш их): Усны эх үүсвэрээ 100 хувь гүний усаар хангадаг, усыг үр ашигтай зарцуулах хөтөлбөр байхгүй, хаягдал болон бохир усаа зориулалтын дагууд зайлуулдаггүй газрын хөрсөнд шууд шингээх буюу ил задгай асгадаг тохиолдолд сөрөг нөлөө маш ихтэй гэж үнэлнэ.

Анхаарах зүйл: ТХГН-ын хамгаалалтын захиргааны судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, тухайн бүс нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран дүгнэлт гаргах. Байгаль хамгаалагчдын хяналт, мэдээлэл чухал ач холбогдолтой.

5. Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт

Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын хэмжээ, чанар, байгаль орчинд учруулж буй хохирлыг үнэлэх, хог хаягдлын менежментийн үр ашгийг дээшлүүлэх. Хийгдэх арга-хэрэгсэл, өндөр технологийг боловсронгуй болгох зорилгоор энэхүү шалгуурыг үнэлнэ.

+3 (зэрэг нөлөө маш их): Жуулчны байгууллагууд хог хаягдлаа бүрэн ангилан цуглуулж, технологийн дагууд хадгалж, зайлуулдаг. Дахин ашигладаг. Жуулчны баазын эзэмшил газраас гадуур үндсэн зам дагууд болон, үзмэрүүдийн орчинд хогийн цэг тодорхой, хүртээмжтэй байдаг.

-3 (сөрөг нөлөө маш их): Жуулчны байгууллагууд хог хаягдлаа стандартын дагууд ангилан ялгадаггүй, ил задгай хаядаг, гол үзмэрүүдийн дагууд болон отоглох цэгүүдийн орчимд хогийн сав, цэг тодорхойгүй, ил задгай маш ихээр хаядаг.

Анхаарах зүйл: Байгаль хамгаалагчдын мэдээлэлд үндэслэн ТХГН-ын хамгаалалтын захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үнэлнэ.

6. Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн шалгуур, хамрах хүрээ

Өрөөл-а аялагчдаас болон аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй аялал жуулчлалын бизнес эрхлэгчид, жуулчид байгалийн баялгийг хэмнэж хамгаалахад, тухайлбал ТХГН, нуга, ой, бэлчээр зэрэг байгалийн эмзэг бүс нутагт байх ан амьтан, ургамалыг хамгаалахад тусалдаг байх, байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байх.

+3 (зэрэг нөлөө маш их): Аялал жуулчлалаас үүдэлтэй ан амьтны болон ургамлын төрөл зүйлийн алдрал байхгүй, ан амьтны тоо толгой өсөж байгаа, ургамлын гарц сайн, жуулчид болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлдэг.

-3 (сөрөг нөлөө маш их): Аялал жуулчлалын үйл ажиллагаанаас үүдэлтэй ан амьтны тоо толгой ихээр хорогдсон, дуу чимээнээс ихээр дүрвэж дайждаг, ургамал нөмрөгийн алдрал, талхагдал маш их, биологийн төрөл зүйлийг хамгаалах ямар нэгэн хөтөлбөр, үйл ажиллагаа бараг байхгүй.

Анхаарах зүйл: Мэргэжлийн судлаач, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар байгаль хамгаалагчид энэхүү үзүүлэлтийг үнэлэх боломжтой бөгөөд, байгаль хамгаалагчдын орчин зүйн ажиглалтын дэвтэр хөтлөлтийг сайжруулах, үр дүнг үнэлж байх нь чухал.

Хавсралт 4. Аялал жуулчлалын кластерт суурилсан бүсчилсэн хөгжлийн концепци

